



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2025 ОНЫ 03 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-11
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	12-95

1.Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах	12-13
2.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/	14-15
3. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	15-27
4.“Гашиунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	27-68
5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/	69-87
6.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	88-95

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
03 дугаар сарын 27-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
нэгдсэн хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 126 гишүүнээс 79 гишүүн хүрэлцэн ирж, 62.7 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 00 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Ч.Анар, М.Бадамсүрэн, Д.Батбаяр, Э.Батшугар, Ж.Баярмаа, Ж.Галбадрах, Л.Гантөмөр, Ц.Даваасүрэн, Ж.Золжаргал, Д.Пүрэвдаваа, Д.Энхтүвшин;

Чөлөөтэй: Н.Номтойбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, А.Ганбаатар, М.Сарнай;

Тасалсан: С.Лүндэг;

Хоцорсон: Н.Алтаншагай-03 минут, Б.Батбаатар-07 минут, Х.Баттулга-04 минут, Г.Ганбаатар-04 минут, Д.Ганбат-02 минут, Т.Доржханд-02 минут, Б.Дэлгэрсайхан-05 минут, Б.Жавхлан-15 минут, Б.Жаргалан-10 минут, Д.Жаргалсайхан-08 минут, Ч.Лодойсамбуу-02 минут, Ц.Мөнхбат-05 минут, З.Мэндсайхан-02 минут, Н.Наранбаатар-02 минут, С.Одонтуяа-05 минут, Б.Пунсалмаа-06 минут, О.Саранчулуун-01 минут, Ц.Туваан-11 минут, Г.Тэмүүлэн-04 минут, Н.Учрал-21 минут, Д.Цогтбаатар-01 минут, Б.Чойжилсүрэн-01 минут, Б.Энхбаяр-54 минут.

Өргөн мэдүүлсэн хуулийн төслийг танилцуулах

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар нарын 9 гишүүнээс 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.01.23-ны өдөр өргөн мэдүүлсэн Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Төсвийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.01.24-ний өдөр өргөн мэдүүлсэн Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатараас 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин нарын 3 гишүүнээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын 26 гишүүнээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишигээс 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Хууль зүйн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд;

Монгол Улсын Засгийн газраас 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн “Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсныг танилцуулав.

Нэг.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2025.03.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, яаралтай хэлэлцэх эсэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу/

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Засгийн газраас үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан

хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлснийг танилцуулав.

Д.Амарбаясгалан: Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 75
Татгалзсан: 27
Бүгд: 102
73.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг гишүүдийн олонхын саналаар яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тул Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 10 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлт
/Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийг Цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, А.Ариунзаяа, Э.Бат-Амгалан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Х.Баасанжаргал нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд соёрхон

баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 41
Татгалзсан: 68
Бүгд: 109
37.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 39
Татгалзсан: 70
Бүгд: 109
35.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 36
Татгалзсан: 73
Бүгд: 109
33.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 42
Татгалзсан: 67
Бүгд: 109
38.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 10 цаг 54 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл, Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Т.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Соёлмаа, мөн газрын Хилийн хэлтсийн дарга Т.Баяржаргал, Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Артур, мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, шинжээч Г.Дөлгөөн, Төмөр замын тээврийн хэлтсийн дарга Д.Мөнхбат, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга, Уул уурхайн технологийн газрын дарга Ч.Алтанбагана нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Д.Энхтуяа, Л.Мөнхбаясгалан, Ж.Алдаржавхлан, О.Цогтгэрэл, Ж.Бат-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир, Б.Түвшин, Ц.Идэрбат, С.Зулпхар, Ө.Шижир, Г.Ганбаатар, Д.Ганбат, Г.Хосбаяр нарын тавьсан асуултад Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ, Монгол Улсын Шадар сайд Т.Доржханд, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Сангийн сайд Б.Жавхлан,

Зам, тээврийн сайд Б.Дэлгэрсайхан, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл нар хариулж, тайлбар хийв.

Д.Амарбаясгалан: Байнгын хорооны саналаар “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 87

Татгалзсан: 23

Бүгд: 110

79.1 хувь буюу нийт гишүүдийн олонхын саналаар хууль батлагдлаа.

Улсын Их Хурлын гишүүн Б.Хэрлэн, М.Энхцэцэг, Г.Дамдинням, Б.Жавхлан, Н.Учрал, Б.Найдалаа, Ц.Мөнхтуяа, П.Батчимэг, С.Ганбаатар, Г.Ганбаатар, Э.Болормаа, Ж.Батжаргал, Х.Баттулга нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул санал хураалтыг дэмжсэнээр хуралдааны тэмдэглэлд тэмдэглүүлэх санал гаргаж, 90.9 хувийн саналаар дэмжсэнд тооцов.

Уг асуудлыг 13 цаг 24 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 24 минут үргэлжилж, 13 цаг 24 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 33 минутад эхлэв.

Дөрөв.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлт /Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн О.Мөнхсайхан оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх М.Отгон, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Хууль зүйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг Цэцийн гишүүн О.Мөнхсайхан, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 01 дүгээр дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг нар танилцуулав.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, С.Бямбацогт, С.Эрдэнэболд, П.Сайнзориг, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Э.Бат-Амгалан, Ш.Бямбасүрэн, О.Номинчимэг, Г.Очирбат, Ц.Баатархүү нар үг хэлэв.

Д.Амарбаясгалан: 1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 107
Бүгд: 110
2.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 97
Бүгд: 110
11.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 101
Бүгд: 110
8.2 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө

тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 104
Бүгд: 110
5.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “ ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 105
Бүгд: 110
4.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 102
Бүгд: 110
7.3 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаал ... -оор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 103
Бүгд: 110
6.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 103
Бүгд: 110
6.4 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцов.

Уг асуудлыг 15 цаг 36 минутад хэлэлцэж дуусав.

Тав.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар 2025.03.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Байгалийн нөөцийн бодлогын хэрэгжилтийн газрын дарга Ц.Уранчимэг, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн ажлын албаны зөвлөх Д.Батмөнх нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Ч.Ариунхур, мөн газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нарангэрэл, мөн хэлтсийн зөвлөх Г.Алтанцэцэг, Байнгын хороодын ажлын албаны дарга бөгөөд Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Хатантуул, мөн албаны Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен нар танилцуулав.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Н.Алтаншагай нарын тавьсан

асуултад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд С.Одонтуяа, Улсын Их Хурлын гишүүн О.Амгаланбаатар нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт үг хэлэв.

Улсын Их Хурлын дарга Д.Амарбаясгалан Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.4-т заасны дагуу “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио ажиллах” дадлага сургалтын дохио 3 удаа дуугарсан тул 16.00 цагт “Жанжин Д.Сүхбаатар”-ын талбайд цуглахыг мэдэгдэн, хуралдааныг өндөрлүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 5 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 53 минут үргэлжилж, 126 гишүүнээс 110 гишүүн хүрэлцэн ирж, 87.3 хувийн ирцтэйгээр 16 цаг 02 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Б.БААСАНДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 00 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүдийн энэ өр өглөөний амгаланг айлтгая 79 гишүүн ирж ирц 62,7 хувьтай болсон байна. 2025 оны хаврын ээлжит чуулганы 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Өнөөдрийн хуралдаанаар нийт 6 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэнэ.

2 дугаарт “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгой нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

3 дугаарт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 01 дүгээр дүгнэлтийг хэлэлцэнэ.

4 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

5 дугаарт Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

6 дугаарт Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 29.1-д “Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.” гэж заасан байгаа.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг холбогдох Байнгын хороонд хуваарилсан талаар танилцуулъя.

1.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хууль, тогтоолын төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар нарын 9 гишүүн 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

2.Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр өргөн мэдүүлснийг Төсвийн байнгын хороонд;

3.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

4.Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

5.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

6.“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд;

7.Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд;

8.Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн Хишигдэмбэрэлийн Тэмүүжин нарын 3 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

Гишүүд дуугаа дуугаа намсгая. Суудалдаа сууя.

9.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Одонгийн Цогтгэрэл нарын 26 гишүүн 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороонд;

10.Өмгөөллийн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлснийг Хууль зүйн байнгын хороонд;

11.Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Засгийн газраас 2025 оны 3 сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Эдийн засгийн байнгын хороонд;

12.“Транс-Азийн төмөр замын сүлжээний тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр өргөн мэдүүлснийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд тус тус хуваарилсан.

Хэлэлцэх асуудалд оръё.

Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлүүлнэ.” гэж заасны дагуу Засгийн газраас 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Төслүүдийг Улсын Их Хурлын гишүүдэд танилцуулахаар тараасан байгаа.

Одоо Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулахаар байгаа.

Тэгээд ер нь Улсын Их Хурлын зүгээс Засгийн газарт энэ яаралтай горимоор хуулийн төсөл өргөн барих асуудлыг аль болох яаралтай горимоор өргөн барихгүй байх талаар бол шаардлага тавьж ажиллаж байгаа. Тэгээд зарим тохиолдолд бас эдийн засгийн нөхцөл байдалтай холбоотой, аюулгүй байдлын нөхцөл байдалтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай өргөн барих нөхцөл үүсэж байна гэдэг энэ тайлбарыг бас Засгийн газраас хийж байгаа. Гэхдээ Улсын Их Хурлын гишүүд тараасан материалтай танилцаад тухайн асуудлыг яаралтай хэлэлцэх эсэхийг санал хураалтаар шийдвэрлэдэг гэдгийг бас дахин сануулж хэлье.

Ингээд Засгийн газраас өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 73,5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар яаралтай хэлэлцэхийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тул Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд шилжүүллээ.

10.07 цаг.

Туваан сайд хаана байна. Дараачийн асуудал орох гээд байна. Учрал сайд хаана байна. Энэ “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл орохоор байна.

Одоо Улсын Их Хурал дээр нэг зарчим барьж ажиллана. Засгийн газрын хувьд Улсын Их Хурлын өмнө ажлаа хариуцаж байгаа салбарын сайд нар оруулсан асуудлаа танилцуулж, тайлбарлах, хамгаалах үүргийг хүлээнэ. Ямар нэгэн байдлаар төрийн албан хаагчид Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд онц шаардлагагүй тохиолдолд орж ирж, хариулт өгөхийг бол хязгаарлана гэж ингэж Улсын Их Хурлын зүгээс бас үзэж байгаа. Тийм учраас салбарын асуудал хариуцаж байгаа сайд нар ажлаа яг Их Хурлын өмнө хамгаалах үүрэгтэй болсон. Тухайн асуудлыг хэлэлцэхэд салбарын сайд байхгүй бол Улсын Их Хурал хэлэлцүүлэхгүй хойшлуулж байна. Энэ дээр одоо сайд нар онцгой анхаарч ажиллана. Туваан сайд байхгүй байгаа учраас энэ асуудлыг түр хойшлуулаад, дараагийн асуудал руу оръё.

3 дахь асуудал руу оръё. **Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийн талаар.**

Цэцийн гишүүн Мөнхсайхан ирсэн үү. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн 1 дүгээр дүгнэлтийг танилцуулж байна. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим. 16 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлтээ хийв.

Дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д.Алтангэрэл болон Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлт нь нийт 23 нүүр, түүний үндэслэх хэсэг нь дангаараа 17 нүүр болсон тул та бүхэнд дүгнэлтийн үндэслэх хэсгийг тогтоох хэсгийн хамт товчлон уншиж сонсгоё.

Үндэслэл:

Монгол Улсад туйлын эрхээс бусад үндсэн эрхийг хязгаарлаж болох ч уул хязгаарлалт нь эрх зүйн тодорхой байдлыг хангахад тохирсон байх, ялгаварлан

гадуурхаагүй байх зэрэг нөхцөлийг хангахыг Үндсэн хуулиар шаардах бөгөөд аль нэг нөхцөлийг нь хангаагүй бол тухайн хязгаарлалт үндсэн эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болно. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт бие даан нэр дэвшүүлэгч тухайн тойргийн 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсгийг зуруулахаар хуульчилсан нь сонгогдох эрхийг хязгаарласан байх тул энэ талаарх үндэслэл журам нь тодорхой, тохирсон ялгаварлан гадуурхаагүй байх шаардлагатай.

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар хууль дээдлэх ёс нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим төдийгүй эрх зүйт төрийг өргөн агуулгаар хамгаалдаг. Хууль дээдлэх ёс үндсэн эрхийг хуулиас гадуур хязгаарлахыг хориглох бөгөөд үндсэн эрхэд тавих хязгаарлалтыг хуульд хэлбэрийн хувьд тусгаснаар энэ зарчим хангагдахгүй. Харин түүний үндсэн журмыг тодорхой хуульчлах буюу эрх зүйн тодорхой байдлыг хангах хэрэгтэй. Бие даан нэр дэвшүүлэгчийн цуглуулсан гарын үсгийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл журмыг тодорхой хуульчлаагүй нь цаг хугацаанд баригдан хайнга хандах, нягтлан шалгахгүй орхих, улмаар иргэн сонгогдох эрхээ эдлэх эсэхийг тодорхой объектив шалгуураар бус харин эрх бүхий этгээд үзэмжээр буюу дур мэдэн шийдвэрлэх эрсдэл үүсгэж байх тул эрх зүйн тодорхой байдал алдагдсан байна.

Түүнчлэн сонгогчийн гарын үсгийг зуруулах шаардлага нь баримт бичгийн бүрдэлд хамаарах эсэх, тус шаардлагыг хангаагүй тохиолдолд бие даан нэр дэвшүүлэгч нөхөж гарын үсэг зуруулах боломж олгох эсэх, ийм боломж олговол ямар хугацаа өгөх зэрэг нь тус хуулийн зохицуулалтаас тодорхойгүй байна.

Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах шаардлагатай. Гарын үсэг зуруулах дээрх зохицуулалт нь хэт олон тооны нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх явцуу ашиг сонирхлын талбар болохоос сэргийлэх, улмаар сонгох эрхийг баталгаатай эдлүүлэх, ардчилсан сонгуулийг шударга, үр нөлөөтэй явуулахад уялдаатай байна. Учир нь бие даан нэр дэвшүүлэхэд тодорхой тооны гарын үсгийг зуруулах эсвэл барьцаа төлөвлөх зэрэг бусад шаардлага хуулиар тогтоохгүй бол хэт олон тооны нэр дэвшигч сонгуульд өрсөлдөх буюу саналын хуудаст бичигдэж, сонгогчдод төөрөгдөл үүсгэж, нэр дэвшигч нараас үр нөлөөтэй сонголт хийх саналаа өгөхөд бэрхшээл үүснэ.

Гэвч бие даан нэр дэвшигчид тавьж буй босго нь хүн ам, нийт сонгогчийн болон тухайн тойрогт бүртгэсэн сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр тохиромжгүй байгаа нь уг эрхийг хамгийн бага хязгаарласан арга хэмжээ гэж үзэхээргүй байх тул зайлшгүй байх шалгуурыг хангаагүй байна. 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг цуглуулахыг шаардаж, энэ босгыг агуулгын хувьд хангасан ч түүнд холбогдох зохицуулалтыг хэлбэрийн хувьд ялимгүй зөрчсөн тохиолдолд нэр дэвшигчээс бүртгэхээс татгалзаж, сонгогдох эрхийг хасах үндэслэл болохоор хуульчилсан нь тэнцвэртэй байх шалгуурт нийцэхгүй гэж үзнэ.

Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсанаар холбогдох иргэний сонгогдох эрхийг тухайн сонгуульд эдлүүлэхгүй байх үр дагавартай тул энэ арга хэмжээг гагцхүү адил түвшний ноцтой зөрчилд хэрэглэвэл зохино.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасан. Энэ заалт нь

хүн бүр хүн болох хувьдаа угаас тэгш гэсэн нийтлэг итгэл үнэмшилд тулгуурлаж, хүн бүрийг адилхан хүн гэж хүлээн зөвшөөрч, хүний ёсоор хүндэтгэх үүргийг төрд хүлээлгэнэ.

Тэгш байх эрхийн дагуу хуулиар болон хуулийг хэрэгжүүлэхдээ хүнд дур мэдэн ялгаатай хандахыг хориглоно. Иймээс үндсэн эрхийг эдлүүлэх хүрээнд зохих үндэслэлгүйгээр ялгаатай хэрэгжүүлэхүйц зохицуулалтыг хуульчилж болохгүй. Бие даан нэр дэвшигчид сонгогдох эрхээ эдлэхэд саад болохуйц хэт өндөр босго тогтоосон нь үндэслэлгүй байх тул тэгш байх эрх, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг зөрчсөн байна.

Мөн бие даан нэр дэвшүүлэгчийн цуглуулсан гарын үсгийг түүвэрлэн тулгах, нягтлан шалгах үндэслэл журмыг тодорхой хуульчлаагүй нь эрх зүйн адил субъектүүд болох бие даан нэр дэвшүүлэгч нарт зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандах нөхцөлийг үүсгэжээ. Ялгаатай эрх зүйн байдал бүхий бие даан нэр дэвшүүлэгч болон нам, эвслээс нэр дэвшигч нарт харилцан адилгүй шаардлагыг хуульчлах боломжтой ч энэхүү шаардлага нь зөвтгөх үндэслэлтэй байх шаардлагатай. Тухайлбал бие даан нэр дэвшүүлэгч сонгогчийн гарын үсэг зуруулахаар хуульчилж болох ч намыг бүртгүүлэхэд тавьдагтай адил тооны сонгогчийн гарын үсэг цуглуулах босгыг зөвхөн 1 иргэнээс шаардах нь илүү дарамт ачааллыг зохих үндэслэлгүйгээр үүсгэхээр байна.

Төрийг удирдах хэрэгт оролцох, сонгох, сонгогдох нь Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактаар хүлээн зөвшөөрөгдсөн үндсэн эрх юм. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүний эрхийн хорооноос 1996 онд гаргасан 25 дугаар ерөнхий тайлбарт нэр дэвшихийн тулд тодорхой тооны сонгогч, дэмжигчийн гарын үсгийг цуглуулах шаардлага тавьдаг бол уг шаардлага нь үндэслэл бүхий байх бөгөөд нэр дэвшихэд саад болох ёсгүй гэжээ.

Гэтэл Улсын Их Хурлын сонгуульд бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулахаар хуульчилсан нь Монгол Улсын хүн ам, нийт сонгогчийн болон тухайн тойргийн сонгогчийн тоотой харьцуулахад хэт өндөр босго байхын зэрэгцээ ийнхүү гарын үсэг зуруулах хугацаа богино, маягтад нарийн мэдээллийг тодорхой бичихийг шаардсан, гарын үсгийг 7 хоногийн хугацаанд түүвэрлэн шалгахаар заасан, гарын үсгийн босгыг агуулгын хувьд хангасан ч холбогдох зохицуулалтыг ялимгүй зөрчсөн гэж нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах боломжтой. Алдаа засах боломжит хугацааг хуулиар олгосон эсэх нь эргэлзээтэй, холбогдох үндэслэл, журам нь тодорхойгүй байх тул ерөнхий тайлбарт заасан үндэслэл бүхий бөгөөд нэр дэвшихэд саад болохгүй байх зарчимд нийцээгүй байна.

Иймээс бие даан нэр дэвшүүлэгч 801-ээс доошгүй сонгогчийн гарын үсэг зуруулах зохицуулалт нь Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт харшилсан байна. Олон улсын сайн туршлагын дагуу гарын үсгийг нягтлан шалгах ажиллагаанд тодорхой хэм хэмжээгээр зохицуулах хэрэгтэй. Дэмжиж байгаа сонгогчийн гарын үсгийн тоо дутуу байгааг хангалттай баримтаар тогтоох, ялимгүй зөрчлийг үндэслэл болгож нэр дэвшигчээр бүртгэхээс шууд татгалзахгүй байх, мэдээллийн алдааг засах боломжит хугацааг бие даан нэр дэвшүүлэгчид олгох зэргээр зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон зохицуулалтыг хийх учиртай. Нягтлан шалгах ажиллагаа нь зарчмын хувьд бүх гарын үсгийг хамрахыг зөвлөдөг. Иймээс бүх гарын үсгийг нягтлан шалгах зарчмыг хуульчлах, богино хугацааг

хуулиар тогтоох тохиолдолд тухайн хугацаанд нягтлан шалгаж болохуйц тооны гарын үсгийг бие даан нэр дэвшүүлэгчээс хуулиар шаардах нь зүйтэй. Хэрэв гарын үсгийг түүвэрлэн тулгах аргыг хэрэглэх тохиолдолд энэ талаарх үндэслэл журмыг тодорхой хуульчлах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааг журамласан шинжтэй, хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой асуудал байх тул тус хэсэг нь Үндсэн хуулийн зөрчлийн шинжгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон. Иймд Үндсэн хуулийн цэцийн энэ дүгнэлт гарсан цагаасаа хойш үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “бие даан нэр дэвшигч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнээс хоёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” 2 дахь хэсэгт “Хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “Төрийн байгууллагад сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

Гурав. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчийн гарын үсэг зуруулна.” гэж заасныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Тав. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Ц.Цолмон, Б.Болдбаатар.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг танилцуулсан болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хүний сонгогдох үндсэн эрхийг зөрчсөн гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийн үндэслэл хэсэгт уг харилцааг илүү боловсронгуй болгох нь зүйтэй талаар хууль тогтоогчид хандсан агуулга байгаа эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Э.Бат-Амгалан уг дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авсан тохиолдолд Сонгуулийн тухай хуульд заасан бусад уялдаа холбоо бүхий зохицуулалтуудын үр дагаврын талаар, Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн дагуу 801 гэсэн босгыг багасгах эсвэл байхгүй болох тохиолдолд бие даан нэр дэвшигч нь ямар шалгууртай байвал зохих талаар, мөн өмнөх сонгуулийн үр дүнгээр 801 гэсэн босгын шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр хасагдсан нэр дэвшигчдийн хувьд нөхцөл байдал хэрхэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх нь зүйтэй бөгөөд 801 гэсэн босго нь бусад улс орны туршлагатай харьцуулахад хэт өндөр байгаа талаар, бие даан нэр дэвшигчид тавьдаг шалгуур нь улс төрийн намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийн шалгууртай ижил тэнцүү байх нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр цэцийн дүгнэлтэд дурдсанаар 801 гарын үсэг гэдэг босго нь хүн ам, сонгогчдын тоо болон дэлхийн ардчилсан бусад орнуудтай харьцуулахад өндөр байгаа нь үндэслэлтэй талаар, мөн 21 хоногийн хугацаанд 801 хүний гарын үсэг цуглуулахад хянуулах хугацаа 7 хоног бөгөөд энэ хугацаанд нэмж гарын үсэг цуглуулах ажил үргэлжлэх эсэх талаар хуульд тодорхой заагаагүйгээс уг заалтыг сонгуулийн байгууллага дур зоргоор тайлбарлаж, ялгамжтай байдлаар хэрэглэх боломж байгаа талаар, мөн хүний үндсэн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах ёстой бөгөөд Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, холбогдох хуулийн заалтыг боловсронгуй болгох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн

зөвшөөрч, 801 гарын үсэг гэсэн босгыг бууруулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, бие даан нэр дэвшигч болон улс төрийн намаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчид тавих босгыг ижил тэгш байхаар зохицуулах нь зүйтэй талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “бие даан нэр дэвшигч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэснийг, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг, 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг үзэл бодлоор ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцэх талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ. Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Цэндийн Сандаг-Очир гишүүн танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2, 31.3, 31.4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1, 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг 2025 оны 2 дугаар сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир Миний бие Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийн агуулгыг танилцуулсан болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “бие даан нэр дэвшигч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил

үйлчилнэ.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” 2 дахь хэсэгт “хүнийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. 5 гишүүнээр тасаллаа. Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууя.

П.Сайнзориг: Би үг хэлнэ ээ. Энэ цэцийн шийдвэрийг бас сонгогч иргэдийнхээ эрх ашгийг бодож, анхаарч үзээсэй гэж хүсэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол би энэ цэцийн шийдвэрийг хүлээж аваагүй Байнгын хорооны саналыг дэмжиж байгаа буюу энэ цэцийн шийдвэрийг хүлээж авах шаардлагагүй гэж үзэж байгаа юм.

1 дүгээрт энэ сонгогч өөрөө ямар хүнийг сонгосон, тэр хүн энэ 4 жил ямар ажил хийсэн гэдэг зүйлийг мэдээлэлтэй танилцаж байж, дараагийн сонголтоо хийх ёстой. Түүнээс биш сонгуулийн жил эхэлсэн гээд огтоосоо иргэд сонгогчтой хууль тогтоогч буюу Улсын Их Хурлын гишүүд уулзаж болохгүй гэж ерөөсөө хязгаарлах нь бас шударга бус. Уучлаарай. Би өөр асуудалтай андуурсан байна.

Д.Амарбаясгалан: Өөр асуудалтай андуурсан байна. Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Гишүүдийнхээ өглөөний амар амгаланг айлтгая. Тэгэхээр 1992 онд Үндсэн хуулиа баталж, энэ сонгуулийн тогтолцоог бид нэг мөр ойлгож явцгаасан эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн. Тэгэхээр энэ бие даан нэр дэвшигчийн тодорхой сонгогчийн квот, суурь тавьчхаад байгаа нь хэдэн оны Сонгуулийн хуулиас эхэлж орсон юм бэ. Би бол энэ ер нь нэлээн тийм тогтчихсон ойлголт болсон гэж ингэж л ойлгоод байдаг. Аливаа сонгууль бол хүн нэр дэвших хүсэл байж болно. Гэхдээ сонголтын үр дүнгээр гарч ирдэг. Тийм учраас тэр төрийн байгууллагад сонгогдох эрх хаагдчихаад байгаа гэж би бол ерөөсөө олж харахгүй байгаа. Одоо бид нарын өнгөрсөн жилийн явсан сонгууль чинь хамгийн багадаа 45 мянган хүний санал авч байж Их Хурлын гишүүнд сонгогдоцгоосон бараг. Тэгэхээр зэрэг наадах чинь 801 хүний саналын асуудал бол бараг үндсэндээ сонгуулийн компанит ажилд нь итгэл үнэмшилтэй оролцох болсон нь тогтож байгаа үйл явц байхгүй юу. Тийм хэмжээний хүлээн зөвшөөрөлт явж байж, сая тэр бие даан нэр дэвшигч өөрөө хариуцлагын асуудал нь давхар гарч ирэх ёстой юм. Энэ бол хүний сонгогдох эрхэд нөлөөлөөд байгаа зүйл биш гэж би бол ингэж хараад байгаа.

Тийм учраас энэ тал дээр яг хэдэн оны Сонгуулийн хуулиас энэ заалт орсон, үүнээс болоод ямар хүний эрх яаж зөрчигдчихөөд байгаа юм. Нэр дэвших гээд байгаа хүмүүсийн. Үүнийг тодорхой дүгнэлт гаргасан байгууллага тайлбар өгнө үү гэж хэлмээр байна.

Эцэст нь бол би энэ эрх зүйт төрийг төлөвшүүлээд бас хариуцлагатай бас энэ иргэдийг төлөөлөх чадвар чадамжаа нэмэгдүүлэх, төрийн эрх барих дээд байгууллагынхаа чадамжийг сайжруулах чиглэлээр барьж байгаа бодлогоо хангана гэвэл энэ тогтсон ойлголт эрх зүйн зохицуулалтаа ер нь хадгалж үлдэх нь бидэнд зөв байх. Тийм учраас цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй л гэсэн ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Сандаг-Очир гишүүн хариулах уу. Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Уг нь бол Цэцээс асууж байх шиг байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бас хариулъя. Батжаргал гишүүний асуултад хариулахад ер нь бол 1992 оноос хойш парламентын 9 удаагийн сонгуульд л энэ бие даан нэр дэвшигч нар 801-ээс доошгүй иргэний, тойргийн сонгогчдын гарын үсгийг цуглуулна гэсэн энэ хуулийн заалт хэрэгжсэн. 9 удаагийн парламентын сонгуульд. Энэ удаагийн сонгуульд бие дааж нэр дэвшээд, нэр дэвших эрхээ хязгаарлуулсан нэр бүхий нэр дэвшигч нар энэ Үндсэн хуулийн цэцэд дээрх асуудлаар гомдол гаргасан байна. 2016 онд 4 хүн, 2020 оны сонгуульд 14 хүн, 2024 оны сонгуульд бас 3 орчим хүн, нийтдээ сүүлийн 3 удаагийн парламентын сонгуульд 21 хүн бие даан нэр дэвшигч нар сонгуулийн тойргийн хорооны баталсан маягтад заасан 801-ээс доошгүй гарын үсэг цуглуулах асуудлаас болж, сонгуульд оролцож чадаагүй гэсэн ийм тоо баримт байна.

Тийм учраас цэцийн дүгнэлтийн гол агуулга бол шалгуур тавьж байгаа нь буруу биш. Гэхдээ тухайн тойргийн сонгогчдын тоотой харьцуулахад босго шалгуур нь өндөр байна 1-д.

2-т тэр бүртгэсэн бүртгэл, маягтыг долоохон хоногийн хугацаанд сонгуулийн хорооны ажилтнууд түүврийн аргаар ингэж хэлбэр төдий асуудалд хандаж, хүний сонгогдох эрхийг хязгаарлаж ингэж байна. Журмаар зохицуулагдаж байна. Хуульчлагдаагүй байна, тодорхой бус байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн гол агуулга нь ийм байгаа. Тэгэхээр Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хүлээж авна гэдэг нь бие даан нэр дэвшигч нарт огт шалгуур босго тавихгүй гэсэн үг биш шүү. Өндөр байна.

Улс төрийн намыг байгуулахад 801-ээс доошгүй иргэний гарын үсгийг цуглуулахтай адилтгаж ингэж бие даан нэр дэвшигчид тухайн тойргийн сонгогчдын гарын үсэг цуглуулах асуудал бол шалгуур шаардлага нь өндөр байна гэсэн цэцийн дүгнэлтийн гол агуулга нь энэ л байгаа юм.

Д.Амарбаясгалан: Сандаг-Очир гишүүн энэ ийм учиртай шүү. Одоо Улсын Их Хурлын гишүүд Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууна гэж байгаа юм. Тийм учраас энд цэц хариулахгүй. Цэцийн дүгнэлтийг хэлэлцэж санал, дүгнэлт боловсруулсан Байнгын хороод гишүүдийн асуултад шууд хариулт өгнө.

2 дугаарт бид санал хураалт явуулахдаа байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийн дагуу санал хураалт явагдах учраас Байнгын хороодыг төлөөлж байгаа гишүүд асуултад тодорхой товч, тодорхой хариулж баймаар байна гэдгийг бас хэлье. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Байнгын хорооны дүгнэлттэй холбоотой 2 чиглэлийн асуулт асууя. 1 дэх нь болохлоор 1992 оноос хойш бие даан нэр дэвшигчдэд 801 хүний гарын үсгийн тоо тавьсан нь 1992 онд 1,5 сая хүн амтай байсан сонгогчийн тоо тэр хэрээрээ бага байсан байж таарна. Одоо 3,5 сая хүн болсон байгаа учраас хүний тооны хувьд бол нэмэгдсэн үү гэхээс биш багадаагүй. 801 тухайн үед энэ шалгуурыг бодож байсан, тухайн үед энэ үнэлгээ хийж байсан хүмүүсийн тавьсан зарчим нь юу байсан юм бол гэдгийгээ мэдэж байж, бид нар өнөөдөр бас яг энэ 801 их байна уу, бага байна уу гэдгийгээ харах нь зүйтэй байх.

2 дахь нь болохлоор улс төрийн нам байгуулахтай нэгэн адил 801-ийг тавьж байгаа нь нөгөө талд парламентын засаглалтай ардчилсан улс оронд улс төрийн намуудын оролцоо хөгжил машид чухал. Ийм учраас улс төрийн сонгуульд оролцож байгаа улс төрийн намуудад тавигдаж байгаа шаардлагатай нэгэн адил 801 хүний гарын үсэгтэй, мөрийн хөтөлбөртэй гээд яг 1 хүн гэдгээсээ илүүтэй нэр дэвшиж байгаа субъект гэдэг агуулгаар улс төрийн намтай адилтгаж, тухайн үедээ үзсэн болов уу. 801 хүний гарын үсэг цуглуулах улс төрийн нам байгуулах гээд ядраад, зовоод чадахгүй байсан хүн 1 талд нь хэсэг бүлэг хүмүүс байхад тэдгээрийн эрх ашгийг эсрэгээрээ хөндөөд бие даагчдад илүү давуу байдал үүсгэсэн хэрэг Цэц дээр дараа нь дахиад очих вий дээ. Нөгөө талаас нь харах юм бол өөр өнцөг байгаа юм бус уу. Нам байгуулахад тэгвэл 801 хүний гарын үсэг шаардаж байгаа нь бас Цэцийн шийдвэрээр хууль зөрчсөн болсон ийм агуулга гарах вий дээ. Ер нь аливаа улс төрийн нам байгуулах, эсвэл бие даан нэр дэвших хэдэн хүний гарын үсэг байвал зохимжтой юм бэ гэдэг асуултад бас хариултыг нь бэлдэж өгсөн нь дээр бол байгаагүй юу. Жишээлбэл энэ цэцийн шийдвэрийг хүлээгээд авчихаар гарын үсгийн босго бүр огт авахгүй байх нь зүйтэй. Ер нь дахиж энэ асуудлыг хөндөж болохгүй гэсэн ийм шийдвэр гарчих вий дээ. Энэ дээр 1 дүгээрт улс төрийн нам байгуулахтай холбоотой яаж уялдаж байгаа юм. 801 биш бол тэгвэл хэд юм бэ гэдэг асуултад хариулж өгнө үү.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир: Ойлголоо. Их Хурлын даргын хэлж байгааг ойлгож байгаа. Гэхдээ гишүүдийн асууж байгаа асуулт бол итгэмжилсэн төлөөлөгчийн хувьд Улсын Их Хурлаас очсон хуулиа хамгаалж, итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцож байгаа шүү дээ. Тэгээд зөрчөөгүй гэдэг үндэслэлээр тайлбар хийж байгаа юм. Та бүхний асууж байгаа асуултууд бол шийдвэр гаргасан Цэцийн зүгээс энэ асуудлыг юу гэж үзсэн бэ гэдэг үүднээс асуулт асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр уг нь бол асуултын хариултад бол уг нь шийдвэр гаргасан субъектийн талаас энэ асуудлыг ингэж үзсэн юм гэж хариулах нь уг нь бол зохимжтой байгаа юм.

Тэгээд Дэгийн тухай хуулиар бол мэдээж Байнгын хороо, итгэмжилсэн төлөөлөгч хариулах ёстой байх. Тэгэхдээ Ариунзаяа гишүүний асуултад хэлэхэд бол яг 801 бол өндөр байна. Тэгээд одоо зохимжтой нь хэд юм бэ гэдэг асуудал байна уу, үгүй юу гэж байх шиг байна. Цэц үзэхдээ бол 801-ийг шаардлага, шалгуур нь, босго нь өндөр байна. Гэхдээ яг зохимжтой тоо нь тэд юм гэсэн дүгнэлтдээ бол тийм хариулт бол хэлээгүй. Тийм дүгнэлтэд оруулаагүй. Гэхдээ ямар ч гэсэн улс төрийн намыг байгуулахад 801 иргэний гарын үсэг цуглуулахтай адилхан бие даагч нарын хувьд бол тухайн тойргийн сонгогчдын 801 бол бас адилтгаж, шууд ингээд улс төрийн намтай адилтгаад үзчихэж байгаа нь ганц бие дааж байгаа хүний хувьд бол зөвхөн тухайн тойргийн сонгогчдоос 801 хүнийг гарын үсэг цуглуулна гэдэг бол бас амаргүй юм. 21 хоногийн хугацаанд ингэж гарын үсэг цуглуулаад, тэгээд түүнийг

нь сонгуулийн хороо долоохон хоногийн хугацаанд түүврийн аргаар асуудалд субъектив байдлаар асуудалд хандаж байна. Тийм учраас энэ нь өөрөө эргээд адил тэгш байх Үндсэн хуулийн зарчмыг зөрчиж байна л гэдэг гол агуулга Үндсэн хуулийн цэцийн маргаан дээр яригдсан.

Д.Амарбаясгалан: Хууль зүйн байнгын хорооны дарга Дамдины Цогтбаатар нэмж хариулъя.

Д.Цогтбаатар: Ариунзаяа гишүүний асууж байгаа асуулт бол яг зөв асуулт. Тэгэхдээ энэ чинь нөгөө 801-ийг энэ их байна гэдэг дүгнэлт гараад, бид нар энэ дээр нь л ажилласан болохоос биш одоо хэд байх нь зохилтой вэ гэдэг чинь бид хүлээгээд авчихсаны дараа хуульд өөрчлөлт оруулахаас өөр үггүй болох нь байна шүү дээ. Тэгэхэд энэ бол нарийн яригдана. Зүгээр тухайн үед Байнгын хороо дээрээ нэг зүйлийг хэлсэн. Ер нь дараагийн хуулиа боловсруулахдаа нэг юмыг бодох хэрэгтэй байна. Зохистой тэгвэл түвшин нь хэд юм бэ гэдгийг бодох хэрэгтэй. Нэг хувилбар нь бол би жишээлбэл юу гэж үзэж байгаа гэхээр Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийн жилээ өөрөө шийддэг байг. Гэхдээ тэрийг баримжаа нь юу байх ёстой вэ гэхээр хамгийн бага, одоо жишээлбэл Бага хурлын гишүүдийн тоотой нам, тэрний гишүүн дэвшүүлэх босго хэд байна, түүгээр нь тогтоож байя, тэгж болно гэж санал хэлж байсан.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууя.

Х.Баасанжаргал: Би асуулт гэхээс илүү энэ Цэцийн дүгнэлтийг дэмжиж, манай Байнгын хороо шийдвэр гаргасан. Гишүүдийг ч гэсэн бас энэ цэцийн дүгнэлтийг хүлээн авч шийдвэр гаргаасай гэж хүсэж, энэ үгийг бас хэлье. Цэцийн хувьд бол хэт өндөр байна гэдгийг бол хэд хэдэн улс орны яг энэ бие даагчид тавигддаг шалгуурыг харьцуулж гаргаж, энэ дүгнэлтийг гаргасан. Манай улс шиг ингэж 800 гэдэг ийм өндөр босготой улс орны тоо бол энэ Цэцийн дүгнэлтэд бол дурдаагүй. Тухайлбал Герман улсад бол 200 хүний гарын үсэг цуглуулдаг. 84 сая хүн амтай орон. Солонгос улсад 300-500 тооны сонгогчийн гарын үсгийг цуглуулдаг. Их Британид бол 10 хүний гарын үсэг цуглуулдаг гэх мэтээр ингээд тоо бол харьцангуй цөөхөн байгаа. Тэгээд бусад улс орнуудын тоог харахаар дунджаас 100-200 орчим хүний гарын үсэг цуглуулж, бие даах эрхээ авч байгаа юм. Тэгэхээр энэ яалт ч үгүй бусад улс оронтой харьцуулахад манай улс бол хэт өндөр босго шаардлага тавигдаж байгаа нь 1 дүгээрт харагдаж байгаа юм.

2 дугаарт гэвэл яг энэ улс төрийн намд тавигддагтай адилхан шалгуурыг хувь хүнд өөрөө тавиад байгаа нь өөрөө тэгш эрхийн зарчмыг зөрчөөд байна л гээд хүний эрхийн үүднээсээ дүгнэлт гаргаад байгаа юм. Тэгэхээр манай гишүүд бас энэ талаас нь харах ёстой гэж би хувьдаа бодож байна.

3 дугаар үндэслэл нь тухайн 801 гэдэг гарын үсгийг Сонгуулийн ерөнхий хороо субъектив байдлаар шалгаад, таныг бүртгэж авахгүй, таны гарын үсэг хангалттай шаардлага хангахгүй байна гэж үзээд, буцаах юм бол дахиж тэр алдааг залруулах хугацааг ерөөсөө хүнд өгдөггүй. Ямар ч тийм хоног хугацаа байхгүй. Ямар ч процесс байхгүй байгаа. Аль хэдийн сонгуулийн процессууд эхлээд явчихдаг. Тэгэхээр энэ нь бие даан нэр дэвших хүнд бол хэтэрхий ийм субъектив байдлаар хууль өөрөө тэгш бус хандаж байгаа гэдэг ийм хууль ёсны зорилгод бол нийцэхгүй байна гэдэг ийм үндэслэлийг Үндсэн хуулийн цэц бол хангалттай үндэслэл дээрээ бичсэн учраас манай Хууль зүйн байнгын хороо бол дэмжсэн юм гэдгийг хэлэх гэсэн юм.

Ингээд та бүхнийг бас энэ Цэцийн дүгнэлтийг хүлээн авч, саналаа өгөөсэй гэж хүсье.

Д.Амарбаясгалан: Энхтайваны Бат-Амгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Э.БАТ-Амгалан: Улсын Их Хурлын гишүүдийнхээ энэ өглөөний мэндийг хүргэе. Цэцийн 01 дүгээр дүгнэлттэй танилцсан, уншсан. Миний хувьд бол Цэцийн дүгнэлтийг хүлээн авах боломжгүй гэж ингэж харж байгаа. Улсын Их Хурлын гишүүд маань бас нэг зүйлийг сайн ойлгох нь зүйтэй гэж бодож байгаа.

Ерөөсөө нөгөө тэгш эрхийн зарчим энд алдагдаад байна гээд ингээд заачихсан. Хэрвээ босгогүй болчихвол энэ нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн ийм хүмүүс нэр дэвшихээс гадна энэ Улсын Их Хурлын буюу орон нутгийн сонгуулиуд бүгд бас будилаантах ийм нөхцөл байдал үүснэ. Яагаад гэвэл хэн дуртай нь хэн нэг нэр дээр давхар ижилхэн нэртэй хүнийг нэр дэвшүүлэхээс эхлүүлээд энэ өнгөрсөн 9 удаагийн парламентын сонгууль яг энэ босготой тогтсон энэ ойлголттой байх үед бол яг энэ заалт дээр ямар нэгэн алдаа гараагүйгээр өнөөдөр 9 удаагийн сонгуулийг Монгол Улсын парламентын засаглалтай ардчилсан улс асуудал гаргаагүйгээр өнөөдөр шийдээд ирчихсэн юм. Ийм байдалтай байгаа.

Тэгээд дүгнэлт дээр ойлгомжгүй нэг зүйл байгаад байгаа юм. Тэр нь юу вэ гэвэл яг одоо 801-ийг бүүр аваад хаячхаж байгаа юм уу, аль эсвэл багасгаж хөдөлгөх гэж байгаа юм уу гэдэг ийм асуудал. Тэгэхээр аливаа улс төрийн сонгуульд нэр дэвшиж байгаа хүн тодорхой хэмжээнд нийгэмдээ хүлээн зөвшөөрөгдсөн, 800 хүний дэмжлэг авчихсан ийм хүн л нэр дэвших нь зүйтэй юм болов уу гэж 1 дүгээрт бол ойлгож байгаа.

2 дугаарт Улсын Их Хурлын сонгуулиас гадна орон нутгийн сонгуулиуд дээр бас энэ босго тоо байгаа шүү дээ. 201 гэдгээр. Тэгэхлээр энэ Улсын Их Хурлаас гадна орон нутгийн бүх шатын сонгуулиуд энэ бидний 9 удаагийн парламентын сонгуульд орсон энэ зүйл заалтаар өнөөдөр ямар нэгэн асуудал үүсэхгүйгээр яваад ирчихсэн байгаа.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүддээ бас хэлэхэд энэ цэцийн дүгнэлтийг эргээд нөгөө талаасаа харахад хэрвээ хүлээж аваад энэ босгогүй болчих юм бол энэ Улсын Их Хуралд нэр дэвшиж байгаа намуудын төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүд, нэр дэвшиж байгаа нөхдүүд намынхаа төлөөллийн байгууллагуудаас бас санал авч, дэмжлэг авч орж ирдэг гэдгийг санах ёстой. Жишээ нь АН, МАН аль аль нь 200 гаруй намын гишүүнтэй. Тэдний төлөөллийн байгууллага болсон Бага хурлаараа нэр дэвших, үгүйгээ тэндээ шүүлгэж орж ирж байгаа шүү дээ. Тэгээд ийм саналтай байна.

Асуулт нь болохлоор яг энэ цэцийн дүгнэлт дээр ер нь бүр 0 болгож явах юм уу, зохистой тоогоор явах юм уу гэдэг нь бас ойлгомжгүй орж ирсэн. Тэгэхээр бас итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс энэ асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн хариулт өгье.

Ц.Сандаг-Очир Бат-Амгалан гишүүний асуултад хариулъя. Цэц 801-ийг босго өндөр байна гэсэн боловч яг хэд байвал зохимжтой вэ гэсэн тийм асуудал бол дүгнэлтэд байхгүй байгаа. Дүгнэлтэд байхгүй. Нөгөө талаар цуглуулаад ирсэн 801

гарын үсгийг нягталж байгаа тэр процедур тодорхойгүй байна. Хувь хүний үзэмжээр шийдэгдэж байна. Тухайн сонгуулийн хорооны 1 албан тушаалтны 801 хүний гарын үсгийг долоохон хоногийн хугацаанд улсын хэмжээнд хэд байдаг юм, хэдэн бие даагч нар нэр дэвшдэг юм. Энэ олон хүмүүсийн асуудлыг долоохон хоногийн хугацаанд нягталж байгаа асуудал нь цаг хугацааны хувьд ч гэсэн бололцоо боломжгүй. Ингээд субъектив байдлаар хүний сонгогдох эрхэд халдаж, тэгш эрхийн зарчмыг зөрчиж, ингэж асуудалд хандаж байгаа нь өөрөө Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчиж байна гэсэн ийм л агуулга байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар хэрвээ Улсын Их Хурал цэцийн дүгнэлтийг хүлээж авлаа гэвэл дараа нь сонгуулийнхаа хуульд өөрчлөлт оруулж, тодорхой тойргийн сонгогчдын боломжит харьцуулсан тоог гаргаж ирж асуудалд хандах ийм асуудал үүсэж байгаа юм. Тэрнээс биш огт шалгуургүй болго гэсэн асуудал Цэцийн дүгнэлтэд байхгүй шүү гэдгийг манай гишүүд анхаараарай.

Д.Амарбаясгалан: Энхтайваны Бат-Амгалан гишүүн тодруулж асууя.

Э.Бат-Амгалан: Энэ цэцийн дүгнэлт дээр бас олон улсын жишиг юунууд тавьсан байна лээ л дээ. Жишээ нь бүгд найрамдах Албани Улс гэхэд 2,7 сая иргэнтэй, 1 хувиас доошгүй иргэдийн гарын үсэг, санал цуглуулж байж босго оноо тавьчихсан. Тэр нь болохоор 27 мянга гэдэг тоо гарч байгаа юм. Тэгэхээр ер нь зүгээр олон улсын жишигт энэ тоо, тэр босго оноо бол ерөөсөө тийм хамаагүй юм байна лээ. Зарим газруудад нь бол 5, 6 хүний гарын үсэг аваад ороод ирэх ийм бас боломжууд харагдаж байгаа юм. Гэхдээ энэ Улсын Их Хурлын сонгууль, орон нутгийн сонгуулиудад нэр дэвших гэж байгаа нөхдүүд одоо сая Сандаг-Очир гишүүн хэлж байна. Долоохон хоног гэдэг нь бага гээд байгаа юм. Энэ Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвших гэж байгаа нөхдүүд маань 7 байтугай бүтэн жилийн өмнөөс нэр дэвшинэ гэдгээ ойлгож, мэдэрч, бэлдэж явах ийм цаг хугацаанууд бас байгаа шүү дээ. Тэр 7 хоногт .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Байнгын хороодын саналаар санал хураалт явуулна. Санал хураалт.

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улсын олон улсын гэрээнд соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомж нэгэн адил үйлчилнэ.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 41 гишүүн буюу 37,6 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье

гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна аа. Санал хураалт. 39 гишүүн буюу 35,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... үзэл бодол ... -оор ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 36 гишүүн буюу 33 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Бие даан нэр дэвшүүлэгч нь Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан маягтад тухайн сонгуулийн тойргийн 801-ээс доошгүй тооны сонгогчдын гарын үсгийг зуруулна.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 42 гишүүн буюу 38,5 хувиар санал дэмжигдсэнгүй. Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа.

Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг манай хуулийн газар ... ингээд олонх нь дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 1 дүгээр дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүдэд талархал дэвшүүлье.

10.54 цаг.

Дараагийн асуудалд оръё.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна. Индэрт урьж байна.

Ц.Туваан: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 тогтоолоор “Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээ”-г баталсан. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах, Хятадын талтай хэлэлцэн тохиролцох үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 28 дугаар захирамжаар байгуулсан.

Түүнчлэн Ерөнхий сайдын 2024 оны 59 дүгээр захирамжаар уг ажлын хэсгийн ахлагчаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд миний биеийг, дэд ахлагчаар Зам, тээврийн сайд Дэлгэрсайханыг тус тус томилсон.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн нэгдсэн чуулганаар “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээ”-ний талаар хэлэлцэж, Монгол Улсын Засгийн газар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээр”-ийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай” 58 дугаар тогтоолыг баталсан.

Мөн олон улсын гэрээний тухай хуулийн 9.1-д заасны дагуу 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээрийн төслийг хэлэлцүүлж, холбогдох Улсын Их Хурлын Байнгын хороогоор зөвшилцөх шийдвэрийг гаргасан. Олон улсын гэрээний тухай хуулийн 9.4-д заасны дагуу Засгийн газрын шийдвэрийг 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор тус тус хэлэлцүүлэн дэмжиж, хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгох шийдвэрийг гаргасан.

Улмаар Улсын Их Хурлын 58 дугаар тогтоол болон Улсын Их Хурлын гишүүдийн гаргасан саналын дагуу Хятадын талтай хэлэлцээ хийж, “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-т Монгол Улсын Ерөнхий сайдын Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлалын үеэр 2025 оны 2 сарын 14-ний өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Харбин хотноо гарын үсэг зурсан.

Монгол Хятадын талын ажлын хэсгийн хамтарсан хуралдаанаар талууд үндсэн 3 түвшний бичиг баримт байгуулахаар тохиролцсон байна.

1 дүгээрт Засгийн газар хоорондын энэхүү хэлэлцээр.

2 дугаарт ажлын хэсгийн түвшинд талуудын байр суурь протокол. Энэхүү протоколд мөн Харбин хотноо гарын үсэг зурсан.

3 дугаарт Компани хоорондын гэрээнүүдийг энэхүү хэлэлцээрийг соёрхон баталсны дараа байгуулах болно.

Хэлэлцээрийн төслийг тохирох явцад талууд төмөр замын царигийн өөр өөрийн стандарт, дүрэм журмыг мөрдөх, төмөр замаар гуравдагч талын ачаа тээврийг тээвэрлэх, төмөр замын бүтээн байгуулалтыг хэрхэн богино хугацаанд хэрэгжүүлэх, нүүрс худалдах, худалдан авах гэрээний хугацаа, нүүрсний хэмжээ, үнийг хэрхэн тогтоох, нүүрсний олборлолтыг хэрхэн нэмэгдүүлэх, эрчим хүчний нүүрсний худалдаа, бусад боомтуудын бүтээн байгуулалт, сэргээгдэх эрчим хүчний салбар, бусад дэд бүтцийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэж дээрх 3 түвшний баримт бичгүүдэд тусгахаар тохиролцсон болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр” байгуулагдсанаар Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэж, улмаар Монгол, Хятадын бусад 3 боомтыг төмөр замаар холбох, бусад томоохон төслүүдийг хамтран хэрэгжүүлэх боломж нээгдэх юм.

Үүний үр дүнд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжиж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Хуулийн төслийн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Н.Наранбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 3 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн “Гашуунсухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгой нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2025 оны 3 сарын 26-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хороо хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, тухайн бүс нутагт ундны усны асуудал хүндрэлтэй байгааг хэрхэн шийдвэрлэх, усны талаар суурь судалгаа хийсэн эсэх, цэвэр усны асуудалд анхаарах, хил холболт хийгдсэнээр төмөр замын тариф, авто тээврийн тарифын харьцаа ямар байх, Гашуунсухайт боомтоос Цогтцэций сум хүртэлх авто замын ажлын явцын талаар, Улсын Их Хурлын гишүүн Шижир Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолын 3, 5, 9 дэх заалтад тусгасан асуудал хэлэлцээрт тусгагдаагүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолд орон нутгийн асуудал, байгаль орчны асуудал, ажлын байрны асуудал, усны асуудал, цөлжилт, шар шороо, тоосжилтын асуудлыг тусгайлан оруулж өгсөн боловч хэлэлцээрт тусгагдаагүй байгаа талаар, төслийг хэрэгжүүлснээр байгаль орчинд сөргөөр нөлөөлөх байдал, тоосжилт, усны хэрэглээ, сургууль, цэцэрлэг, төрийн үйлчилгээ, эмнэлгийн асуудлыг шийдвэрлэх, орон нутагт үр өгөөжтэй байхад хэрхэн анхаарч байгаа талаар, “Эрдэнэс Тавантолгой” ХК орон нутгийн иргэдтэй харилцах хүрээнд ямар ажил хийхээр төлөвлөж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Жангабыл хэлэлцээрийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, бүтээн байгуулалтын ажлыг ямар хугацаанд эхлүүлэх, хэлэлцээрийг баталснаар ямар нэгэн хууль тогтоомжид өөрчлөлт орох эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ганбат хил холбох, хил дамнах гэсэн ойлголтыг нэг мөр болгох, хэлэлцээрт тусгасан 3-ыг цогцоор гэснийг юу гэж ойлгох

талаар, Улсын Их Хурлын гишүүн Эрдэнэболд олон нийтэд мэдээллийг тодорхой түгээхэд анхаарах, хэлэлцээр батлагдсанаар эдийн засгийн үр өгөөжөө хэр хугацааны дараа өгөх, гүүрэн байгууламж ямар хугацаанд баригдах, бүтээн байгуулалтын ажил дуусах хугацаанд холбоотой тодорхой мэдээлэл өгөх, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас гадна байгаль орчин, экологи, нийгмийн асуудал хөндөгдөж байгаа учраас Засгийн газар анхаарч ажиллах шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Жаргалан хэлэлцээрийг зөвшилцөх үед Байнгын хорооны гишүүдээс тодорхой саналууд гаргасныг хэлэлцээрт тусган томъёоллын хувьд сайжирсан байгаа талаар дурдаад, Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрт 2025 оны 2 дугаар сарын 14-ний өдөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Харбин хотноо гарын үсэг зурсан протоколтой танилцах хүсэлтэй байгаа талаар, дагалдах 3 гэрээ байгуулах хугацаа, гэрээтэй холбоотой бүтээн байгуулалтын тендер зарлах, дүгнэхтэй холбоотой тодорхой мэдээ мэдээллийг ажлын хэсгээс тодруулж асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Хосбаяр Төслийн зураг төсөл, норм стандартыг хангаж байгаа эсэх, томоохон бүтээн байгуулалт, төслийн ажлуудын график, үе шатуудад онцгой анхаарах, хугацаа алдалгүйгээр төмөр замын асуудлыг судлах, Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар төслийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, хот тосгон, суурьшлын бүсийн асуудлыг шийдвэрлэх, цогцоор нь анхааралдаа авах зайлшгүй шаардлагатай боомтод ажиллаж, амьдарч байгаа төрийн албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөл, тоног төхөөрөмж, лаборатори бий болгох, малчдын асуудал, худаг ус, бэлчээрийн асуудлыг шийдвэрлэх, АМНАТ, татвар хураамжаас тодорхой хувийг орон нутагт төвлөрүүлэх, үр өгөөжтэй байхад анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Болормаа төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд, “Эрдэнэс Тавантолгой” ХК төслийг хэрэгжүүлэхдээ хариуцлагатай байж хэрэгжилтэд анхаарах, орон нутгийн иргэдийн оролцоог хангах, хэлэлцүүлэг зохион байгуулах зэргээр санаачилгатай ажиллах, орон нутгийн иргэдэд хүртээмжтэй, үр өгөөжтэй байхад анхаарч, үйл ажиллагаагаа цаг алдалгүй эхлэх шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Жангабыл нүүрсний чанарт анхаарах, шинээр нээх уурхайгаас гарах нүүрсийг борлуулах талаар гэрээнд тусгах шаардлагатай, Улсын Их Хурлын гишүүн Ганбат төслийг хэрэгжүүлэх явц, үр дүнд анхаарч хариуцлагатай ажиллах, Улсын Их Хурлын гишүүн Тэмүүлэн гишүүдийн хэлсэн саналуудыг ажил хэрэг болгох, засаж залруулах, нийцүүлэхэд анхаарч хариуцлагатай ажиллах, 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр учраас харилцан ашигтай байх, 1 талдаа Монголын талын эрх ашгийг хангуулахад анхаарах, авто зам болон тээвэр боомтын орчин нөхцөлтэй холбоотой орон нутгийн хөгжил, үндэсний аж ахуйн нэгжүүдийн оролцоотой холбоотой асуудлыг онцгойлон анхаарч ажиллах, түүнчлэн гишүүд 2 талын ажлын хэсэг хооронд байгуулах протоколтой танилцуулах шаардлагатай талаар тус тус үг хэлсэн болно.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард

Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Наранбаатар гишүүнд талархал дэвшүүлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулна.

Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн дагуу би бас өнөөдөр өглөө гишүүдэд, сайд нарт бас танилцуулсан байгаа. Улсын Их Хурлын чуулганд аливаа асуудлаар танилцуулга хийх, хариулт, тайлбар өгөх үндсэн үүргийг салбарын сайд нар бүрэн хариуцаж хийж байна. Шаардлагатай тохиолдолд ажлын хэсэгт орсон төрийн албан хаагчид, мэргэжлийн эрдэмтэд, судлаачид бас нэмэлтээр хариулт, тайлбар өгдөг байна гэсэн энэ дэгийн тухай хуулийнхаа заалтыг одоо бүрэн хэрэгжүүлж ажиллана.

Тийм учраас энэ асуудал дээр Цэвэгдоржийн Туваан, Борхүүгийн Дэлгэрсайхан, Батмөнхийн Батцэцэг гэсэн сайд нар голчилж хариултаа өгч, бусад ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон хүмүүс нэмэлт хариулт өгөх нөхцөл үүссэн тохиолдолд нэмэлтээр хариулт авч явна гэдгийг бас дахин сануулж хэлье.

Ингээд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Намчинсүрэн мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Т.Ганбаатар мөн яамны Хуулийн хэлтсийн дарга, Б.Хулан мөн яамны Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга, Л.Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Ж.Соёлмаа мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Т.Баяржаргал мөн яамны Гэрээ, эрх зүйн газрын Хилийн хэлтсийн дарга, Б.Артур Зам, тээврийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Х.Итгэлт мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Д.Мөнхбат мөн яамны Төмөр замын тээврийн хэлтсийн дарга, Г.Дөлгөөн мөн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч, Х.Мөнхжаргал "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, Э.Түвшинжаргал "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, Э.Уянга "Эрдэнэс Тавантолгой" ХК Хууль, эрх зүйн газрын дарга, Ч.Алтанбагана "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Уул уурхай, технологийн газрын дарга гэсэн албан тушаалтнууд байна.

Ингээд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Гомбын Ганбаатар гишүүнээр тасаллаа. Нийт 12 гишүүн. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Нүүрсний экспорт, ялангуяа нүүрсний экспортыг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолыг өнгөрсөн онд баталж, үүний дагуу Засгийн газар ажиллаж, энэхүү хил холболтын асуудлыг оруулж ирж байгаа. Тэгээд энийг бол дэмжиж байгаа.

Тэгэхдээ энэ Улсын Их Хурлын 58 дугаар тогтоол дээр 1 зүйлийг өөрөөр хэлбэл дандаа төмөр замын холболтын асуудлыг оруулж ирсэн. Энэ дотор тоон дотор үсэг цохиж явна гэдэг шиг авто замын холболтын асуудлыг 11 дүгээр зүйл болгож оруулж өгсөн байгаа. Тэгэхээр энэ бол Ховд аймгийн Булган боомтын 126,

127 дугаар хилийн шугамаар шинэ гарц нээх, мөн түүнчлэн Байтагийн боомтыг байнгын болгох ийм заалтыг оруулж өгсөн. Тэгэхээр энэ хил холболтын төмөр замын асуудлаар говийн бүсийн Шивээ-хүрэн, Ханги-Мандал, Гашуунсухайтын төмөр замын холболтын асуудлыг шийдвэрлэж байгаа. Зүүн бүсийн Бичигт боомтын төмөр замын холболтын асуудлыг шийдвэрлэж байгаа. Ингэснээр энэ төмөр замын холболтын асуудлуудыг шийдвэрлэснээр гол нь нүүрсийг энэ төмөр замуудаараа экспортлох тухай л асуудал гол нь байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл дээр яагаад түрүүчийн 2 авто замын боомтын асуудлыг оруулсан бэ гэхээр баруун бүсийн нүүрсний экспортын асуудлыг л гол нь оруулж өгч, үүний хүрээнд баруун бүс илүү хамт хөгжих энэ боломжийг л нээж өгч байгаа. Тэгэхээр энэ 2 боомт нээгдэх юм бол, байнгын болох юм бол хөшөөт дээр байгаа 2 компани илүү 3 сая тонн гаран тонн нүүрс экспортолж байсан бол 10 сая тонн нүүрс экспортлох, мөн түүнчлэн Хотгор, Тарвагатай зэрэг нүүрсний уурхайнууд бас экспорт хийнэ. Дээрээс нь Увс аймагт, Баян-Өлгий аймагт 3, 4 төмрийн хүдрийн компаниуд байгаа. Тэд нар бас экспорт хийх ийм боломжууд нээгдэх юм.

Өнөөдрийн байгаа байдлаар бол Булганы боомтоор өдөрт 200 машин гарч байгаа. Гэтэл тэндхийн Гаалийн дарга нь танай компани өдөрт 120-ийг гаргаж, танайх 40 машин гарга гээд бүх сайд нар бүгдээрээ урд талын хил дээр очоод яаж нүүрснийхээ экспортыг сайжруулах вэ гэж ярьж байхад Жавхлан сайд аа, ингэж ярьж байхад тэр Гаалийн дарга нь танайх тэдийг л гарга гэдэг ингээд зогсоож байж болохгүй. Тийм учраас энэ дээр арга хэмжээ авах хэрэгтэй.

Тийм учраас энэ Засгийн газрын тэргүүн ч гэсэн ажлын хэсэгт орсон Их Хурлын гишүүд юу Засгийн газрын гишүүдэд яг энэ 58 дугаар тогтоолын 11 дүгээр заалтад байгаа тэр асуудлаар Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай Хөгжил шинэтгэлийн хороотой ямар ямар шатад асуудал ярьсан бэ. Энэ хэзээ нээгдэх вэ.

Ер нь бол цаашдаа нэлээн асуудлууд шийдэгдэх нь бол ОХУ баруун бүсийн босоо тэнхлэгийн замыг маш их сонирхож байгаа. Новосибирскээс Ташкент хил хүртэл 898км замыг хүчитгэх, хүнд даацын болгох тэр концессын гэрээг зарлаад, тэрэнд нь компани шалгараад ингээд явж байгаа. Тэгэхээр бид нар Цагааннуурын боомтоос Байтагийн боомт хүртэл хуучин АН4 гэдэг зам бол хүнд даацын зам биш учраас энэ бол уул уурхайн тээвэр хийхэд их хүнд байгаа. Тийм учраас цаашдаа бид бол энэ босоо тэнхлэгийн АН4-ийг хүнд тээврийн авто зам болгох энэ ажлыг хийх ёстой. Ингэж байж бид нар хамгийн бага зардлаар БНХАУ болон ОХУ-ын хооронд тээвэр хийх ийм боломжийг, гарцыг нээж өгөх юм. Энэ бол Засгийн газрын бодлогод бас орчихсон байгаа. Тэгээд энэ дээр хариулт өгнө үү гэж Ерөнхий сайдаас.

Д.Амарбаясгалан: Монгол Улсын Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Пүрэвдорж даргын асуултад хариулъя. Монгол Улс БНХАУ-тай 1955 онд анхны 2 боомт холбогдох гэрээг хийж байсан. Энэ бол бид бүгдийн сайн мэдэх Замын-Үүд-Эрээний боомт 1955 онд. Өнөөдөр бид нар Монгол Улсын Их Хурлаар 2 улсын Засгийн газар хоорондоо албан ёсны хэлэлцээр хийсэн. 2 дахь боомтыг далан жилийн дараа өнөөдөр батлах гэж байна гэсэн үг. Энэ бол манай экспортын гол боомт болох Гашуунсухайт-Ганцмод холбогдох, мөн Монгол Улсын Засгийн газрын яам, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хөгжил шинэтгэлийн хороотой Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурсан анхны тохиолдол бол

энэ болж байгаа. Энэ үеэр хэлэлцээрээр Хөгжил шинэтгэлийн хороо дээр боомтуудыг эдийн засгийн ач холбогдлоор нь эрэмбэлсэн байгаа тухай ийм протоколд үлдэж байгаа юм. Гашуунсухайт-Ганцмод өнөөдөр батлагдсанаар 3 дахь боомт буюу Шивээхүрэн боомттой бид нар хамтын ажиллагааг эхлүүлэх ийм эрх зүйн орчин нээгдэж байна гэсэн үг. Одоо энэ протоколын дагуу.

Шивээхүрэн бол экспортын хүчин чадлыг 10 сая тонноор нэмэгдүүлэх ийм боомт байгаа. Шивээхүрэн боомтыг бид нар холбосны дараа Шивээхүрэн маань өөрөө Арц-суурьтай холбогдвол энэ нь өөрөө баруун босоо тэнхлэг болчихож байгаа. Таны асуултад Шивээхүрэнгийн дараа Бичигт. Бичигт бас 10 сая тонноор нэмэх ийм боломжтой. Бичигтийг Эрээн цавтай холбочихвол энэ зүүн босоо коридор болчихно.

Үүний дараа 5 дахь боомт бол Ханги. Ингээд бусад боомтуудыг бид нар ээлж дараалан ярих боломжтой байгаа. Тийм учраас бидний хувьд Гашуунсухайт-Ганцмод өнөөдрийн Засгийн газар хэлэлцээрийг соёрхон батлагдсанаар Шивээхүрэнгүй албан ёсны хэлэлцээр хийх ийм боломж бол энэ протоколын дагуу нээгдэж байгаа. Шивээхүрэнгээ нээчихвэл Бичигт, Бичигтээ нээчихвэл Ханги. Үүний дараа бусад боомтуудынхаа боломжит хувилбар буюу ТЭЗҮ дээр яаралтай ажиллах ийм л боломж бүрдэж байгаа гэдгээрээ өнөөдрийн бас гэрээ бол яалт ч үгүй 1955 оноос хойш 70 жилийн дараа албан ёсоор батлагдаж байгаа ийм 2 дахь бас түүхэн үйл явдал юм. Тэгээд энэ дээр бас Их Хурлын гишүүд, манай Пүрэвдорж дарга ч гэсэн бас их идэвхтэй, ялангуяа энэ боомтууд холбох тал дээр орж ажилласан. Үүнийг бид нар 2 ч удаа албан ёсны хуралдаан дээр энэ байр сууриудыг Монголын тал бол тавьчихсан байгаа.

Гагцхүү дарааллын хувьд ингэж тогтсон байгаа л гэсэн үг.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмэлт хариулт өгье.

Ц.Туваан: Энэ үндсэн чиглэл батлах тухай 58 дугаар тогтоолыг хэлэлцэж байх үеэр Улсын Их Хурлын дэд дарга Пүрэвдорж маш чухал асуудлыг хөндөж буюу ганц төмөр зам гэлтгүй бүгдээрээ экспортыг нэмэгдүүлэх зорилго агуулж байгаа учраас энэ авто замуудыг, боомтыг ялангуяа энэ баруун талын Байтаг, Улиастай, Булган, Ташкент боомтын 126, 127 дугаар тэмдэгтийн хоорондуур шинэ авто замын гарц гаргах энэ асуудлыг хөндөж тавьсан.

Тэгээд энэ асуудлыг бид бүхэн хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн бусад хэсэг дээр талууд боомтын хамтын ажиллагааг бэхжүүлж, гаалийн нэвтрэх чадварыг нэмэгдүүлнэ гэдэг байдлаар ерөнхий, тухайлан бол энэ асуудлаар 2 улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Хятадын талд Засгийн газар дээрээс саналуудыг бас тавиад явж байгаа. Мөн энэ боомтуудын цаана Шинжан Уйгарын өөртөө засах орон байрладаг. Тэгэхээр бид нар энэ оны 5 дугаар сард Монгол Улсын Гадаад харилцааны яам, Шинжан Уйгарын өөртөө засах орны ардын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны механизмын уулзалтын үеэр.../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Сангийн сайд Болдын Жавхлан нэмэлт хариулт өгье.

Б.Жавхлан: Пүрэвдорж гишүүн асуултад нэмэлт мэдээлэл өгье. Яг Булганы боомт манай урд талын боомтуудаас яг ковидын үед их хариуцлагатай ажилласан боомт байдаг юм шүү дээ. Бусад том боомтууд маань хаагдчихаад байхад Булган

дээр бол яах вэ, хэмжээ нь бага л даа. Гэхдээ ковидын үед бол огт зогсоогүй. Бусад боомтууд бүр тэг зогсолт хийчихсэн байхад Булганаар дор хаяж 100 машин, 150 машин нүүрс гараад л байдаг байсан. Тэгээд хэрвээ яг Пүрэвдорж гишүүний хэлсэнчлэн тэр гаалийн үйл ажиллагаанаас болоод тэндээс гаалийн ажилтнууд нэвтрүүлэн өнгөрүүлэх чадварыг тоогоор нь хязгаарлах тийм шийдвэр гаргаад, тэгж зохицуулалт хийж байгаа бол энэ маш буруу зүйл. Тэгэхдээ би бас тэгээгүй болов уу гэж бодож байна. Би нягтлаад танд хариу өгье.

Ер нь хэлэхэд Гаалийн үйл ажиллагаа гаалийн хуваарьт цагаас болоод хэрвээ тэнд нэвтрэн өнгөрүүлэх .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн нэмэлт 1 минут.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр бид нар бол аж ахуйн нэгжүүдээ Ховд аймгийн удирдлагууд, Их Хурлын гишүүд бол нэг зүйлийг зорьж байгаа нь боомтынхоо нэвтрэлтийг сайжруулсны үндсэн дээр аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа илүү олон их тонноор, их хэмжээгээр нүүрс экспортлох ийм боломжийг л нээж өгч байгаа юм. Тэгэхээр манай Ховдын компаниуд жишээ нь “Мон эко” гэж компани нүүрс гаргаж байгаа тонн тутамдаа 1 доллар төлдөг. Энэ Монголд хаана ч байхгүй. Бид нар нэвтрэлтийг нь сайжруулсны үндсэн дээр 2 доллар авахаар зорьж байгаа. Ингэсний үр дүнд Ховд аймаг АМНАТ болон экспортынхоо тэр зүйлээр болон “Мон эко”-ийн төлбөрөөр бид нар улсын төсвөөс ямарваа нэгэн татаас авахгүйгээр амьдардаг л ийм аймаг болохын төлөө зүтгэж байгаа. Энэ дээр Засгийн газрын гишүүд илүү сайн ялангуяа Ерөнхий сайд илүү сайн ажиллаж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Доржзодовын Энхтуяа гишүүн асуулт асууна.

Д.Энхтуяа: Баярлалаа. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын их бүтээн байгуулалтыг дэмжиж саналаа өгсөн. Дэмжих болно. Энэ дээр Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж ингэж заасан байгаа. Тэгэхээр энэ дээр бол би Засгийн газар маш хариуцлагатай, бүх асуудлыг цогцоор нь авч явах юм байна гэж ингэж ойлгож байгаа.

Энэ дээр хамгийн гол нь бүтээн байгуулалтыг бол холбох бүтээн байгуулалтыг 2 сарын хугацаанд хийнэ гэж Сангийн сайд хариулж байна лээ. Яг үүнтэйгээ адилхан бүх юмыг цогцоор нь авч явах уу гэдэг нэг ийм асуудал байна. Энэ дээр юу гэхээр одоо бол Цагаан хад дээр жишээлбэл. Энэ дээр бол суурьшлын бүс бий болчихсон байгаа. Харамсалтай нь тэнд ажиллаж, амьдарч байгаа хүмүүсийн нийгмийн асуудал бол маш хүндрэлтэй байдаг юм. Тэгэхээр энэ нийгмийн асуудлыг Засгийн газар, мэргэжлийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нь цогцоор нь авч үзээд, ингээд Байгаль орчны яам, Барилга, хот байгуулалтын яам гээд манай Засгийн газар энэ дээр маш хариуцлагатай ажиллах байх гэж ингэж бодож байна.

Энэ дээр надад 3 асуулт байна. Энэ хэлэлцээрийн 5 дугаар зүйл дээр талууд аж ахуйн нэгжүүдийг арилжааны зарчмаар сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд үргэлжлүүлэн дэмжинэ гэсэн ийм зүйл заалт байна. Тэгэхээр би Эрчим хүчний үндэсний хорооны реформын гишүүнээр ажиллаж байгаа. Энэ дээр бол сэргээгдэх эрчим хүчний асуудлаар урьд нь ямар үйл

ажиллагаа ярилцан тохиролцсон зүйл байгаа юу. Байгаа болоод үргэлжлүүлэн дэмжиж ажиллана гэсэн ийм асуудал бол энэ дээр орсон байна. Тэгэхээр өнөөдөр бол манай Монгол Улсын эрчим хүчний асуудал бол маш хүндрэлтэй байгаа. Сэргээгдэх эрчим хүчин дээр маш олон гаднын хөрөнгө оруулалт орж ирэхээр ийм хүсэлтэй байдаг боловч манай эрчим хүчний энэ нөөц бололцоо бол хязгаарлагдмал. Дээрээс нь Хятадын талаас хэрвээ худалдан авалт байх юм бол бас томоохон хөрөнгө оруулалт орж ирэх боломжтой гэж би ингэж харж байгаа юм. Тэгэхээр яг энэ энэ зүйл, заалттай, энэ гэрээтэй холбоотойгоор энэ сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний энэ асуудлуудыг яг ямар хэмжээнд цааш нь ярьсан бэ. Ярьсан тодорхой ийм зүйл заалтууд байгаа юу гэсэн 1 дүгээр асуулт байна.

2 дахь асуулт энэ талууд хот байгуулалт, орон сууцжуулалт, дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана гээд ингэж байна. Тэгэхээр ер нь бол Хятадын тал бол онцгой энэ бүтээн байгуулалтыг маш чухал хэмжээнд авч явдаг. Дээрээс нь хүний асуудлыг цогцоор нь авч явдаг ийм бүтээн байгуулалт хийдэг улс. Тэгэхээр манай улс бол зөвхөн энэ байгалийн баялгаа гаргаж тавьчихаад, энэ бүтээн байгуулалтыг, хүний асуудлыг бол орхигдуулдаг. Ганц түрүүн би хэлсэн Цагаан хад дээр өнөөдөр энэ асуудал бас хүндрэлтэй хэвээр л байгаа. Тэгэхээр энэ бүтээн байгуулалтыг бол хүмүүс хийнэ. Яг ажиллах ийм насан дээрээ байгаа, идэр насны хүмүүс хийх учраас энэ хүмүүсийн асуудлуудыг яаж цогцоор нь харж байгаа вэ. Тодорхой бас төлөвлөгөө зүйл Засгийн газрын хэмжээнд байгаа юу гэсэн 2 дахь асуулт байна.

3 дахь асуултад энэ зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх зорчигчид аюулгүй үйлчлүүлэх боломж бүрдэнэ гээд ингээд ерөнхий заалт орсон байна. Тэгэхээр зорчигч тээвэр яг хэзээ явж эхлэх вэ. Энэ талаар бас тодорхой санал гаргасан зүйлүүд байгаа юу гэсэн ийм 3 асуулт байна. Ер нь бол хурдхан шиг л энэ нүүрс тээврийн асуудлуудыг цогцоор нь хийж хэрэгжүүлээд, энэ Засгийн газар одоо яг энэ гаргасан хэлэлцээрийнхээ үр дүнг нь бас ард түмэндээ хүрэх ёстой гэж бодож байна. Би бол өөрөө Өмнөговь аймагт төрсөн. Энэ Өмнөговь аймаг бол бас баялагтай байсныхаа хашилтад хэлье “хар гайгаар ч” гэдэг юм уу, ер нь бол байгаль орчин бол маш сүүддэг. Жишээлбэл Өмнөговь аймгийн миний төрсөн нутаг Гурван Тэс Мандал-Овоо сумдад бол сүүлийн 5 жил .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Доржханд сайд энэ төсөлтэй холбогдуулан бас сэргээгдэх эрчим хүчний хөрөнгө оруулалтын талаар хариулт өгье.

Т.Доржханд: Баярлалаа. Энхтуяа гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр Хятадын Засгийн газартай байгуулж байгаа анхны гэрээ гэдгийг бас дахиж онцолж хэлмээр байна. Тэгээд Хятадыг тойрсон 14 улс байдаг. Хөгжиж байгаа улсуудтай бас ийм гэрээ байгуулаагүй байдаг гэдгээр бас их онцлог. Тэгээд үүгээрээ бид нар хийж авсан, тохирч авсан зүйл нь юу вэ гэхээр зөвхөн бас энэ хил холболт, уул уурхайн асуудал биш юм. Энэ бол эрчим хүчний хамтын ажиллагааныхаа асуудлыг тов тодорхой энэ гэрээн дээрээ тусгасан байгаа. Тэгэхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын зүгээс бол Монгол Улсаас эрчим хүч авъя гээд 2 удаа Ерөнхийлөгчийн айлчлалын үеэр тохиролцсон байдаг юм байна лээ. 2005, 2015 онд. Тэгээд тэгэхдээ бол 5 жилийнхээ төлөвлөгөөнд тусгаад, эрчим хүч авъя. Эхнийх нь бол 10,7 гигабайтыг, дараа нь 5,8 гигабайтыг авъя. Тэгээд цаашаа нэмье гэсэн ийм тохиролцоонууд өмнө нь хийгдсэн байдаг юм байна лээ. Тэгээд харамсалтай нь манайх тэр ажлаа хийж чадаагүй. Бодит байдал нь бол тэр. Одоо ингээд цаашаа

яах вэ гэхээр сэргээгдэх эрчим хүч бол нийтийн хэрэглээ болчихсон. Тэгээд сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр тухайлбал тоног төхөөрөмж үйлдвэрлэл явуулдаг тэр зах зээлийн 90 хувийг нь бол Хятад ингээд дангаараа хангадаг. Тэгээд нөгөө талдаа яг энэ уулзалтын, энэ хэлэлцээрийн давуу тал нь юу байна вэ гэхээр бид нар сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр хамтын ажиллагаа бол хийе гэдэг энэ үг үсгээ бол тов тодорхой ингээд тусгагдсанаараа онцлог байгаа.

Тэгээд үүнийгээ баталгаажуулаад Шанхайд болсон уулзалтаар, Ерөнхий сайдын айлчлалаар бид нар бол энэ асуудлаа ярьсан. Үүнийгээ баталгаажуулаад сая 1 сарын өмнө Хайнаньд бас Ерөнхий сайдын айлчлал болсон. 1 өдрийн маш их үр дүнтэй айлчлал болсон. Энэ айлчлалын үеэр Хятадын Ерөнхий сайдтай уулзсан уулзалтаар маш тодорхойгоор одоо эрчим хүчнийхээ хамтын ажиллагааг хийе. Бид нар цэвэр сэргээгдэх эрчим хүчийг танай талаас авъя гэдгээ бол уулзалтын протокол дээр тусгаад ингээд явж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол Хятадын хэрэглээ бол жилийн 2 тера буюу 2 мянган гигабайт жил болгон ингээд өсөөд явж байгаа. Тэгээд нөгөө талдаа бүгд мэдэж байгаа байх. Энэ их өгөгдөл дэлхий нийтийн хэрэглээ болсонтой холбоотойгоор цэвэр эрчим хүчний хэрэглээ дэлхий даяараа өсөж байгаа. Тэгээд энэ Давосын уулзалт энэ олон улсын хөрөнгө оруулалтын уулзалт дээр бол дараагийн 10 жилийн хугацаанд энэ хэрэглээ өнөөдрийн хэрэглэж байгаа дэлхийн эрчим хүчнээс 7 дахин илүү ийм хэрэглээ дэлхий дээр үүсчхээд байна буюу эрчим хүч, цэвэр эрчим хүч бол маш их тийм эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн болчихоод байгаа. Тэгээд ийм агуулгаар бол бид нар гэрээ хэлэлцээрээ амжилттай хийсэн.

Тэгээд яг үүний араас бол Арабын Нэгдсэн Улсын Засгийн газруудтай бол гэрээ хэлцэлд ороод явж байна. 10 гегаваттаас эхлээд бид нар хөрөнгө оруулалт хийгээд, тэгээд үйлдвэрлэсэн эрчим хүчнийхээ тодорхой хэсгийг бол мэдээж Монгол Улс хэрэгтэй гэвэл .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Энхтуяа гишүүний асуултад нэмж хариулъя. Энхтуяа гишүүн маань бас говийн бүсээс сонгогдсон. Энэ төсөл хэрэгжих Өмнөговь аймгийн хүн байгаа учраас тойрогтой аймагтайгаа холбоотой асуудлуудыг тавьж байна. Энэ гэрээн дээр бид бүхэн нэлээн олон хэлэлцээрт, протоколд, дараа нь байгуулах компани хоорондын гэрээнд энэ Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолоор баталсан 12 заалтуудаа хувааж оруулж өгсөн байгаа гэдгийг хэлье. Тухайлах юм бол бид бүхэн хэлэлцээр дээрээ энэ сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой хамтын ажиллагааг идэвхтэй урагшлуулна гэж заалт, мөн тухайн манай улсын талд бол хот байгуулалт, орон сууцжуулалт болон дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалтын төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах ийм заалтууд орсон. Дээрээс нь бас өнөөдөр Засгийн газар дээр экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсгийг Сангийн сайдаар ахлаад ажиллаж байгаа. Энэ ажлын хэсэг дээр яг тэр Цагаан хад .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Нэмж хариулъя.

Ц.Туваан: Цагаан хад дээр үүсээд байгаа суурьшлын асуудал, тухайн боомт байгаа Өмнөговь аймгийн Ханбогд сумын Хайрхан сумтай холбоотой асуудлуудыг бол ярилцаад явж байгаа. Тэгэхээр энэ өөрөө газар нь ТХГН-т ордог учраас газрын асуудлыг шийдвэрлэхэд бол маш төвөгтэй байдаг. Тэгээд өчигдрийн Засгийн

газрын хуралдаан дээр энэ асуудлыг тухайлан авч, Засгийн газрын асуудлыг шийдэж, тэнд байгаа хүмүүсийн бас нийгмийн асуудлуудыг шийдэх тал дээр онцгой анхаарч ажиллах ийм шийдвэр гарч байгаа. Сая ажлын хэсэг Гашуунсухайт боомт дээр ажиллах үеэрээ Хайрхан багт байрлах онцгой байдлын бүлгийн асуудал, тэнд баригдах эмнэлгийн асуудлуудыг бас шийдэж ирсэн байгаа гэдгийг нэмэлтээр хэлье.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн асуулт асууя.

Л.Мөнхбаясгалан: 2010 оны 6 сарын 24-ний өдөр Монгол Улсад Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого батлагдсан тэр өдрөөс эхэлсэн төмөр замын даажинг өнөөдөр ингэж дуусгаж, Улсын Их Хурлаар 2 улсын хоорондох гэрээг соёрхон батлах гэж байгаа юм. Ийм өдөр ирдэг юм байна. Монгол Улсын Ерөнхий сайд, Хууль зүйн сайд, Туваан сайд нараас асуух асуулт бий. Тэгэхдээ жоохон тайлбар хиймээр байна.

2014 оны 8 сард Монгол Улсын Ерөнхийлөгч Элбэгдорж удирдаж, “Энержи Ресурс” компани Сайханбилигийн Засгийн газар нэг нууц гэрээ байгуулсан. Тэр гэрээ өнөөдөр Монгол хэл дээр байхгүй. 10 жилийн дараа Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ 5 намын хамтарсан Засгийн газар очиж, Хятад хэл дээр олж ирсэн гэрээг. Энэ гэрээг олон нийтэд ил болгомоор байна. Би эндээс юу хэлэх гээд байна гэхээр шударга ёсыг нэхэмжилмээр байна. Бүтэн 15 жил “Тавантолгой”-г 100 жилээр Хятадын компанид өгөх гэж оролдсон. Улсын Их Хурал дээр тогтоол гаргаж, 40 гишүүн энийг унагасан. 36 нь эх орон Монгол Улсын эрх ашгийн эсрэг ажилласан. Дээрээс нь Хятадын компанийг олборлолтод оруулна. Төмөр замыг нарийн царигаар барина гэж Улсын Их Хурлын тогтоолын эсрэг явж байсан. Одоо харин Туваан сайдаас асуухад ингэж ойлгож байна. Монгол Улсын хуулийн дагуу өргөн царигаар тавих юм байна. Хил холболтын зардлыг Хятадын тал даах юм байна. “Тавантолгой”-н хувь эзэмшил рүү дахиж орохгүй юм байна. Олборлолт явуулахгүй юм байна. Жилдээ 20 сая тонн нүүрс авах юм байна. Тийм үү. Энэ зөв үү. Ингэж ойлгож байна.

Алтангэрэл сайд, Ерөнхий сайд 2-оос бол шударга ёсыг нэхэмжилж байна. 15 жилийн дотор 80 гаруй хүн ажил амьдрал, нэр төрөөрөө хохирсон. Яаж цагаатгах юм. Дээрээс нь энэ хулгайч нартайгаа хариуцлага тооцохгүй юм уу. Кайманы аралд бүртгэлтэй оффшор компанитай “Энержи ресурс” гэдэг компани энэ бүгдэд оролцож, зохион байгуулж байсан. Сая ил болсон. Энэ хүмүүстэй хариуцлага тооцохгүй юм уу. Тэр Элбэгдорж, Сайханбилэг нарыг баривчилж авчирч ял тооцохгүй юм уу. Эд нар чинь хулгай хийсэн гэдэг нь, тухайн үед хуйвалдаан хийсэн гэдэг нь ил боллоо шүү дээ. 15 жил гэдэг хүний амьдралд 1 хүүхэд төрүүлээд, бүр 15 нас хүртэлх хугацаа шүү дээ. Энд шударга бусын хонгилоор нь чирэгдэж яваад, 15 жилийн хууль бус ял тулгуулж явсан хүний хувьд би энэ асуултыг энэ шударга ёсыг нэхэмжлэх эрхтэй гэж бодож байна. Энэ олон хэлмэгдсэн хүмүүсээ цагаатгахгүй юм уу.

Дээрээс нь Эрдэнэтийн 49 хувь, Дубайн гэрээ бүгд яг ийм технологиор хийгдсэн. Бид нар яриад л байдаг, яриад л байдаг, ямар ч хариуцлага тооцдоггүй. Эсвэл тэр хулгайч нартай хариуцлага тооцож чадахгүй юм бол дархлагдсан хулгайч гэдэг нэг тийм цол тэмдэг өгөөд, тэрийгээ Их Хуралдаа танилцуулаад тэгээд дархлаад явчихмаар байх юм. Санжийн Баяр гэж нэг нөхөр байдаг. Шүүхээс авлигын хэргээр ял сонсчихсон. Хөрөнгөө хураалгачихсан. Ялаа эдэлчихсэн.

Дуртай үедээ Монгол Улсын эсрэг геополитикийн бодлогуудыг хамаа намаагүй ярьж байдаг. Одоо тэр хүнийг тэгээд тусгай эрхт элчин сайдаар томилох уу Ерөнхий сайдаа. Үгүй биз дээ. Энхсайхан гээд ял эдэлсэн хүн байна. Одоо Сайханбилэг, Элбэгдорж гээд эх орноосоо зугтаагаад явчихсан хүн байна. Монгол Улсыг 15 жил хохироосон, өмнөд хөрштэй нь үл ойлголцол хийсэн, Засгийн газар 2-ын хооронд хувийн “Энержи ресурс” гэдэг компани зуучилж байдаг. 4 янзын гэрээ оруулж ирдэг. Хятад хэл дээр үйлдүүлдэг. Монгол хэл дээр байсан гэрээг устгадаг ийм төрөөс том, дээрээс нь Монгол Улсын Ерөнхийлөгчийг өөрийнхөө дохио зангаагаар хөдөлгөдөг ийм .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хариулт өгье. Эхлээд Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Энэ 58 дугаар тогтоолын хүрээнд 12 зүйл заалттай гэрээ, хэлэлцээрийг байгуулах үндсэн чиглэл баталж өгсөн дотор таны саяын ярьсан тодорхой асуудлуудыг бол тусгаж өгсөн. Тухайлах юм бол энэ заалтын үндсэн чиглэлийн 1 дүгээрт 2 улсын Засгийн газар хооронд төрийн дээд түвшинд тохирсон иж бүрэн хамтын ажиллагааны хэлэлцээрт аливаа гуравдагч талын оролцоогүй хэрэгжүүлэх гэдэг байдлаар тусгаж өгсөн. Тэгэхээр шууд Засгийн газар хоорондоо дундын зуучлалгүй хэрэгжүүлнэ гэж ингэж ойлгож болно. Энэ дээр мөн гэрээний 3 дугаарт Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хүрээнд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа, эзэмшиж байгаа ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг бусад этгээдэд шилжүүлэхгүй гэж тодорхой зааж өгсөн. Мөн протокол дотор давхар 4.3-д нь “Чайна Энержи” группийн зүгээс Тавантолгой ордын лиценз, хувь эзэмших зэрэг саналыг тавихгүй гэдэг заалтаар орж өгсөн.

Олборлолтын тухайд бол эхний 2025, 2026, 2027 онуудад 5, 5 сая тонн, 2028, 2029 онд 6, 6 сая, 2030 оноос жилийн 20 сая тоннд хүргэж олборлох, нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээг оруулж өгсөн.

Царигийн асуудлыг бол Монгол Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замыг байгуулахад өргөн, нарийн царигийн аливаа маргаан дахиж үүсэхгүйг бататгах гэж 6 дугаар зүйл заалт дээр оруулж өгсөн гэдгийг бас хэлье.

Дээрээс нь энэ заалтын 9 дүгээрт 2 улсын хооронд баригдсан төмөр замын бүтээн байгуулалттай холбогдуулж өнгөрсөн хугацаанд Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд гарсан аливаа алдагдал хохирол болон төмөр замын хил холболтод шаардлагатай хөрөнгө оруулалтын асуудлыг ирээдүйд нэхэмжлүүлэхгүй байх гэж ийм зүйл заалтуудаар бол тодорхой зааж өгсөн гэдгийг танд хэлье.

Д.Амарбаясгалан: Оюунсайханы Алтангэрэл сайдад хариулт өгье.

О.Алтангэрэл: Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Хариуцлагын асуудал яаж яригдах юм бэ гэж байна. Хариуцлага бол олон янз байгаа. Эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэдэг ч юм уу. Энэ асуудал дээр ер нь эрүүгийн хувьд ямар ч асуудал ярих боломж, бололцоогүй болчихоод байгаа. Манай Эрүүгийн хуулийн хөөн хэлэлцэх хугацаа гэж 1 зүйл байгаа. Үнэхээр энэ холбогдох байгууллагууд нь шалгая, хяная, үүний араас явъя гэх юм бол Эрүүгийн хуулийн хувьд боломжгүй болчихсон.

Тэгэхдээ Монгол төрийн бодлого, ой санамж хэвээр үргэлжлэх ёстой. Монгол төр энэ хариуцлага тооцдог аливаа асуудлынхаа хойноос явдаг ийм чадамжтай байх ёстой. Ийм ч учраас таны сая жишээ дээр дурдаад байгаа Ухаа худгийн ордтой холбоотой асуудал дээр Монгол Улсын Засгийн газраас ажлын хэсэг гараад дүгнэлтээ гаргаад, энэ дээр хууль зөрчсөн байж болзошгүй үйлдэл байна гээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх гээд ингээд товоо хүлээж..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя.

О.Алтангэрэл: Зарим нэг материал тодруулахтай холбоотой ажиллагаа явагдаж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь үүнээс хойш, түүнээс цааш 1 зүйлийг сайн ойлгох ёстой. Бүхэл бүтэн стратегийн орд газарт тооцогдох ордтой холбоотой байгуулсан гэх гэрээнийх нь хувь төрд нь албан ёсоор байдаггүй. Энийг хариуцлагатайгаар хэлж байгаа шүү дээ. Ийм юм байхгүй гэж. Зарим нэг хүн гуйвуулаад байна лээ. Үзэх гэхээр тэр гэрээ нь төрд албан ёсоор эхээрээ байдаггүй. Айлын талтай асуудал ярихаар цаанаас бас түрүүнд нь төрийн өндөр албан тушаалтан хүн гарын үсэг зурчихсан гэрээ, бидэнд байхгүй гэрээ бас гарч ирдэг ийм байдал байж болохгүй. Бид нар эхнээс нь төрийн хувьд өөрийн чадах хүрээндээ шийдвэрээ гаргаад энэ асуудлыг цэгцлээд явахгүй бол цаашдаа энэ асуудал тасрахгүй. Тийм учраас Монгол Улсын Засгийн газраас энэ асуудалд онцгой анхаарал тавьж, өнгөрсөн хугацаанд хууль зөрчсөн байж болзошгүй, ард түмний энэ эзэмших ёстой баялагтай холбоотой буруу шийдвэр гарсан байж болзошгүй..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмэлт хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Хугацаа бага учраас өнөөдрийн хувьд 70 жилийн дараа Гашуунсухайт-Ганцмод боомт маань ингээд шийдэгдэж байна. Тийм учраас би энэ дээр хэнийг ч шүүмжлэлтэй өнцгөөс, бас хэнийг ч зөвтгөх ба буруутгах өнцгөөс харахыг хүсэхгүй байна. Өнөөдөр том зургаараа Монгол Улс 70 жилийн дараа 2 дахь боомтоо баталж байна. Олон хэлэлцүүлэг боллоо. Тэрийг түүх шүүнэ гэж хариулах нь зүйтэй.

2003 оны 9 сарын 9-өөс эхлээд анх Монгол Улсын Засгийн газар Хятадын талд тавьснаас хойш 20 жил, 2014 оны 8 сард 2 улсын төрийн тэргүүнд тохиролцсоноос хойш 10 жилийн хугацаа өнгөрлөө. Дараа дараагийн боомтуудаа, дараа дараагийн том төслүүдээ ч гэсэн бид нар мэтгэлцээд, явуулах талаас нь харах нь бол зүйтэй. “Тавантолгой”-н асуудлыг бид оруулж ирнэ. Бас цаасан дээр л тулгуурлаж ярих нь хамгийн зөв болно. Засгийн газар энэ цааснуудыг бэлдэж байгаа. Тэгээд Их Хурлын гишүүд та бүхэн маань тухайн үед юу болсон бүх зүйлийг цаасаар хараад л өөр өөрсдийнхөө дүгнэлтийг хийх нь зөв байх. Тэгээд хэдүүлээ хамтдаа шүүн хэлэлцэж ярилцах ийм цаг удахгүй ирнэ. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Лувсанбямбаагийн Мөнхбаясгалан гишүүн тодруулж асууя.

Л.Мөнхбаясгалан: 15 жил зүтгэсэн энэ зүтгэл, энэ тэмцэлд хамт явсан хүмүүст маш их баярлалаа. Тийм учраас өнөөдөр 3,5 тэрбумын орлоготой, 6,3 их наядын татвар төвлөрүүлдэг ийм том үндэсний хэмжээний компанийг Монгол Улсдаа авч үлдэж чадсан юм. Тийм учраас өнөөдөр энэ гэрээг бид нар энд соёрхон батлах гээд сууж байгаа юм.

Алтангэрэл сайдад хэлэхэд хэрвээ эрүүгийн хариуцлага тооцоход тэр хөөн хэлэлцэх хугацааных нь хугацаа хүрдэггүй юм бол хууль санаачлах эрх мэдлээ хэрэгжүүлээд нэмэлт, өөрчлөлтийн хэмжээнд аваад ороод ирж болно шүү дээ. Бид нар заавал хэн нэгнийг цоллолцоод зөв, бурууг нь заавал тогтоох ёстой. Хариуцлагыг нь заавал тооцох ёстой. Тэгэхгүй бол Монголын төрд хэн ч итгэхгүй. Цагаатгах юм бол бас цагаатгачих ёстой. Тэгэхгүй бол энэ хүмүүс чинь нэр төр, амьдралаараа хохирч байна шүү дээ. Төрсөн хүүхэд 15 нас хүртлээ аавыгаа .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууя.

Ж.Алдаржавхлан: Баярлалаа. Мөнхбаясгалан гишүүнд минут арай урт өгчхөв үү, үгүй юу. Түрүүн нэлээн урт сонсогдсон шүү. Мөнхбаясгалан гишүүн нэлээн олон гэмт хэрэгтнүүдийг нэрлэж байна. Энэ нэрс цаашаа маш урт үргэлжлэх ёстой гэж би бодож байгаа. Тантай бол зарим нэгэн зүйл дээр бас санал нэг байгаа. Олон хүмүүсийг нэрлэж болно. Тэр ч яах вэ, ажилдаа оръё.

Эхлээд 3 асуулт байна.

1 дүгээрт өнгөрсөн чуулган дээр яг энэ хэлэлцээрийг баталж байхад Дэлгэрсайхан сайд, Туваан сайд 2 1 амлалтыг өгөөд явсан. 20 сая тонн хүртэлх нүүрсийгээ гэрээний дүнгээр борлуулаад, түүнээс дээш гарсныг зах зээлийн үнийн дүнгээр борлуулъя гэж Улсын Их Хурлын индэр дээр хэлсэн. Тэр маань гэрээндээ орсон уу, үгүй юу гэдгийг хариулж өгөөч ээ гэж.

2-т нь нүүрсний гарцаа өргөтгөх ажил маань яг хэзээ дуусаж, хэдэн оны, хэдэн сард энэ нөгөө төмөр зам нь ашиглалтад орох вэ гэж. Иргэд маань сонирхож байгаа шүү дээ. Баахан юм яриад байх юм. Тэгээд энэ хэзээ орох юм гэж он, сар, өдөртэй нь хэлж өгвөл их сайн байна.

3 дугаарт нь Жавхлан сайдаас асууя. Миний өмнө зогсож байна. Уг нь Эдийн засаг, хөгжлийн сайд хариулах ёстой юм. Бид нар, Монгол Улс чинь олдог орлогынхоо 93 хувийг нь энэ нүүрс, зэсээр олж байгаа юм байна лээ шүү дээ. Хуучин ч тийм байсан. Хуучин бид нар Эрдэнэтийн зэсээр л хөөрхий төсвийнхөө орлогыг дийлэнхийг нь бүрдүүлж ирсэн. Одоо ч ойрын ирээдүйд ч гэсэн энэ нүүрс, зэсээр л амьдрах байх. Ер нь бидний ирээдүйн амьдралын гол орлого бол угаасаа энэ байх нь ойлгомжтой. Ямар ч ажил хийгээд бид нар огцом өөрчлөлтийг авчирч чадахгүй учраас Жавхлан сайд аа нэг ийм санаа байна. Та хариулж өгөөч гэж байгаа юм. Хэдүүлээ төсвийн зардлынхаа огцом өсөлтийг хязгаарлавал яасан юм бэ. Өнгөрсөн жил 27 их наяд байсан төсөв маань энэ жил 33 болсон. Бизнес эрхлэгчдийн маань хамгийн их хүсэж байгаа зүйл ханшийн тогтвортой байдал байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хангахын тулд төсвийнхөө зардлын огцом өсөлтүүдийг хязгаарлавал яасан юм. Төсвийн зардлын огцом өсөлтүүд чинь бүгдээрээ гадагшаа валют болж гараад байгаа байхгүй юу. Гүүр барьсан ч валют болж байгаа, машин худалдаж авсан ч валют болж байгаа. Тэгэхээр энэ төсвийн зардлынхаа огцом өсөлт дээр ирэх жил бодлого гаргаж, дахиж энэ 20 хувиар өсөх энэ тэр дээрээ бодолцвол яасан юм бэ. Магадгүй Эдийн засаг, хөгжлийн сайд л хариулах байсан байх л даа. Тэгээд энэ ханш алдаад байхаар нөгөө цалин, тэтгэврийн нэмэгдэл чинь үнэ цэнгүй л болчих гээд байна л даа.

Тийм учраас ирэх жилийн төсвийн бодлого дээр энийг бас анхаарч өгөөч ээ. Төсвийнхөө зардлыг нь хэдүүлээ бас жоохон хязгаарлавал яасан юм бэ л гэсэн ийм 3 асуулт байна. Дараа нь тодруулна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд эхэлж хариулъя. Дараа нь Борхүүгийн Дэлгэрсайхан сайд. Тэгээд Болдын Жавхлан сайд.

Ц.Туваан: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Таны тавьж байсан асуултыг энэхүү хэлэлцээрийн 5 дугаар зүйл заалтад оруулж өгсөн. Энэ дээр бол 2025-2029 онд нийтдээ 27 сая тонн гээд энэ бол эхний нөгөө төмөр зам ашиглалтад орох хүртэлх хугацаанд 5,5,5,6,6 гээд 27, тэгээд таны хэлж байгаа 20 сая тонныг бол 2030 оноос эхэлж борлуулна. Энэ бол борлуулах дээд талын хязгаарыг нь 20 сая тонн хүрээд, энэ гэрээний хэлэлцээрийн хүрээнд олборлох нүүрсний асуудал бол ингээд зогсоно гэж ойлгогдохоор 5 дугаар зүйл заалт дээр орсон шүү.

Тэгээд энэ зүйлийн дагаж гарсан 2 дахь бичиг баримт буюу протокол дээр энэ тоонуудаа бид нар зааж өгөөд, дээрээс нь олборлож байгаа нүүрсний агуулгын процентыг 55/35/10 буюу коксжих 55, 1/3-35, эрчим хүчний нүүрс 10 гэж зааж өгсөн.

Мөн Чайна Энержи групп урт хугацааны гэрээний энэ зүйл заалтуудаас гадна эрчим хүчний нүүрсийг нэмэлтээр худалдан авахад бэлэн байна гэдэг асуудлыг ярьсан. Тэгэхээр энэ хэмжээнүүдээс цааших асуудал бол бусад хууль тогтоомж, биржийн хууль, бусад гэрээ хэлцлийн хүрээнд хийгдээд явах боломжтой. Энэ бол дээд хязгаарыг тогтоосон зүйлийг 5 дээр зааж өгсөн гэдгийг танд хэль. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Төмөр зам яг хэзээ ашиглалтад орох вэ гэж. Бид өнөөдөр ингээд энэ гэрээ соёрхон батлагдвал, тендер зарлагдана. Тендерийг бол манай худалдан авах газар зарлана. Тендерийн хугацаа бол ойролцоогоор 1 сар орчим гэж тооцоход, бид тендерийн ялагч гараад, тэгээд энэ бүтээн байгуулалтын хил дамнасан бүтээн байгуулалтын үйл ажиллагаа 5 сарын 1-нд эхэлж чадвал бид нар 22 сар буюу 1,9 жилд барьж дуусгана гэж үзэж байгаа.

Тийм учраас 2027 оны 4 сар гэхэд энэ төмөр замыг холбож, ашиглалтад оруулна гэсэн ийм хугацаа байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Болдын Жавхлан сайд хариулт өгье.

Б.Жавхлан: Гишүүний асуултад хариулъя. Уул уурхайгаас орж байгаа орлого маань бол сүүлийн жилүүдэд нэмэгдэж байгаа. Мэдээж. Тэгэхдээ 93 хувь бол арай биш шүү. 93 хувь гэхихээр нөгөө салбаруудаа ерөөсөө байхгүй, ямар ч үүрэг рольгүй юм шиг тэгж бас бид нар орхиж харж болохгүй. Энэ чинь өөр маш олон манай эдийн засгийн салбарууд байна. Үйлчилгээ, худалдаа, харилцаа холбооны салбар, хөдөө аж ахуйн салбар гээд. Яах вэ, уул уурхайгаас бол шууд уул уурхайгаас орж байгаа нь 50 хувь руу дөхөж байгаа шүү. Шууд болон шууд бус нөлөөгөөр гээд 60, 70 хувь руу бол дөхнө. Гэхдээ бусад салбарууд маань бол бас өргөжсөөр, тэлсээр үүргээ биелүүлсээр байгаа шүү гэдгийг хэлье.

Төсвийн зардлаа бид цаашдаа хумья. Ер нь алдагдалгүй төсөв баталъя гэдэг ийм бодлого руугаа бид нэгэнт шилжчихсэн. Дараагийн 3 жилд бид нар ийм байна гээд хуульчилчихсан байгаа. Тэгэхээр өөрөөр хэлбэл бид орлогынхоо хэмжээнд төсвөө төсөвлөнө гэсэн үг. Та дахиад төсвөө хумья гэхээр бид төсвийг нь илүү их ашигтай гаргах тэр чиглэл рүүгээ ингээд явах нь. Тэгэхээр энд .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жавхлан сайдад 1 минут нэмж өгье.

Б.Жавхлан: Тэгэхээр энд бид хуулиуд дээр маш сайн ажилламаар байгаа юм. Засгийн газраас бараг дараа 7 хоногт байна уу даа бид өнгөрсөн төсөв батлах үед тогтоолоороо үүрэг авсан байгаа. Юу вэ гэхээр энэ төсвийн зардлуудыг шууд нэмээд байгаа энэ хуулиудаа эргэж харъя. Үүнийхээ судалгааг оруулж ир гэсэн байгаа. 40 гаруй хуулиар өнгөрсөн жилийн төсөв батлахад 4,5 их наяд шууд нэмэгдэж байна шүү гэдгийг харуулсан. Одоо цаана нь дахиад 2,5 их наяд шууд төсөв нэмэгдэхээр хуулиудын заалттай ийм зүйлүүд байгаа. Хэрвээ эд нарыгаа цэгцэлчих юм бол жил бүр шууд автоматаар хуулийн дагуу нэмэгддэг энэ төсвийн өсөлтүүд маань бол байхгүй болно. Ийм боломжууд бидэнд байгаа.

Дээрээс нь төсөв гэдэг маань өөрөө ер нь бол Засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэх л эцсийн үүрэгтэй. Тэгэхээр бид нар 4 жил ямар төлөвлөгөө батална, жилийн хөгжлийн төлөвлөгөө ямар хэмжээнд батална, энийг л бүрэн санхүүжүүлэх үүрэгтэй гэдгийг дахин хэлье.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Хил холболтын асуудал орж ирж байна л даа. Үргэлжлээд явж байна. Батлагдах шатдаа орж байгаа. Ер нь Ардчилсан нам болоод Ардчилсан намын бүлгээс өнгөрсөн хугацаанд худалдааг хөнгөвчлөх, тэр тусмаа экспортын боломж бололцоог нэмэгдүүлэх, тогтвортой урт хугацааны гэрээнд бий болох, дэд бүтцийг дэмжих энэ бүхий л бодлогыг өнгөрсөн хугацаанд тэр тусмаа энэ чуулганы хугацаанд бүрэн дүүрэн бас ингэж дэмжиж ирснийг бас хэлэх нь нь зүйтэй байх.

Тэгээд хэдийгээр дэмжиж байгаа ч гэсэн энэ дотроос бас анхаарах, онцгойлох бас тодруулах зарим зарим зүйлүүд бас байна. Хил холболтын асуудал, төмөр замын асуудал мэдээж тоо хэмжээг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэх байх. Тоо хэмжээнээс гадна энэ аливаа бизнес арилжаанд үнийн асуудал хамгийн чухал. Тэгэхээр яг үнэтэй холбоотой энэ гэрээнд ямар зүйлүүд орсныг ажиглаад харахаар бас тодорхой анхаарч үзэх ёстой зүйлүүд байгаад байна л даа. Үнэ гэдэг зүйлийг өнгөрсөн хугацаанд бид нар өрсөлдөөнд ил тод, нээлттэй болох, дэлхий нийтийн санхүүгийн арга механизм болсон биржийн арилжаа гэдэг зүйлийг оруулж ирсэн. Би бол энийг маш зөв зүйтэй л гэж боддог.

Гэтэл сүүлийн үед ер нь бирж гэдэг зүйл их л буруу байсан тухай, биржээс буцах тухай маш ихээр яригддаг болчихсон. Уг нь энэ бирж чинь урт хугацааны ирээдүйн тэр пьючерс арилжаа олон олон арга механизм хэрэгсэл энэ дотор байдаг. Бид нар тэр бүгдийг үгүйсгэж, ер нь бирж бол дэмий юм байна гэдэг 1 дүгээрт нь энэ өөрөө их буруу бодлого л гэж гэж. Сайжруулаад явах ёстой зүйлийгээ бид нар ингэж хойшоо ухралт бол буруу гэж боддог.

Тэгээд энэ гэрээн дээр шууд гэрээнүүд хийгдэнэ. Энэ соёрхон батлах гэж байгаа хэлэлцээрийн хүрээнд үнийг яаж тогтоох гэж байгаа юм бэ гэсэн чинь нэг

ийм зүйл эцсийн байдлаар орж ирж байна л даа. Нүүрсний урт хугацааны гэрээг энэ хил холболтын хүрээнд тогтохдоо анхны үнэ дээр нэмэх нь улирлын индексийн тодруулга, энэ 2 зүйлээс бүрдэх юм байна. Анхны үнэ гэдгийгээ үзэхдээ энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнөх үнийг авна. Тэгэхээр ингээд өнөө маргаашаас өмнөх үнийг анхны үнэд аваад, үндсэндээ 4 индексийн дунджаар тохируулга хийгээд явах юм байна. Тэгэхээр яг энэ 2 маань өнөөдрөөс өмнөх үнийг авна гэдэг чинь дэлхийн зах зээл дээр магадгүй сүүлийн хэдэн жилийн хамгийн доод үнэ. Энэ хамгийн доод үнэ дээр 4 биржийн үнээс тохируулга хийгээд авна гэхээр энэ чинь тийм урт хугацааны гэрээ хэлэлцээр хийхэд баримтлахад яг энэ аргачлал чинь хамгийн зөв юм уу. Ер нь урт хугацааны гэрээ хэлэлцээр Засгийн газар, парламентаар соёрхон баталж байгаа энэ хэлэлцээр дээр хамгийн доод үнийнхээ нөхцөл дээр гэрээг хийх зөвшөөрлийг өгөх гэж байгаа юм шиг. Тэгээд энэ дээр тайлбар өгөөч 1 дүгээрт нь.

2 дугаарт нь тэр улирлын индексийн тохируулга гэж байна. Энэ ийм 4 бирж, 4 бас бирж биш юм. 4 ийм үнийн өөрчлөлтийг хувийн жин өгчихсөн юм байна л даа. Жишээ нь энэ дотор чинь одоо тэгээд Сингапурын биржийн үнэ энэ тэр гээд л гаднынхыг болохоор биржийн дунджийг энэ тохируулгад аваад байдаг, өөрийн биржийг үүсгээд байдаг, биржийн үнэ үүсгээд байдаг. Тэр ам нөхцөл, хуучин чинь ам нөхцөлийг болиод хил нөхцөлийг их сайн зүйл боллоо гэж байсан. Одоо буцаад ам нөхцөл рүүгээ орж байгаа. Тэгэхээр энэ үнэтэй холбоотой, үнэ тооцох аргачлалтай холбоотой энэ зүйл чинь тийм зөв зүйтэй байна уу. Энэ дээр тайлбар өгөөч ээ.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Цогтгэрэл даргын асуултад хариулъя. Бид нар энэ хэлэлцээр батлагдсанаар шууд дараагийн буюу Улсын Их Хурал, Засгийн газраас гарах шийдвэрүүд ингээд дуусаж байгаа юм. Тэгээд дараагаар нь шууд компани хоорондын гэрээ рүү орж байгаа. Компани хоорондын гэрээний 2 дахь нь бол нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ буюу энэ онд 5 сая тонн нүүрс худалдах, худалдан авах гэрээ рүү орно. Энэ нүүрсийг шууд бэлэн мөнгөөр зарна. Тэгэхээр бид нар бас Улсын Их Хурлын гишүүд маань, Байнгын хороод маань бас маш яаралтай баталж өгсөн. Энэ үндсэн чиглэл яаралтай байгуулсан хэлэлцээр маань бол маш цаг үеэ олсон ийм бичиг баримтууд болж байгаа. Яагаад гэхээр энэ хугацаанд энэ цаг үед бол дэлхийн зах зээл дээр олон улсын худалдааны асуудал Трамп тарифаас болоод энэ гангийн экспорт, нүүрсний үнэ бол тогтворгүй болж ирж байгаа. Тэгэхээр олон улсын зах зээл дээр нүүрсний үнийг урт хугацаандаа тогтвортой байхаар ийм байдлаар зохицуулдаг ийм жишиг байгаа. Тэгэхдээ бид нар энэ гэрээ хэлэлцээрийнхээ 2 дээр бол таны саяын хэлсэн анхны үнэ дээр нэмэх нь хамтарч сонгож авсан улирлын индексийн тохируулга гээд энэ дээр манай экспорт хийж байгаа буюу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 5 боомтын үнийн мэдээллийг, энийг шууд биржийн үнэ гэж ойлгож болохгүй. Энэ дээр гарсан үнүүдийн мэдээллийг аваад процентолж дундажлаад, энэ үнийг гаргаж байгаа. Тэгэхээр өнөөдрийн байдлаар яг үнэндээ бол бирж дээр маань арилжаа сайн явж эхлээгүй байна. Удахгүй бас идэвхжих чиг хандлага байна. Тэгэхдээ өнөөдрийн урт хугацааны гэрээнүүдийн үнэ бол биржийн дуудаж байгаа үнээс бол дээшээ гарчихсан байгаа гэдгийг хэлье. Манай бирж дээр өнөөдөр коксжих нүүрсний ханш, дуудах үнэ бол 91ам.доллар-той байгаа. Тэгэхээр энэ дотор нүүрсний үнэ дээр нэмэх нь хил хүргэх логистикийн үнэ орчихсон байгаа гэдгийг бас хэлье.

Тэгэхээр ер нь бол урт хугацаандаа гэрээгээ бид нар хэрвээ энэ хэлэлцээрээ өмнө байгуулаад явчихсан байсан бол үнэ их өндөр үед бас энэ гэрээнүүд байгуулагдаад явах ийм боломж байжээ гэж харж байгаа.

Биржийн тухай хууль бол зогсоох асуудал байхгүй. Сайжруулаад, засах зарим зүйл байвал нэмээд явна. Бид нар Засгийн газрын хуралдаанаар Уул уурхайн биржийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрээ өчигдөр батлаад, Улсын Их Хуралд өргөн барина. Энэ дээр бол нөгөө яг амьдрал баян учраас шинээр гарч ирж байгаа нөхцөл байдал. Тухайлах юм бол нүүрсний үнэ унаж байх үед ямар зохицуулалт байх юм. Унах, өсөх аль алинд нь нүүрсний индексийн асуудлыг яаж уялдуулж өгөх юм. Дээрээс нь энэ тээвэртэй, тээвэргүй үнээр борлуулах асуудлыг компаниуд маш их тавьж байгаа. Энэ асуудлыг бол оруулж өгөх гэсэн зүйлүүдийг оруулаад, Уул уурхайн биржийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөө Засгаар хэлэлцүүлээд Их Хурал руу хүргүүлсэн байгаа гэдгийг бас хэлье.

Д.Амарбаясгалан: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Тэгэхээр их тийм тодорхой асуулт байна л даа. Анхны үнэ гэдэг чинь одоо бараг та нар тооцоод, бараг тохиролцчихсон байх ёстой цаг үе юм байна. Яг энэ гэрээ дээр зааж байгаагаар хэлэлцээрт гарын үсэг зурах өдрөөс өмнөх үнийг анхны үнэ гэнэ. Анхны үнэ дээр нэмэх нь тохируулгатай үнийг авна гэж. Тэгэхээр өнөөдрөөс өмнөх үнийн чинь анхны үнээр та нар бараг тогтчихсон байх цаг хугацаа байна шүү дээ. Тэгэхээр энэ нүүрсний үнийг нь гэрээн дээрх анхны үнэ гэдэг нь тонн нь хэдэн доллар юм. Ямар нөхцөлтэй, хэдэн доллар юм.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Яг өнөөдөр манай “Эрдэнэс Тавантолгой”-н нүүрсийг 2 шугамаар борлуулж байгаа. 1 нь бол уул уурхайн биржээр арилжаа явуулж, борлуулж байгаа, нөгөөдөх нь бол өмнө нь байгуулсан урт хугацааны тогтвортой 4 компанитай хийх Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит 4 компанитай хийсэн гэрээний нүүрсний борлуулалт гэсэн ийм зүйл явж байгаа. Энэ үнэ бол эдгээр компаниудтай байгуулсан гэрээний үнийг жишиг болгоод явж байгаа ийм үнэ. Улирал тутам хөдөлдөг, өөрөөр хэлбэл тэр индексүүдийнхээ үнийг харж байгаад хөдөлгөж, өссөн үед нь өсдөг, буурсан үед нь бууруулдаг ийм үнэ. Анхны үнэ өнөөдрийн байдлаар тогтвол 69ам.доллар-той тэнцүү байгаа.

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Гашуун сухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны гээд Засгийн газар хоорондын гэрээ орж ирж байна. Энэ түүх яривал маш их түүх ярина. Тэнд 15 жил гэж байна. Тэгээд нарийвчлаад яривал энэ 2012 онд төмөр замын асуудал анхных нь гэрээг хүртэл миний бие үзэглээд ингээд явж байсан. Энэ гэрээнээс хойш төмөр зам маань 2016 онд ашиглалтад орно л гэж байсан. Үгүй ээ, мөн их хол байна шүү л гэж байсан. Одоо 2016-аас хойш 2022 онд ашиглалтад орлоо. 2022 оноос хойш өнөөдөр хүртэл яригдаад 2027 оноос ерөнхийдөө холболтод орох нь байна шүү дээ. Тийм болохоор энэ бас хэдийгээр цаг хугацаа хойшлогдоод орж ирж байгаа ч гэсэн зайлшгүй бид нарын шийдээд явах нэг ийм асуудал байгаа юм. Дээрээс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улстай тэгээд хийсэн гэрээнүүд янз янзын гэрээ. Үндсэндээ бид нар урьд өмнө нүүрсээ ганзагын

байдлаар зарж байсан улс шүү дээ. Одоо бол Засгийн газар хоорондын гэрээгээр нүүрсээ зарж байгаа. Борлуулах гэж байна. Тэгээд энэ гэрээн дээрээ нүүрснийхээ хэмжээг яг заагаад оруулж ирэх 1 дүгээрт боломж байхгүй байсан уу гэж энийг асуух гээд байна.

2 дугаарт яг Засгийн газрын хооронд хэдэн сая тонн нүүрсийг ямар хугацаанд зарах юм бэ. Цаг хугацаагаараа хэмжигдээд байгаа юм уу, жилээрээ хэмжигдээд байгаа юм уу. Хэдэн сая болох юм. Хэдэн жил үргэлжлэх юм. Энэ чинь ерөөсөө орж ирэхгүй байна шүү дээ. Улсын Их Хурал дээр орж ирж байгаа юм бол энэ тоонууд чинь бүтэн орж ирээд, бүр танилцуулгатай орж ирмээр байгаа байхгүй юу даа.

2 дугаарт 20-25 сая тонны хүчин чадалтай л байх ёстой энэ төмөр зам. Одоо 20 сая гэж байгаа юм байна 1 дүгээрт. 2 дугаарт энэ жилийн 20 сая гэсэн байгаа юм чинь 20 саядаа бид нар төмөр замаараа нийт гэрээнийхээ дагуу тээвэрлэлтээ хийчих юм бол нөгөө аж ахуйн нэгжүүд чинь Дэлгэрсайхан сайд хэдэд нь гаргах юм. Төмөр замаараа гаргах ийм бололцоо байх юм уу. 25 сая байж байгаад 20-ийг нь Засгийн газар хоорондын гэрээгээр зарчхаад, цаана нь дахиад аж ахуйн нэгжүүд чинь яаж гаргах юм.

Тэгээд нөгөө Тавантолгой компанийн өмчлөлд байж байгаа авто замаа ашиглах юм уу.

Тэгээд 3 дугаарт ер нь Туваан сайд нийт ер нь Гашуунсухайт боомтоор төмөр замтай, авто замтайгаа нийлээд бид нар ойрын хугацаанд ер нь хэдэн сая тонн нүүрс гаргах юм. Тэгээд авто замаа ер нь ямаршуу байдлаар ашиглах юм гэсэн ийм асуудлууд байна.

Дэлгэрсайхан сайд энэ ачиж буулгах аж ахуйнууд чинь яг ном дагуу жишээ нь манайхаас гаргаж байгаа нь бол нөгөө талдаа, нөгөө талаас орж ирж байгаа ачаа нь бол манай талдаа гээд яг дүрмийнхээ дагуу гаргаж байгаа юу. Урьд нь бас янз янзын сайд нарын үед бол өөр тийм томъёолол яригдаад байсан. Энэ дүрмийнхээ дагуу хийгдэж байна уу, үгүй юу.

3 дугаарт сая тайлбарлаад л байна. Ганбаатар сайдын үед оруулж ирсэн энэ Уул уурхайн биржийн тухай хууль шүү дээ. Уул уурхайн биржийн тухай хууль би ажлын хэсгийг нь ахлаад, ер нь бол Монгол Улсад эдийн засгийн хүрээнд тэр тусмаа болуул уурхайн бирж байгуулж, уул уурхайгаас гарах бүтээгдэхүүнээ биржээр орох ямар нэгэн авлигал хээл хахууль юу байдаг юм тэр аж ахуйн нэгжүүд нь өөрсдөө цаашаа харж байгаад гэрээ хийгээд явчихдаггүй ийм тогтолцоо руу бид нар орсон шүү дээ уг нь бол. Тийм үү. Тэгээд энэ яг юу нь бас болохгүй болчихоод байгаа юм. Ер нь цааш цаашдаа хэдэн сая тонн нь жишээ нь ийм уул уурхайн биржээрээ бид нар ном дүрмээрээ явах ийм боломж бололцоо байна. Сая бас хэлээд л байна. Ер нь Уул уурхайн биржийн хууль ч бас тийм ч сайн хууль биш болчихлоо эд нар гэсэн ер нь бол манайд тохирохгүй хууль байна уу даа гэсэн ярианууд бас нэлээн гараад ирж байна шүү дээ. Сая ч бас Цогтгэрэл гишүүн хэлж л байна. Тэгэхээр цааш цаашдаа бид нар яг тулсан тухайн зах зээл нүүрс унана уу, өснө үү, үүнтэйгээ уялдаад хамгийн дээд хэмжээнийхээ үнээр бид нар биржээр үнэ хаялцуулаад зарах ийм боломж бололцоо чинь гарсан байх ёстой шүү дээ. Тэгээд энийгээ хангаад ингээд явж байгаа зүйл байна уу гэсэн ийм асуулт.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Нүүрсний хэмжээ, хугацааг хэлэлцээр дээр тодорхой зааж өгсөн. Энэ хэлэлцээрийн 5 дугаар зүйл дээр 2025-2029 онд 27 сая тонн, 2030 оноос эхлэн 1 жилд 20 сая тонн нүүрс гэж оруулж өгсөн. Энэ гэрээний маань хугацаа нийтдээ 16 жил байгаа. Тооцох юм бол нийтдээ 247 орчим сая тонн нүүрсний асуудал яригдана гэдгийг танд хэлье.

Мөн протокол дотроо бид нар энэ асуудлуудаа бүр он оноор нь 2025 онд 5 сая гээд, он оноор нь бүгдийг нь заагаад өгчихсөн. Мөн зарагдаж байгаа нүүрсний 100 хувь гэж үзэх юм бол түүний 55 хувийг нь коксжих, 35 хувийг нь 1/3-ийг нь коксжих, 10 хувийг нь эрчим хүчний нүүрс байна гэдгийг бас зааж өгсөн. Компани ч гэсэн эрчим хүчний нүүрсийг бол бид нар боломж байвал илүү худалдаж авъя гэсэн ийм зүйлүүдийг протоколд тусгаж өгсөн гэдгийг хэлье.

Уул уурхайн биржийн тухай хууль бол үүргээ гүйцэтгэсэн бөгөөд өнөөдөр хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль. Тэгэхдээ амьдрал баян учраас уул уурхайн бирж дээр баталж өгсөн зарагддаг нүүрс, зэс, жонш, цайр гээд энэ бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээлийн худалдаалагдах үнэ өсөж байгаа үед бол энэ болж байгаа юм. Яг өнөөдрийнх шиг ийм буурч байгаа нөхцөл байдал дээр тохируулга заалтууд, тухайлах юм бол үнийг индексжүүлж өгөх, зохицуулалт хийх заалт оруулж өгөөгүйгээс болоод энд оролцох компаниуд байхгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр энэ зүйл заалтыг бас бид нар оруулж өгч байгаа.

Дээрээс нь мөн тээвэртэй, тээвэргүй гэдэг дээр манайд энд оролцож байгаа бүтээгдэхүүнүүдээ зарж байгаа төрийн болон орон нутгийн өмчит компаниудын зүгээс бол бид нарын зүгээс тухайлах юм бол Дархан төмөрлөг дээр бид нар энэ вагоны олдоцтой холбоотой асуудлаас болж нөгөө биржээр борлуулсан бүтээгдэхүүнүүдээ хүргэж өгөх асуудал дээр асуудал үүсэж байна энэ тэр гээд ийм тээвэртэй, тээвэргүй холбоотой асуудал дээр зохицуулах ийм шаардлага байгаа учраас бид нар өчигдөр Засгийн газрын хуралдаанаар Уул уурхайн биржийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг оруулж ирсэн. Тун удахгүй бас Улсын Их Хурлын чуулган дээр оруулж ирнэ гэж бодож байгаа. Өндөр үнэтэй байх үед биржээр худалдаа тэгээд авчихсан компаниудын нүүрс хилийн цаана “Монголын Эрдэнэс” Тавантолгой компанийн хүргэж өгсөн терминалууд дээр дүүрчхээд энэ компаниуд цаад унасан үнээр нүүрсээ борлуулж чадахгүй байгаагаас шалтгаалаад, тэнд нүүрс хүлээн авах боломжгүй болчихоод байгаа юм. Маш бага хэмжээний орон зай үлдсэн. Энэ зайдаа хүлээн авалт хийгээд, цаашаа тээвэр явж байгаа учраас нэлээн ийм гацалттай асуудал үүсээд байгаа. Энэ асуудлыг шийдвэрлэх буюу экспортыг нэмэгдүүлэх ажлын хэсэг Сангийн сайдаар ахлуулан ажиллаж байгаа. Тэгээд энэ асуудал дээр арга хэмжээ авсны дүнд биржээр худалдаалах нүүрсний хэмжээ сэргэх хандлагатай байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмэлт хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ төмөр зам холбогдоод тээвэрлэлт эхлэхэд бол та өөрөө бас Зам, тээврийн сайд байсан хүний хувьд төмөр замын хүчин чадлыг маш сайн мэдэж байгаа. Энэ төмөр замаар ямар ч байсан уурхай дээрээсээ бол шууд 20-25 сая тонн нүүрс ачигдана. Дээрээс нь бол зөрөөд нарийн царигийн төмөр зам орж ирж байгаа. Тийм учраас нарийн царигийн төмөр замаар бид бас мөн ялгаагүй 20 сая тонн нүүрс ачна гэж байгаа. Нийтдээ бол

ойролцоогоор 2 төмөр замаараа нийлээд 45-50 сая тонн нүүрс ачих ийм боломж бололцоотой гэж үзэж байгаа.

Авто тээврийн хувьд бол зэрэгцээд явна. Өнгөрсөн хугацаанд явж байсан авто тээвэр бол бас мөн ялгаагүй хэвээрээ үргэлжилнэ гэсэн үг. Ингээд бид .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Туваан сайд аа, нийт Гашуунсухайтын боомт, төмөр зам, авто зам ойрын хугацаанд ер нь 10 жил, 20 жилийн хугацаанд хэдэн сая тонн гарах юм. Төмөр замаараа хэд нь гарах юм. Авто замаараа хэд нь гарах юм. Яг нөгөө олборлож чадах хүчин чадалтай таарч байна уу гэдгийг чинь л сонсмоор байгаа байхгүй юу даа. Хэдэн тонныг бид нар экспортод гаргах юм бэ.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Энэ төмөр зам ашиглалтад орсноор саяын Дэлгэрсайхан сайдын хэлснээр өргөн царигийн төмөр замаар уурхай дээрээс бид нар 25 сая тонн орчим нүүрсийг тээвэрлэж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд байгаа өргөн цэргийн терминал дээрээ буулгана. Зөрж орж ирж байгаа төмөр зам маань мөн хэмжээний нүүрсийг нарийн царгийн төмөр замаараа аваад, ямар нэгэн терминал хэрэглэхгүйгээр шууд явна.

Өнөөдрийн байдлаар 2024 оны гүйцэтгэлээр 83 сая тонн нүүрсийг борлуулсан. Үүний 40 сая тонн нь бол Гашуунсухайт боомтоор гарсан. “Эрдэнэс Тавантолгой” компанийн олборлолтын хүчин чадал 30 сая тонн байгаа. Уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлснээр энийг 1 дахин өндөрсгөх ийм боломж байгаа. 2030 оноос хойш Монгол Улсын нүүрсний экспортыг 160 сая тоннд хүргэнэ гэж үзэж байгаа. Энэ 160 сая тонны талыг нь буюу 80 сая тонныг нь Гашуунсухайт-Ганцмодны авто болон төмөр замаар экспортолно гэж тооцоолж байгаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууя.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Гэрээний энэ 2-т нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ гэдэг дээр нүүрсний үнэ унасан бас 1 шалтгааныг би одоо л ойлгож байна. Энэ гэрээ соёрхон батлахтай холбогдуулж, Улсын Их Хурлаар хэлэлцэхтэй холбогдуулж, нүүрсний үнийг бас зориуд бууруулсан юм байна гэж би хувьдаа ойлгож байгаа. Яагаад гэхээр та бүхэн энэ гэрээндээ анхны үнээ хэлэлцээрт гарын үсэг зурахаас өмнөх өдрийн ханшаар тооцно гээд оруулчихсан байгаа байхгүй юу.

Тэгэхээр манай нүүрс оргил үедээ хэд байлаа, өнөөдөр хэд болчихсон байна. Тэгээд цаад тал чинь энийг хараад, ингээд бас нүүрснийхээ үнийг бууруулж байгаад он гарангуут зориудаар, тэгээд энэ соёрхон батлах энэ хугацаанд анхны үнээ хямдаар тооцох ийм л бизнесийн арга ухаан байсан юм уу гэж би харж байгаа юм.

Тэгэхээр Туваан сайдаас үүний зөрөөнд бид нар ямар алдагдал хүлээх ийм эрсдэл үүсэж байна. Зүгээр дундаж оны өмнө өгч байсан үнээрээ энэ гэрээг хийсэн бол анхны үнээ тооцсон бол. Гэтэл өнөөдөр нүүрс чинь 70, 80 руу ороод ирчихсэн байна. Энийг анхны үнэ гэж тооцвол энэ хоорондын зөрүүнээс бид нар ямар

хэмжээний алдагдал үүрэхээр байна вэ. Энийг тооцож үзсэн үү. Энийг та хариулж өгөөч.

2-т энэ Гашуунсухайт бол яг үндсэндээ өнгөрсөн 4 жилийн чинь 2 жил гаруй нь ковидтой үе байсан. 1 мянга гаруй жолооч нар үндсэндээ энэ 2 жилийн эдийн засгийн хүндрэлийг авч гарсан. Улс орныг тэжээсэн. Тэгэхээр энд ерөөсөө энэ гэрээний хажуугаар энэ жолооч нарын асуудал ерөөсөө яригдахгүй байгаа. Цаашдаа ер нь энэ жолооч нарын хувь заяа яах вэ. Энэ чинь өчнөөн олон хоног ар гэрээсээ хол, машины кабин дотор, байгаль, цаг агаарын, эрүүл мэнд, амь насны ч гэдэг юм уу маш эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байгаа жолооч нарын асуудал байгаа. Эд нар ер нь би ойлгох нь 1,9 жилийн дараа бол ажилгүй болох юм байна гэж ойлгож байгаа. Зөв үү. Энэ жолооч нарын хувь заяаны асуудлыг бас цаашид яаж харж үзэх вэ гэж.

Төмөр зам ашиглалтад орсноор энэ өмчлөл нь хэний өмчлөлд байх юм. Цаашдаа ашиглалтад хэн хариуцаж явах юм.

4-д би Мөнхбаясгалан гишүүнтэй бас ойролцоо асуулт асуух гээд байна. Хариуцлагын асуудал. Сая Алтангэрэл сайдын хариулж байгаагаар бол үндсэндээ хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэдгээр хариуцлагын асуудлыг ингээд дуусгаж байгаа юм байна л даа. 15 жилийн хугацаанд бид нар энэ төмөр замыг ашиглалтад оруулсан бол Монгол Улсын эдийн засагт, говийн бүсийн байгаль орчны экологид гээд олон талын давуу байдлыг гэдэг юм уу, ашигтай байдлыг хүртэх бололцоо боломж байсан. Түрүүнд бас нэр бүхий хүмүүсийг нэр усаар нь дурдаж байх шиг байна лээ. Магадгүй би бас энэ дотор тэр гацаасан хүмүүсийн мэр сэр зарим нэг нь сууж л байгаа гэж ойлгож байгаа. Тэгээд ингээд чимээгүйхэн сууж байгаад хариуцлагаас мултрах нь л дээ. Тэгээд огт хариуцлагын асуудал яригдахгүй юм байна гэж ойлголоо. Энэ дээр нэг хариулт тайлбар өгөөч. Ийм 4 асуулт.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд энэ үнэтэй холбоотой асуудлаар ойлгомжтой мэдээлэл гишүүдэд өгчихсөн нь зөв байх аа. Дараа нь Дэлгэрсайхан сайд хариулт өгнө.

Ц.Туваан: Энэ үнэтэй холбоотой асуудлыг би бас дахиж Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Бүр заалтуудаар нь уншиж өгье. Энэ хэлэлцээрийн 4 дүгээр заалт дотор Гашуунсухайт-Ганцмод чиглэлийн төмөр замын тээврийн багтаамж, эдийн засгийн үр өгөөжийг хангах зорилгоор нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээний үнийг тогтоохдоо “Эрдэнэс Тавантолгой” компанийн урт хугацаатай байгуулсан гэрээний нөхцөл, үнийн аргачлалыг жишиг болгож, гэрээний хугацааг хэлэлцээ хийж эхэлсэнтэй уялдуулан 16 жилээр тогтоох гэж байгаа юм. Энэ дээр ерөөсөө өчигдрийн үнэ энэ тэр гэсэн өмнөх өдрийн үнэ гэсэн үг, өгүүлбэр ерөөсөө байхгүй. Би түрүүн хэлсэн Тавантолгойгоос зарагдаж байгаа нүүрс маань 2 замаар зарагдаж байгаа. Нэг нь уул уурхайн биржээр арилжаалагдсан үнээр, нөгөөдөх нь бол өмнө нь байгуулагдсан урт хугацаатай гэрээ байгуулсан 4 гэрээний нүүрсийг өгөх гэсэн ийм байдлаар явагдаж байгаа.

Тэгээд энэ гэрээнүүдийн хамгийн сүүлд баталгаажсан үнэ дээр нэмэх нь нөгөө сонгогдсон индексүүдийн тохируулгыг ашиглаж энэ үнэ бүрдэнэ гэж ингэж ойлгож болно. Дээрээс нь эдгээр тогтвортой хийгдсэн 4 гэрээний үнэ бол тээврийн зардал ороогүй үнэ байгаа. Биржээр арилжаалагдаж байгаа үнэ бол Хятадын талын боомт дээр очиж, буулгаж өгөх хүртэл үнэ орсон байгаа. Тэгэхээр хүмүүс энэ тээвэргүй

үнийг нь хараад ийм хямд үнээр борлуулж байгаа юм байна гэдэг ийм ойлголттой болдог.

Яг бодит байдал дээр өнөөдөр биржээр зарласан байгаа үнэ бол коксжих нүүрс дээр 91 долларын үнэтэй, 1/3 коксжих дээр 67,8 долларын үнэтэй, эрчим хүчний нүүрс дээр бол 40,7 долларын үнэтэй байгаа. Энэ үнүүд дотор хил хүртэлх хүргэлтийн буюу DAF нөхцөлийн тээврийн үнүүд орсон үнэ байгаа. Тэгэхээр энэ 2-ын зөрүү гэж ингэж ойлгогдоод байна. Өнгөрсөн мэдээж онууд дээр бол нүүрсний үнэ бол янз бүр байсан. Дундаж нүүрсний үнэ бол 120 орчим доллар байсан. Бид нар төсөв дээрээ бол 105 доллароор авсан. Өнөөдрийн байдлаар бол нүүрсний дундаж үнэ бол 80 доллар орчмын хэмжээтэй байгаа гэдгийг хэлье. Жолооч болон төмөр замтай асуудлыг Дэлгэрсайхан сайд.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Жолооч нарын асуудлын хувьд бол машины тээвэр бол цаашдаа үргэлжилж хийгдэнэ. Тэгэхээр зэрэг үүнтэй холбогдуулаад сая Засгийн газраас томилогдсон экспортыг сайжруулах ажлын баг өнгөрсөн 7 хоногт Гашуунсухайт дээр ажилласан. Энэ ажиллах хугацаандаа бол мөн жолооч нарын нийгмийн асуудлыг шийдэх дээр бол нэлээдгүй анхаарч, Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу жишээлбэл Хайрхан баг дээр суурьшлын бүс байгуулах, ялангуяа тэнд ажиллаж, амьдарч байгаа уурхайн ажилчдаас эхлээд төмөр замын ажилчид, мөн жолооч нарыг орон сууцжуулах, цэцэрлэгтэй болгох хүүхдүүдийг нь, мөн дээрээс нь эмнэлэг байгуулах гээд энэ асуудлуудыг бол бид газар дээр нь яриад ирсэн. Тэгээд эмнэлгийг бол Жавхлан сайд энэ онд нь мөнгийг нь гаргаад, хамгийн түрүүнд эмнэлгийн асуудлыг шийднэ гэдгийг хэлсэн.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд гүйцээж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Энэ Тавантолгой төмөр замыг барьж байх энэ төсөв дотор бол Тавантолгой төмөр замын ажилчдын байрыг барих 17 сая доллар байгаа гэж ярьж байгаа. Энэ мөнгөөр бол бид аль болохоор төмөр замын ажилчдын байрыг барьж, суурьшлын бүсийг илүү болгоно гэж.

Төмөр замын хувьд өмчлөл нь бол хэнд байх юм бэ гэж. Өмчлөл нь бол Тавантолгой компанид байна. Энэ төмөр замын ашиглалтыг бол Монголын Төмөр зам менежментийг нь хийж явна. Мэргэжлийн компанийн хувьд бол ингэж Засгийн газар шийдсэн. Цаашдаа бол төмөр замын арчлалт хамгаалалт, ачаа тээвэр бүх асуудлыг бол Монголын Төмөр зам шийдэж явна гэдгийг хэлье.

Тэгээд бид бол аль болохоор бас өөрийн чинь хэлдгээр энд ажиллаж амьдарч байгаа хүмүүсийн, жолооч гэлтгүй бүх л хүмүүсийн нийгмийн асуудлыг шийдэхийн төлөө Засгийн газар бас ажлын хэсэг байгуулаад ажиллаж..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууя.

Ц.Сандаг-Очир: Үгүй ээ, Туваан сайд аа би маш тодорхой асуулт асуусан шүү дээ. Оны өмнөх 120 доллартой байсан тохиолдолд өнөөдөр бид нар гэрээгээ хийвэл анхныхаа үнийг тэндээс тооцвол бид нар цаашдаа ямар хэмжээний орлого олж болох вэ. Өнөөдөр уначихсан байгаа тохиолдолд 80 доллароор тооцоход энэ 2-ын

хоорондын алдагдал хэд вэ. Тэгээд бид нар бол бас л нөгөө талдаа монжуулж байна л гэсэн үг шүү дээ. Алдагдалтай л гэрээ байгуулж байна гэсэн үг. Яагаад гэхээр цаад тал чинь зориудаар нүүрснийхээ үнийг унагаж байгаад л энэ гэрээг хийлгэж байна шүү дээ. Яагаад гэхээр та бүхэн гэрээндээ болохоор анхны үнийг нь гэрээ байгуулахын урьдах өмнөх өдрөөр тооцно гээд л оруулчхаж байгаа байхгүй юу.

Тэгэхээр цаадуул чинь үнээ унагаж байгаад л зориуд, хаанаасаа тооцох вэ гэдэг. Тэр таны нэмэгдэл юу гэдэг юм, хамтран сонгож авсан улирлын индексийн тохируулгыг чинь ойлгож байна. Анхны үнийг чинь би асуугаад байна шүү дээ. Энэ хоорондын зөрөө та нарт эдийн засгийн тооцоо байна уу, үгүй юу. Ямар хэмжээний .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Энэ үнэ бол дэлхийн худалдааны дайн, Трамп тарифтай холбоотойгоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын экспортын гангийн бууралттай холбоотой үнийн уналт. Манай энэ Гашуунсухайт-Ганцмодны хил холболттой унаж байгаа бол үнэ биш ээ. БНХАУ жилдээ 4 орчим тэрбум тонн нүүрсний хэрэглээтэй ийм улс. Манайхаас орж байгаа 80 сая тонн бол энэ хэрэглээний ердөө 2 хувь.

Тэгэхээр манайд зориулаад бусад бүх хүнээ унагана гэдэг ойлголт бол байхгүй. Анхны үнэ гэдэг үнэ бол хөдөлдөг үнэ. Энэ бол нэг тогтоочихсон үнэ биш. Өмнөх өдрийн үнэ гэсэн ойлголт байхгүй. Олон улсын практикт бол энэ нүүрсний худалдааг урт хугацаанд тогтвортой байдлаар хийдэг. Яг өнөөдрийн байдлаар харах юм бол энэ урт хугацааны гэрээнүүдийн үнэ, биржийн үнээс өндөр байгаа гэдгийг танд хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Банзрагчийн Түвшин гишүүн асуулт асууя.

Б.Түвшин: Өнөөдөр Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын хэлэлцээрийг соёрхон батлах гээд хэлэлцэж байна. Үнэхээр энэ хэлэлцээр олон жилүүдийг давж туулсан бас энэ хамтарсан Засгийн газрын бас нэгээхэн томоохон амжилт гэж бас хэлж болох байх. Манай Монгол Улсын хувьд бас үнэхээр худалдааны болон гадаад хамтын ажиллагааны бас өндөр ач холбогдолтой гэдэг талаас нь бол дэмжиж байгаа.

Энэ дээр холбогдуулаад ер нь бол 2 тодруулах, нийтэд мэдээлэл өгөх 2 асуултыг асууя гэж байгаа. 1 дүгээрт энэ 3-ыг цогцоор гээд ийм зарчим орж ирж байгаа. Хүмүүс бол ихэвчлэн төмөр замыг 2 талаасаа уулзварыг байгуулах тухай, төмөр замын бүтээн байгуулалтын тухай ойлгож байгаа. 3-ыг цогцоор чинь бол эхнийх нь хил дамнасан төмөр зам байгаа. 2 дахь нь бол нүүрсний худалдаа. 3 дахь нь Тавантолгойн нүүрсний хүчин чадлыг нэмэгдүүлэх гэж байгаа. Тэгэхээр энэ нүүрсний худалдааны асуудал, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх асуудал яагаад заавал ингэж 3-ыг цогцоор буюу энд хамт орж ирж байгаа юм бэ. 1 дүгээр асуулт.

2 дугаар асуудалд нүүрсний худалдаа нь өөрөө энэ төмөр замын бүтээн байгуулалтыг дагаж орж ирж байгаагаараа дэлхийн зах зээлийн үнэ дээр цаашдаа тогтоод явах, Монгол Улсын эрх ашиг хамгаалагдаж чадах уу гэдэг 2 дугаар асуулт.

Гуравдугаарх нь Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гээд байгаа. Мэдээж яг төмөр замын бүтээн байгуулалт явахаар нүүрсний экспорт нэмэгдэнэ. Тэгэхдээ энэ нь өөрөө яг энэ хэлэлцээр дээр дагаж орж ирж байгаа нь ямар учиртай юм бэ. Энэ манай талын санаачилга мөн үү. Манай Улсын үндэсний эрх ашиг, энэ дээр яг баттай хамгаалагдаж чадах уу гэсэн ийм 3, 4 асуултыг асууя.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Энэ бол маш урт хугацаанд яригдсан ийм асуудал. Тэгээд бас янз бүрийн шалтгаанууд байсан. Тэрийг бид нар өнөөдөр энэ маш олон Байнгын хороо, Улсын Их Хурлаар хэлэлцүүлэгдэх энэ шатанд бол бүгд ойлголцотой байгаа учраас энэ богино цагт бол ярьж амжихгүй байх.

3-ыг цогцоор гэдэг энэ зарчим бол яг энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийн 2 дугаар зүйл заалт дээр орсон. Энэ нь бол таны хэлсэнчлэн эхнийх нь бол Гашуунсухайт-Ганцмодны төмөр замын хил дамнасан холболтын асуудал, хоёрдугаарх нь нүүрс худалдах, худалдан авах гэрээний асуудал, гуравдугаарх нь уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэсэн ийм 3 асуудал байгаа.

Тэгэхээр энэ асуудалд 3-ыг цогцоор гэдэг энэ зарчим бол 2014 оны 2 улсын Ерөнхийлөгчийн зурсан бичиг баримтын үеэс бас яригдаж эхэлсэн. Олон улсын практикт байдаг асуудлуудыг энэ цогцоор авч үздэг ийм асуудал. Тэгэхээр энэ үеэс эхэлсэн тухайлах юм бол нэмж хэлэхэд бас ОХУ-тай бид нар өнгөрсөн намар Путин Ерөнхийлөгчийг ирэхэд нефть бүтээгдэхүүний хангамж, онгоцны түлшний асуудал 2-ыг ч гэсэн бас ингээд хамтад нь цогц буюу пакетын байдлаар ингээд авч үзсэн гэдэг ийм жишгүүд байдаг. Өмнө нь энэ асуудлууд тусдаа явахаар манай улсын байр суурь яг 1, 1-ээр нь явахаар хоорондоо уялдаж өгөхгүй, нэгнийх нь асуудлыг буюу тухайлах юм бол төмөр замын асуудлаа хийгээд бариад ирэнгүүт бусад асуудал нь гацаад зогсчихдог ийм нөхцөл шалтгаанаас болоод өөрөөр хэлбэл хэлсэн үгэндээ хүрэхгүй буцдаг иймэрхүү шалтгаануудаас болж энэ асуудлуудыг багцалж, цогцоор гэдэг ийм байдлаар шийдсэн гэдгийг хэлье. Тэгээд энэ дээр энэ байдлаараа Засгийн газар хоорондын хэлэлцээрт болон мөн 58 дугаар тогтоолын 2-т ороод батлагдаад явж байгаа гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Түвшин гишүүн тодруулж асууя.

Б.Түвшин: Саяын энэ цогцоор дотор нүүрсний худалдааны, ялангуяа тэр үнийн хэсэг бол олон улсын 2 улсын худалдааны шударга зарчмаар дэлхийн зах зээлийн зарчмаар явж чадах уу гэдэг 1 дүгээр асуултыг та дахиад тодруулаад өгөөч.

Хоёрдугаарх нь тэр Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг нь манай энэ гэрээний 1 хэсэг болчхож байгаа. Тэгэхээр энэ гэрээний хэсэг болж байгаа ч манай улсын үндэсний эрх ашиг яг бүтэн хамгаалагдаж чадах уу. Үүний цаана яг юу яваад байна вэ.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: Үнийн зарчим бол бид нар өнөөдөр Эрдэнэс Тавантолгой компанийн олборлож байгаа нүүрснийхээ ойролцоогоор 50 орчим хувийг өмнөх 4 гэрээний урт хугацаатай байгуулсан гэрээнийхээ зарчмаар нийлүүлж байгаа. Тэгэхээр энэ урт хугацаанд эцсийн хэрэглэгч нь авч хэрэглэдэг энэ тогтолцоо бол

ялангуяа нүүрсний зах зээл дээр нүүрс, гангийн, коксжих нүүрс, гангийн энэ холбоос дээр баримтлаад явдаг ийм зарчим байна лээ. Тэгээд үнийн хувьд бол тэр тээвэртэй, тээвэргүйгээс болж онц ялгаатай харагддагаас биш урт хугацаандаа нэлээн тогтвортой байх ийм үнэ байдаг. Хэрвээ бид нар нүүрсний үнэ өндөр байхад ч гэсэн энэ асуудлаа шийдсэн бол бас нэлээн хожоотой байхаар байгаа.

Хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудал дээр бол бид нар өнөөдөр энэ 58 дугаар тогтоол дотроо 3 дугаар зүйл заалт дээрээ “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцаа эзэмшиж байгаа ашигт малтмалын .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд нэмж хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Түвшин гишүүний асуултад товч тодорхой хариулъя. 2014 онд Тавантолгой компанийн 51 хувийг Монголын тал, гэхдээ Тавантолгой компани 0 хувь 49 хувийг Хятадын тал тэр нь тухайн үеийн Шинхуатай хийхээр, 1 үгээр хэлбэл лиценз шилжүүлэх ийм хэлцэл байсан. Өнөөдрийн энэ гэрээ бол ямар нэгэн лиценз шилжүүлэхгүйгээр зүгээр нүүрсний тогтвортой худалдах энэ асуудлыг эрх зүйн хувьд баталгаажуулаач ээ гэдэг л ийм хүсэлт. Тийм учраас энэ бол улсын эрх ашигт илүү нийцнэ гэж үзэж байна.

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуулт асууя. Гишүүд хурууныхаа хээг уншуулаарай. Нэр гарахгүй байна. Суудлын дугаар гараад байна шүү.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Өнгөрсөн намрын чуулганы завсарлагаагаар зүүн бүсийн гишүүд өөрсдийн сонгогдсон тойргийн бүх сум, багуудад очиж Их Хурлаас авч хэрэгжүүлж байгаа энэ хууль, тогтоол, Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар бас нэлээн танилцуулга хийж, нэлээн уулзалтуудыг 30 гаруй хоногийн хугацаанд зохион байгууллаа.

Тэгээд эндээс олон зүйлүүд харагдаж байна. Намар бид нар хамтарсан Засгийн газар, түүний хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөр, дагалдуулаад 14 мега төслийн асуудлыг батлаад ирлээ гээд 8, 9 сард сумуудад очоод иргэдтэй уулзаад танилцуулахад бол тэр хүмүүс бол тийм их итгэлтэй байгаагүй. Яагаад гэвэл энэ чинь бараг 30 хэдтэй цэл залуу байсан хүнийг 60 хүрчхээд байхад нь дахиад энийг хийнэ гээд ярихаар ер нь дахиад л нөгөө нэг ярьдгаа ярьж байна гэсэн ийм л дүр зурагтай уулзалтууд намар болж байсан юм байгаа юм. Саяын харин уулзалтаар үнэхээр энэ 14 мега төслийн 4 нь хэрэгжээд эхэллээ гээд ярихаар бол иргэд олон нийт энэ ч бас нээрээ яваад эхэлчих юм байна шүү гэсэн ийм бас итгэл төрж байгаа юм байна гэдэг нь бас харагдаж байгаа юм.

Нөгөө талдаа бас нэг зүйлийг иргэд бол бидэнд нэлээн сайн захиж байгаа нь энэ уул уурхайн салбарын асуудал, тэр дундаа Үндэсний баялгийн сангийн хуулийн хэрэгжилтийн асуудал дээр Их Хурлын гишүүд маш тийм нухацтай хандаарай. Энэ бол олон түмэн энэ байгалийн баялгаасаа ашиг хүртэж эхлэх энэ том хууль юм байна шүү гэдэг ийм зүйлийг бас бидэнд хэлж яриад, захиад байж байгаа юм. Тэгээд би эндээс 2, 3 зүйлийг асууж тодруулах гээд байгаа юм.

Ерөнхий сайдыг энэ холболтын гэрээ байгуулах тэр үйл явцыг бид чуулган завсарлалчихсан учраас хэвлэлийн юмнаас нэлээн сайн анхааралтай ажиглаж байлаа л даа. Эндээс 2 мессеж өгч байна гэж би ойлгосон.

1 дүгээрт бол мэдээж энэ нүүрсний олборлолт энэ юмнууд сайжирна.

2 дугаарт тэр эрчим хүчтэй холбоотой асуудлууд бас давхар шийдэгдэх юм байна гэсэн. Сая Доржханд сайд хариулчихлаа.

3 дахь нь бол таны шинжилгээ мэндчилгээ дээр ч орж байсан. Энэ татвар, нийгмийн даатгалын шинэчлэлийн асуудлууд, энэ бас орон зай бидэнд гаргаж байна гэсэн ийм зүйлийг хэлсэн. Тэгэхээр энэ ер нь цаашдаа ямар байдалтай явах юм бэ гэсэн нэг дэх асуулт байгаа юм.

2 дахь нь одоо ингээд 20, 30 жил яригдсан энэ төслүүд ингээд амжилттай хэрэгжээд эхэллээ. 14-өөсөө 4-ийг хасахаар цаана нь 10 үлдлээ. Энэ парламентаар хаврын чуулганаар үлдэж байгаа 10 төслөөс ямар төслүүд нь орж ирэх юм бэ гэдэг ийм бас асуулт байна.

3-д нь бол бидний уулзалт дээр маш ихээр яригдаж байгаа нэг зүйл бол ер нь энэ 1072 хувьцааныхаа асуудлыг иргэд, олон нийт тухайн үед бол нэг их тийм ойшоож байгаа ч үгүй юм байна. Магадгүй тэр нөгөө цэнхэр, ягаан тасалбар шиг нэг их тийм хүртээмжтэй биш гэсэн иймэрхүү хандлагатай байсан бол энэ нүүрсний хулгай зогсоосны дараа энэ жил болгон олгож байгаа, олгохдоо жил болгон нэмэгдэж байгаа энэ ноогдол ашгийн асуудлууд бол иргэдэд маш том мессежийг өгсөн байна. Үнэхээр энэ бол миний өмч юм. Өмчөө ер нь цаашаа хянана гэсэн ийм л зүйлийг ярьж байна.

Үүнийг дагалдуулаад нэг зүйл очсон сум болгонд, ялангуяа манай ахмадуудаас яригдаж байгаа зүйл бол 1072 хувьцааны эзэн болсон ч тэр 15 онд байх сайн хувьцаа гэж нэг юм гаргаад, эргүүлээд нөгөө хувьцааг нь төр худалдаад авчихсан хүмүүсийн асуудал. Энэ хүмүүс бид нар яах вэ хувьцаандаа эзэн болмоор байна гээд. Энэ чинь анх нөгөө 60 хэдэн мянгыг өгөхөд шоолж байсан бол энэ чинь 200 хэд болоод, энэ жил 350 болоод, одоо энэ холболтын дараа хэд болж өсөхийг бас таашгүй байна шүү дээ. Тийм учраас бол энэ 3 асуудал, нийгмийн даатгалын асуудал, татварын асуудал, 2 дугаарт үлдэж байгаа 10-аасаа хэд нь хаврын чуулганаар орж ирэх юм. 3-д тэр 1072 хувьцаагаа өгчихсөн хүмүүсийн асуудал яах вэ гэсэн 3 асуулт.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Хүний амьдралын чанар шиг том мега төсөл гэж хаана ч байхгүй. Тийм учраас энэ бүх мега төслүүд цаанаа амьдралын чанар, орон сууцжуулалт, сургууль, цэцэрлэг энэ бүх асуудлыг л шийдэхийн төлөө байгаа. Тийм учраас эдийн засгаа тэлэх ёстой, мөнгөтэй болох ёстой л гэдэг ийм бодлого. Монгол Улсын ДНБ 3 жилийн өмнө 40 их наяд байсан. Одоо 80 их наяд 2 дахин тэлчихсэн байна. Яаж бид нар энэ эдийн засгийнхаа бааз суурийг хадгалах вэ. Яаж бид нар дутуу байгаа дэд бүтцийн асуудлаа хурдан шийдвэрлэх вэ. Бид нарт 150 орчим мянган айлын орон сууц хэрэгтэй. Аймаг аймгуудтай хоорондоо холбогдсон, боомтуудтайгаа холбогдсон нийслэл Улаанбаатар хотыг бүтэн, бүр больё гэхэд хагас тойрсон замууд хэрэгтэй. Улаанбаатар болон Улаанбаатарыг тойрсон гэр хорооллыг холбох дэд бүтэц хэрэгтэй. Энэ бүх зүйлийг шийдэхэд 10 тэрбум доллар хэрэгтэй. Хамгийн багадаа. Яаж шийдэх вэ. Төсвөөс шийдэх үү. Боломжгүй. Эдийн засаг тэлж байж л шийдэгдэнэ. Тийм учраас л энэ мега төслүүд бүгдээрээ л эдийн засгийнхаа багтаамжийг тэлэхийн төлөө татварын бааз суурийг нэмэхийн төлөө л байгаа.

Гэхдээ энэ бүх зүйлийн цаана хүний амьдралыг хэрхэн өөрчилж илүү амьдралын чанартай болгох вэ гэдэг л асуудал. Гол асуудал гол мега төсөл нь өөрөө энэ л байгаа. Тийм учраас өнөөдрийн бидний энэ баталж байгаа төсөл бол илүү урт хугацаанд тогтвортой ийм боломжит худалдааг бид Засгийн газар хооронд хийж байгаа тохиолдол учраас би тэгж хэлсэн. Яагаад гэвэл энэ 16 жилийн хугацаанд хэрэгжинэ. Одоо бид нар харж байгаа. Намрын чуулган дээр нүүрсний үнэ 170 доллар байсан. Мөнхөд ийм байх юм шиг л бид энэ асуудал дээр их олон өнцгөөс хандаж байсан. Одоо нүүрсний үнэ 70 доллар болчихсон байна. Хаврын чуулганаар. 1 чуулганы дунд л дэлхий дээр олон үйл явдал болж байна. 4 сарын 2-оос эхлээд АНУ 25 хувийн татварыг бүх улсын машин дээр тавих гэж байна. Нийт цахилгаан машины 62 хувийг манай урд хөрш үйлдвэрлэдэг. Үүнээс болоод шок өгч байна. Гэхдээ мэдээж энэ 70 долларын үнэ бас буцаж өснө. Тэгэхээр бид нар өслөө гээд нэг их айхтар баярлаж зангаа буруулахгүй, буурлаа гээд нэг их айхтар бачимдаж барьц алдахгүй. Энэ бол дэлхийн зах зээл дээр байдаг л бүтээгдэхүүн. Энэ манай Монгол Улсын эдийн засгийн 90 хувийг бүрдүүлж байна гэдгийг л ойлгох ёстой.

Тийм учраас өнөөдрийн гэрээ тогтвортой байх байдлаар тохиргоотой, тэгээд Засгийн газар хоорондоо Их Хурлаар батлуулж байгаа гэдэг нь туйлын чухал зүйл юм. Туйлын чухал зүйл юм. Зөвхөн төмөр зам 70 жилийн дараа холбогдож байгаа гэхээс илүүтэйгээр энэ бол өөрөө манай Монгол Улсын хувьд урт хугацааны ийм тогтвортой байдлын харилцан итгэлцэл дээр тулгуурласан харилцан ашигтай ийм худалдааг бид нар хөрш оронтойгоо хийж байгаа тохиолдол.

Энэ гэрээний ард ямар асуудлууд шийдэгдэх вэ. Энэ гэрээ батлагдсанаар ОХУ, БНХАУ-тай 3 улсын төслүүд хэрэгжиж эхлэх боломж бүрдэж байгаа юм. Тэр нь юу вэ гэхээр бид нар төмөр замын баруун, зүүн коридорын төслүүдийг яриа хэлэлцээрийн түвшинд оруулна. Нэг үгээр хэлбэл Шивээхүрэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя.

Ц.Туваан: Идэрбат гишүүний асуултад нэмж хариулъя. Манай Их Хурал 2024-2028 онд ажиллах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг баталж өгсөн. Энэ хөтөлбөрийн амин сүнс нь 14 мега төсөл. Энэ 14 мега төслийн дотроос таны хэлснээр 4 мега төсөл бол шийдвэрлэгдэх шатандаа буюу өнөөдөр 4 дэх нь хэлэлцээр соёрхон батлагдсанаар эхэлнэ. Энэ бол Эрдэнэбүрэнгийн УЦС, Орано групптэй байгуулах ураны хөрөнгө оруулалт, газрын тос боловсруулах үйлдвэр, Гашуунсухайт-Ганцмодны хил холболтын асуудал гээд. Үүнээс цааших төслүүдээс хамгийн ойрхон байгаа нь бол Үйлдвэр технологийн паркийн тухай хуулиар Зэс хайлуулах цогцолборын асуудал бол компани болоод тендер нь зарлагдах шатдаа, Гангийн цогцолбор бас төслийн нэгжийн шатдаа, мөн нүүрс, химийн цогцолбор, Багануурт, Кокс химийн цогцолбор Тавантолгой дээр, мөн жоншных гээд Бор-Өндөрт гэсэн ийм байдлуудаар орж ирэхээр байгаа.

Д.Амарбаясгалан: Сархадын Зулпхар гишүүн асуулт асууя.

С.Зулпхар: Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье. Бид өнөөдөр бол их тийм түүхэн шийдвэр гаргах гэж байна гэдгийг Их Хурлын гишүүд маань бүгд хэлж байна. Мэдээж хэрэг Их Хурлаас гарсан шийдвэр болгон түүхэн байдаг байх. Гэхдээ энэ шийдвэр бол бас онцгой түүхэн шийдвэрүүдийн 1 болж байна гэж ойлгож байна. 70 жилийн дараа

Монгол Улсын эдийн засгийг дэлхийн эдийн засагтай интегралчлах чиглэлд томоохон бас алхам болж байна гэж ойлгож байгаа учраас энэ шийдвэрийг, энэ хуулийн төслийг бүрэн дэмжиж байна гэдгээ илэрхийлье. Зарим 1 тоо хэлмээр байна. Бид ер нь урд хөрш маань ямар түвшний эдийн засаг вэ гэдгийг бүгд хэлдэг. Гэхдээ энэ тоог бол зарим тохиолдолд байнга санаж байх ёстой. Хятадын эдийн засаг 2023 оны гүйцэтгэлээр 1,9 их наяд америк доллар байсан. Энэ бол дэлхийн эдийн засгийн 18-19 хувь юм. 2024 оны гүйцэтгэл сая 2 сард гарсан байна. Энэ 20 их наяд америк доллар бол гарчихсан явж байгаа юм. Тэгэхээр бид төдий хэмжээний эдийн засагтай интеграцлагдах буюу нэгдэх энэ холболт хийх боломжийг энэ төмөр замын холболтоор хийж байгаа гэдэг үүднээс энэ хэлэлцээр бол маш онцгой ач холбогдолтой гэдгийг бас тэмдэглэх ёстой.

Тэрнээс гадна энэ дан ганц Хятадын эдийн засагтай биш. Бид Зүүн өмнөд Азийн эдийн засгийг тоогоор нь аваад үзэх юм бол 3,7 их наяд америк доллар. Ийм эдийн засагтай бид бас холбогдох цаашдын холболтуудын эхний алхам болж байна гэж ойлгож байгаа юм. Бид бол бүрэн холбогдож чадахгүй байгаа гэдгээ бол хүлээн зөвшөөрдөг, мэддэг шүү дээ.

Шинэ сэргэлтийн бодлогыг боловсруулж байх үед 1 онцгой зүйл яригдаж байсан. Тэр нь юу гэхээр бид бол эдийн засгаа ер нь дэлхийн эдийн засагтай холбох гол үндсэн холболтын гарцууд болсон төмөр зам, авто зам, бусад тээвэр болон логикийн хувьд бол бид сул талтай юм байна гэдгээ ойлгосон. Сорилт байсан. Энийг давах үүднээс хийсэн энэ ажлууд буюу төрийн бодлого шийдвэрийн тогтвортой болон залгамж чанарын гол илэрхийлэл болж байна гэдэг үүднээс энийг бол гарцаа байхгүй дэмжих ёстой.

Төв Азийн эдийн засаг 460 тэрбум ам.доллар. Энэ эдийн засагтай бид холбогдоно гэдэг талаас нь бас энийг онцгой ач холбогдолтой гэдгийг бол тэмдэглэмээр байна. Монгол Улсын Ерөнхий сайд Пакистанд айлчлал хийсэн. Өнгөрсөн хугацаанд. Тухайн үед бол Пакистан Хятадтай эдийн засгаа холбох чиглэлээр бүс ба зам санаачилгын хүрээнд яаж ажиллаж байгааг өөрөө бидэнд бас хуваалцаж байсан. Энэ үүднээс нь аваад үзэх юм бол их чухал байна гэж байгаа юм. Би 2 асуулт асууя.

Эхний асуулт Доржханд сайдаас байгаа юм. Энэ хэлэлцээрийг бид бас саяын эдийн засгийнх нь болон тээвэр логикийн олон улсын худалдааны хувьд, Монгол Улсын гадаад худалдааны хувьд ач холбогдолтой гэдгийг нь бол ойлгож байна. Дэлхий нийтийн хэмжээнд бүсийн хэмжээнд томоохон санаачилга байгаа. Та мэдэж байгаа. Бүс ба зам санаачилга. Энэ холболтууд хийгдсэнээр бүс ба санаачилгад нэгдэх ийм боломж хэр нээгдэх вэ гэдэг эхний нэг асуулт байна.

2 дахь асуулт бол Дэлгэрсайхан сайдаас. Дэлгэрсайхан сайд одоо бид бол олон улсын тээвэр логикийн нэн ялангуяа Евро-Азийн тээвэр логикийн шинэ алтернатив хувилбар гарчихсан. Тэр нь дундын коридор буюу Миддл коридор. Энэ дундын коридор луу нэгдэх боломжийг энэ олгох уу гэдэг ийм асуулт байна.

3 дахь асуулт Дэлгэрсайхан сайдаас ахиад. Энэ холболтууд цаашдаа бид далайн шинэ боомт руу холбогдох далайн шинэ боомттой холбогдож эдийн засгийн хувьд дэлхийн эдийн засагтай интеграцлагдах буюу нэгдэх энэ боломжийг бас хэр нээх вэ гэсэн ийм асуулт байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Зулпхар гишүүн үг хэллээ. Дэлгэрсайхан сайд хариулах уу. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Зулпхар гишүүний асуултад хариулъя. Энэ төмөр зам холбогдсоноор эхний ээлжид бол та мэдэж байгаа. Өргөн цариг, нарийн цариг хоёр хоёулаа хил дээр ингээд аль алиныхаа улсынхаа төмөр замын царигийг хүлээн зөвшөөрөлцөөд ингээд холбогдож байгаа. Уурхай дээрээс нүүрс ачигдаад өргөн царигаар шууд Ганцмод руу ороод, Ганцмод дээр ачилт буулгалтын терминал дээр шилжин ачилт хийгдээд нарийн замаар цаашаа явна гэсэн үг.

2 дахь нь бол нарийн цариг Монгол руу орж ирээд, нүүрс ачаад, цаашаа хилийн боомт орох, далайн боомт орох ийм боломж бололцоо бүрдэж байгаа. Тийм учраас цаашдаа бид бол 3 улсын гэрээгээр хамтарсан гэрээгээр хийгдсэн энэ дамжин өнгөрөх тээвэр, мөн бусад орнуудаас ирж байгаа энэ тээврийг нэмэгдүүлэх, бусдын ачаа тээврийг тээвэрлэх ийм боломж бололцоог бүрдүүлж өгч байгаа гэдгийг хэлье.

Энэ дундын коридор гэж саяын асуулттай бас адил зүйл. Өөрөөр хэлбэл энэ төмөр замыг бид хамтдаа тэгш эрхтэйгээр ашиглана гэдэг дээр бол харилцан тохиролцож байгаа. Өөрөөр хэлбэл цаад талдаа байгаа Чайна Энержи-ийн замыг бид бас адилхан тэгш эрхтэйгээр ашиглана гэдгээ энэ гэрээг дагасан протоколд заасан байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Тогмидын Доржханд сайд нэмж хариулъя.

Т.Доржханд: Зулпхар гишүүний асуултад товчхон хариулъя. Тэгэхээр хөгжье гэх юм бол замаа тавь гэдэг үг дэлхий даяараа байдаг. Хаашаа тавих вэ гэхээр зах зээл рүүгээ л тавь гэж байдаг. Тэгэхээр өнөөдөр дэлхийн түүхэнд бол хуурай газар бол төмөр замаа л тавьдаг. Далайтай ойрхон бол тэгээд далай дээрээ л тээврээ хийдэг. Энэ бол хамгийн хямдхан ийм тээвэр байдаг. Тэгээд Монгол Улсын хувьд бол харамсалтай нь 70 жилийн дараа 2 дахь гарцаа тавьж байгаа нь маш харамсалтай. Тийм болохоор бид нар асар их боломж алдсан нь бас үнэн. Гэхдээ сайн зүйл нь бол одоо хамтарсан Засгийн газар үүссэн болохоор бид нар энэ төслийг тавьж, замаа тавьж байгаа юм. Замаа тавихаар энэ чинь Хятадын зах зээл рүү орж байна. Цаашаагаа Төв Азийн зах зээл рүүгээ орно. Дамжаад цаашаагаа Европын зах зээл рүү гарна шүү дээ. Тэгээд энийг чинь бид нар маш олон жилийн хугацаанд энэ Монгол болон далайд гарцгүй орнуудын ганц бэрхшээл бол тээвэр логистикийн өндөр зардал байна. Ганц боломж нь бол төмөр зам. Энийгээ л тавих ёстой гээд санхүүжилт ч их ярьдаг байсан, холбоос ч их ярьдаг байсан. Тэгээд дотоод улс төрөөсөө болоод ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Цагаанхүүгийн Идэрбат гишүүн түрүүн тодруулж асуух байсан. Хоцорчихсон 1 минут өгье. Тодруулж асууя.

Ц.Идэрбат: Тийм. Энэ том төслүүдийн ард бас маш том эдийн засгийн үр өгөөжүүд явж байгаа гэдгийг бол маш сайн ойлгож байгаа. Тийм ч учраас том төслүүдээ энэ 14 мега төслийг бид ард түмэн ч харж байна, маш амжилттай бас эхлүүлж байна гэж харж байгаа. Тэгэхээр миний асуусан асуултаас тэр нөгөө 1072 хувьцаагаа 2014, 2015 оны үед ер нь хэзээ ч үр өгөөжийг нь мэдэхгүй тийм байх үед нь борлуулчихсан. 1 сая төгрөгийг 3 хуваагаад өгчихсөн олон ахмадууд сум болгон дээрээс энэ асуудлыг ярьж байгаа. Сайн хувьцаа гэж нэрлээд худалдаад авчихсан. Одоо тухайн үедээ зарчихсан чинь өнөөдөр тэр хувьцаа маань 60 мянган төгрөгөөр

эхэлж байсан бол өнөөдрийн жилд 350 болж өсчхөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр хувьцаагаа бид эргүүлээд бидэнд боломж олгооч гэдэг зүйлийг ялангуяа ахмадууд бол энэ саяын явсан уулзалт болгон дээр бидэнд ярьж байгаа юм. Тэгэхээр энэ ямархуу шатанд байх юм бэ гэж асууж байгаа юм.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулах уу.

Нөгөө 10 жилийн өмнөх сайн хувьцаа гэж зарсан. Зарсан нь яах вэ, зараагүй нь яах вэ. Зарчихсан нь буцааж авч болох уу гээд их олон янзын асуудал гараад, өнгөрсөн жил 1 сарын 7-ны Улсын Их Хурлаар энэ асуудал ороод, Улсын Их Хурлаар дэмжигдээгүй унасан л даа. Туваан сайд хариулт өгье.

Ц.Туваан: 2016 онд болсон процесс. Иргэн болгонд 1072 хувьцаа ноогдож байгаа. Тухайн үед 3 сарын 31-ээс өмнө төрсөн хүүхдүүд гээд. Энэ дээр тухайн үеийн Засгийн газраас шийдвэр гаргаад 1072 хувьцааны 300 ширхэг хувьцааг нэрлэсэн үнээр нь сайн дурын үндсэн дээр борлуулах боломжтой ийм шийдвэр гарсан. Энэ шийдвэрийн дагуу миний санаж байгаагаар 1 сая 400 гаруй мянган иргэн маань өөрийнхөө 1072 хувьцаанаас 300 ширхэг хувьцааг 300 гаруй ширхэг хувьцааг 300 мянган төгрөгөөр 100, 100 мянган төгрөгөөр 3 хувааж арилжсан асуудал байгаа. Энэ асуудлыг та ярьж байна. Тэгэхээр энэ борлуулсан асуудал бол иргэдээсээ асуугаад сайн дураараа би энэ хувьцаагаа бэлэн мөнгөөр Засгийн газартаа заръя гэсэн шийдвэр .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Энэ асуудалд Туваан сайд нарийвчилсан ер нь мэдээлэл цуглуулаад бас засаг дээрээ яриад, тэгээд яах талаараа бас эргээд Их Хуралд танилцуулах нь зүйтэй байх. Давхардсан тоогоор 300 орчим мянган иргэн байгаа шүү. Хувьцаагаа бүтнээр болон хэсэгчилж зарсан. Оюутнууд 500.000-ыг, төрийн албан хаагчид 30.0000-ыг, зарим ахмадууд 1072-оо бүтнээр нь зарчихсан байгаа юм. Тэгэхээр энэ асуудал үндсэндээ яаж шийдэгдэх юм гэдэг дээр бас эргэж танилцуулах нь зүйтэй байх.

Өлзийхүүгийн Шижир гишүүн асуулт асууя.

Ө.Шижир: 17, 18 жилийн дараа маш их талцал хуваагдал улс төржилт, үүнээс улбаалаад хэд хэдэн Засгийн газрын хувь заяаны асуудал хүртэл энэ яг энэ төсөлтэй холбоотой өөрчлөгдөж байсан. Тэгээд хамтарсан Засгийн газрын үед бас энэ төсөл өнөөдөр Их Хурлын чуулганаар орж ирээд, соёрхон батлах гэж байгаад бас баяртай байна. Өнгөрсөн 17, 18 жилийн талцал хуваагдал энэ хүрээд төгсөж байна. Ер нь бол Монгол Улс 2 хөрштэй, түүнээс урд хөрштэйгөө 4307км буюу хамгийн урт хилээр хиллэдэг. Энэ бас Бүгд Найрамдах Хятад Ард Улсын 14 улстай хиллэдгээс хамгийн урт нь. Харамсалтай нь 70 жилийн дараа дөнгөж 2 дахь боомтоо холбогдож байгаа нь бас маш харамсалтай байна.

Ер нь тэгээд сая Алтангэрэл сайдын үг дээр ч гарч байна. Ерөнхий сайдын үг дээр ч гарч байна. Манай Засгийн газар, төр нь хөрш улстайгаа гэрээ байгуулчхаад, тэрийгээ устгачихдаг болж таарч байна. Ард иргэдээсээ нуудаг болж таарч байна. Улсын Их Хурлаасаа нугаад, дараад тэрийгээ устгачихдаг. Аргаа бараад хөрш улсаасаа, айлаас тэр гэрээгээ олж авдаг ийм ичгэвтэртэй байдлыг өнгөрсөн хугацаанд бид нар туулсан байна. Тэгэхээр үүний хариуцлагыг бид нар заавал ярих ёстой. Тэгэхээр энэ устгачихсан, алга болгосон гэрээг нэгэнт олж авсан бол үүнийг ил болгох уу гэдгийг би Ерөнхий сайдаас асуумаар байна. Энийг олон нийтэд заавал

ил болгох ёстой. Үнэн зөвийг нэг талдаа гаргах ёстой гэж асуумаар байна. Эхний асуулт.

2 дугаарт нь ер нь бол бас Монгол маш олон олон улс орны эдийн засгийг дэмжсэн, экспортыг дэмжсэн төсөл хөтөлбөрүүд улс төрчдөөс болж гацаж ийм хүнд байдлыг бас өнөөдөр бид нар туулсан. Тэгэхээр цаашид тийм олон олон төсөл энэ улс төрчдийн гацалтыг бид заавал давж туулдаг байгаасай гэж хүсэж байна. Тийм учраас бас Зам, тээврийн сайдаас 2 асуулт байна.

Эхнийх нь яг нэг чиг үүргийн үндсэндээ Монголын Төмөр зам, Тавантолгой төмөр зам гээд 2 компани байгаа. Энэ хил холболтын төмөр замууд, цаашдаа холбогдох төмөр замууд хэрэгжсэнээр энэ 2 компани нэгдэх үү. Аль эсвэл ижилхэн чиг үүрэг, бүтэцтэй, давхардсан орон тоотой энэ 2 компани ингээд тусдаа яваад байх уу гэдэг асуулт байна.

Мөн 2 дахь асуулт нь хил дамнасан төмөр замын Монгол Улсын нутаг дэвсгэр дээр бүтээн байгуулалт төмөр зам барилгын ажлыг хаанахын компани гүйцэтгэх вэ. Энийг хэлэлцээр, протоколд юу гэж тусгасан байгаа вэ гэдгийг асуух гэсэн юм. Ийм 3 асуулт байна.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд хариулт өгье. Борхүүгийн Дэлгэрсайхан сайд дараа нь хариулна.

Ц.Туваан: Энэ 2014 онд 2 улсын Ерөнхийлөгч нарын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ерөнхийлөгчийн Монгол Улсад хийсэн айлчлалын үеэр байгуулагдсан бичиг баримтуудаас ярьж байх шиг байна. Тэгэхээр энэ бичиг баримтуудыг гишүүнд хүргүүлье. Тэгээд бас мэдээж тухайн үед нууцаар биш байгуулсан бичиг баримт учраас ил болгож болох байх гэж бодож байна.

Төмөр замын асуудлыг нь Дэлгэрсайхан сайд.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Ер нь Засгийн газраас төрийн өмчтэй компаниудын үр дүн бүтээмжийг сайжруулах ийм ажлын хүрээнд Тавантолгой төмөр зам, Монголын Төмөр зам 2-ыг дэд бүтэц буюу өөрөөр хэлбэл төмөр замын хэллэгээр суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүн, ажиллах хүчийг нь МТЗ-д нийлүүлж, менежментийг нь нэг төмөр зам хийхээр болж байгаа. Үүнтэй холбогдуулаад Тавантолгой төмөр замыг бол татан буулгахгүй. Тавантолгой төмөр зам өөрөө мөн энэ Чайна Энержитэй хийсэн гэрээний дагуу хил холболтын ажил дээр хамтарч гэрээ хийж, цаашаа ажиллах учраас Тавантолгой төмөр замын бүтцийг 20-30 инженертэйгээр үлдээж, энэ Тавантолгой төмөр замын бүтээн байгуулалтад хяналтаар ажиллах ийм компани болж байгаа гэдгийг хэлье.

Дараагийн асуудал бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Гүйцээж хариулъя. Дэлгэрсайхан сайд.

Б.Дэлгэрсайхан: Энэ хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг бол урд хөршийн буюу өөрөөр хэлбэл Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын гүүрний компани хийнэ. Гэхдээ Монгол Улсын хуулийн дагуу орон нутаг төрийн

өмчийн худалдан авах үйл ажиллагааны хуулийн дагуу тендер зарлана. Ингээд олон улсын гэрээний дагуу хөрш зэргэлдээ Хятадын компаниудын дунд тендер зарлаад аль хямд буюу богино хугацаанд энэ бүтээн байгуулалтыг хийх санал өгсөн компани мэдээж ялах байх. Тийм учраас цааш энийг хийхдээ тэгэхдээ 1 харгалзах зүйл бол урд хөршийн бүтээн байгуулалт, гүүрэн байгууламжийг хийх компани 1 компани байна гэдгийг энэ ташрамд хэлье. Яагаад вэ гэхээр энэ хэдийгээр хил дамнасан ч гэсэн нэг байгууламж учраас 1 компани ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Өлзийхүүгийн Шижир гишүүн тодруулж асууя.

Ө.Шижир: Өчигдөр Байнгын хороо дээр бас зарим зүйл асуулт асуусан учраас зармыг нь орхиё. Ер нь бол энэ 1 компаниар гүйцэлдүүлэх гэдэг санал нь Монголын талын санал байсан уу. Монголын нутаг дэвсгэр дээр бүтээн байгуулалтыг өрнүүлэх хятадын компанид Бүгд Найрамдах Хятад Ард Улсын компаниар гүйцэтгүүлнэ гэдэг нь Монголын талын санал байсан уу, Хятадын талын санал байсан уу гэдгийг дахин тодотгоё.

2 дугаарт бас Монгол Улсын Ерөнхий сайдаас би асуулга асуусан. Энэ асуулгын хүрээнд яг энэ Ганцмод-Гашуунсухайт боомтын төмөр замын санхүүжилтийн хэлэлцээртэй холбоотой яг ямар, хэдэн баримт бичгүүд Монголын талд байхгүй байгаа. Тэр олдсон баримт бичгүүд дээр хэн хэн гарын үсэг зурсан. Үүнийг Их Хурлаар хэлэлцүүлэх үү. Мөн тухайн аж ахуйн нэгжээс тодруулга авсан уу гээд ийм асуулга өгсөн байгаа. Тэгээд энэ асуулгын тодорхой хариулт ирсэн. Яг энэ асуулт дээр бол хариулт ирээгүй. Тийм учраас би лавлаж асууж байгаа юм.

Туваан сайдад хэлэхэд бол та надад хүргүүлж болно. Би бол энийг олон нийтэд ил болгоосой гэж байгаа юм. Яагаад олон нийт ил болгох вэ гэхээр өнгөрсөн 17, 18 жилийн энэ их улс төржилтийг, энэ их гацалтыг иргэд өөрсдийнх нь нүдээр ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд эхлээд хариулт өгье. Тэгээд нэмээд Дэлгэрсайхан сайд.

Л.Оюун-Эрдэнэ: 2014 оны 8 дугаар сард Бүгд Найрамдах Хятад Ард Улсын дарга Ши Жиньпин Монгол Улсад төрийн айлчлал хийсэн. Энэ айлчлалын 2 дахь өдөр энэ гэрээ зурагдсан. Энэ гэрээ бол Ганцмод талд Хятадын тал төмөр замаа бариад, Монголын тал өөрийн санхүүгээр төмөр замаа барих зээлийн хэлэлцээртэй холбоотой ийм баримт бичиг. Тэгээд энэ баримт бичиг бол нууц биш. Тэгээд удахгүй би бас хэлсэн. Нөгөө Тавантолгойтой холбоотой зарим асуудлуудыг Их Хурлын гишүүд санал тавьсан байгаа. Мөн шаардлагууд ч ирж байгаа. Тийм учраас энэ баримт бичиг дунд энэ гэрээг оруулъя. Тэгээд Их Хурлын гишүүдэд тарааж өгье.

Д.Амарбаясгалан: Дэлгэрсайхан сайд нэмж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Шижир гишүүний асуултад хариулъя. Энэ төмөр замын хил холболтын гүүрэн байгууламж өөрөө төвөгшилтэй гэж нэрлэгддэг ийм бүтээн байгуулалт байгаа барилгын. Тийм учраас манайд өнөөдөр энийг хийхээр хэмжээний компани одоохондоо бол байхгүй. Гэхдээ мэдээж цаашдаа бол бий болно. Ер нь бол энэ төмөр замыг бүтээн байгуулж байхад олон компаниуд бол гүүр хоолой барьдаг ийм туршлагатай болсон байсан. Гэхдээ энэ удаагийн хил холболтын төмөр замын гүүрэн байгууламжийг Монгол талын гэдгээр илүүтэй

саналаар энэ хамтдаа 1 гүүрэн байгууламжийг хийхгүй бол дараа нь 2 тусдаа хийхчээд төмөр замын байгууламж нь аль нэг талдаа төмөр зам нь зөрөх юм уу, алдаа оноо гаргах, гүүрэн байгууламж нь өөрөө шаардлага хангахгүй гээд урд хөрш атгаас тавиад татгалзаад, төмөр замаа дээгүүр нь явуулахгүй, бид нар үүнээс баталгаа шаардана гэдэг ийм асуудал гарч болзошгүй учраас Хятадын талын компаниудын дунд тендер зарлаж байгаа юм гэдгийг энд хэлье. Зориуд.

Тийм учраас энэ бол хамтдаа нэг компаниар хил дамнаж хийлгэх нь илүү чухал үр ашигтай. Яагаад вэ гэхээр дараа нь илүү зардал гарахгүй, дараа нь янз бүрийн зөрчил гарахгүй. Энэ байгууламж өөрөө нэг компани хийснээрээ хариуцлагаа үүрээд явна гэдэг ийм үүднээс хийгдэж байгаа байгууламж гэдгийг хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн асуулт асууна.

Г.Ганбаатар: Өдрийн мэнд ээ. Энэ 2 улсын хооронд байгуулах хэлэлцээрийг зарчмын хувьд соёрхон батлахыг нь дэмжиж байгаа. Бид нар 2024 оны 12 сарын 27-нд Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолоор энэхүү хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэлийг нь баталж өгсөн. Улсын Их Хурлын 58 дугаар тогтоолоор. Тэгээд хэлэлцээрийн ажлын хэсэг бас их хурдтай сайн ажиллаж, 2 дугаар сарын 14-нд юм байна. Энэ Харбин хотноо хэлэлцээр хийсэн байна. Өчигдөр би бас Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралд сууж, өнөөдөр хэлэлцэх гэж байгаатай нь холбоотой өөр Байнгын хорооных ч гэсэн энэ талаар нэлээн дэлгэрэнгүй мэдээлэл авсан.

Туваан сайдын мэдээллээс сонсож байхад бол бас тэр төмөр замын байгууламж нь 270 сая доллароор хийх байсныг 50 сая доллароор хямдруулсан. 30 сарын хугацаанд хийх байсан төмөр замыг бас 22-24 сараар багасгасан гээд Дэлгэрсайхан сайд нар ярьж байсан. Олон сайшаалтай зүйл байна. Гэхдээ өчигдөр бас нэг зүйл дээр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороон дээр протоколыг нь бид нар нэг олоод харчихъя. Дотроо яг нарийн өөр юу байна вэ гэдгийг харъя гэсэн олж харж чадсангүй. Сайны хажуугаар энэ Улсын Их Хурлаас хэлэлцээр байгуулахад өгсөн үндсэн чиглэл 12 зүйл л байгаа. Энэ 12 зүйлийн тэр 12 дугаар хэсэг дээр нь түрүүнд яах вэ, Эрчим хүчтэй холбоотой, эрчим хүчний экспорттой холбоотой хэсгийг нь Энхтуяа гишүүн асуучхаж байгаа харагдана лээ. Сэргээгдэх эрчим хүчний экспорт, эрчим хүчний нүүрс экспортлох, нүүрсийг гүн боловсруулах аж үйлдвэр. Хамгийн гол миний асуух гэж байгаа асуулт бол энэ говийг усжуулах, шар шороон шуурга, цөлжилттэй тэмцэх энэ хэсэг нь ерөөсөө энэ хэлэлцээрээс би олж харсангүй. Тэгээд Улсын Их Хурлаас өгсөн 12 чиглэлийн 1 заалт энэ хэлэлцээрт биелсэнгүй юу гэсэн ийм асуулт байна. Үүнд холбогдох хүмүүс нь хариулна уу. Хэрвээ тийм протоколд байгаа бол түүнийгээ энд дурдаад өгнө үү.

2 дахь асуудал нь Гашуунсухайт-Ганцмодны төмөр замын холболт, хил дамнасан холболт ингээд явах нь. Үүний дараа тэр Шивээхүрэн, Бичигт боомтуудыг холбох юм бол бид нар бас жилдээ 10, 10 сая тонноор нүүрс экспортоо нэмэгдүүлэх боломжтой юм байна. Түүний дараа бас Ханги-Мандал боомтыг холбох юм байна. Ингээд шат дараатайгаар энэ нь хэдий хэмжээний хугацаа орох юм. Ер нь хэзээ дараагийн боомтуудыг холбох асуудлууд орох юм. Бид яг үнэндээ бол жилдээ 15 төгрөг болоход 9 төгрөг нь л нүүрснээс олж байна шүү дээ. Олох орлогоо нэмэгдүүлэхийн тулд энэ боомтуудынхаа холболтыг хурдацтай холбох асуудал

дээр ямар хугацаа орох юм бэ гэдэг 2 дахь асуулт байна. Тэгээд асуултынхаа хариултыг авч байгаад тодруулах эсэхээ шийдье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулах уу. Ерөнхий сайд эхлээд хариулъя.

Л.Оюун-Эрдэнэ: Би түрүүн хариулсан. Гэхдээ дахиад бас хэлчихье. Замын-Үүдээс хойш 2 дахь боомт Гашуунсухайт. Гашуунсухайтын дараагийн боомт буюу 3 дахь боомт бол энэ протоколд тусгагдсаны дагуу, мөн уулзалтууд дээр яригдсаны дагуу Шивээхүрэн. Өнөөдөр Их Хурал батлагдсанаас хойш бид нар хамтдаа Шивээхүрэн боомтыг холбох ажилд орно гэж ойлгож болно. Хэлэлцээрүүд явна. ТЭЗҮ-үүд яригдана. Гэхдээ Шивээхүрэн бол хоорондоо холбогдох зай нь богино учраас хэлэлцээр явчих л юм бол Гашуунсухайтынхаа ч өмнө дуусах магадлалтай. Дуусах магадлалтай. 3 дахь боомт Бичигт. Бичигт боомт бол зүүн коридор бас далайтай шууд холбогдох ийм дөт зам. 2 далайн ийм гарцтай болох боломжтой гэсэн үг. Тийм учраас Бичигт рүү чиглэх хэлэлцээрүүд явна. Дараагийнх нь Ханги-Мандал. Ханги-Мандал бол төмөр замаа баригдчихсан. Гэхдээ энэ хэлэлцээр нь өөрөө тэр дэс дарааллынхаа дагуу байгаад байгаа. Энэ дарааллын дагуу л явна. Тэгээд бид нар Замын-Үүд, Гашуунсухайт хоёрынхоо дунд бол 70 жил алдчихсан болж таараад байгаа шүү дээ. Гэхдээ бидний хувьд 1 жил дотроо багтах тал дээр бүх л чадлаараа л ажиллах нь зүйтэй болоод байгаа.

Дээрээс нь говийг усжуулах асуудал бол яригдсан. Хэлэлцээрт тусгагдсан талаар нарийвчилсан хариултыг Туваан сайд өгчих нь зүйтэй байх. Говийн бүс нутгийг усжуулах, шар шороон шуургатай тэмцэх гэдэг энэ агуулга бол яригдсан гол 3-4 зүйлийн 1 байгаа. Сэргээгдэх эрчим хүчтэй холбоотой асуудал яригдсан. Энэ бол урт хугацаанд сэргээгдэх эрчим хүчийг экспортлох ийм хэлэлцээр энэ гэрээ өнөөдөр соёрхон батлагдсанаар энэ хэлэлцээр нээгдэж байгаа гэж ойлгож болно.

Дээрээс нь түрүүн бас Энхтуяа гишүүн асууж байсан. Өмнийн говийнхондоо говийн бүсийнхэндээ маш их талархаж байгаа Монгол Улс. Би энийг бас албан ёсоор хэлчих нь зүйтэй. Мэдээж тэнд маш их баялаг байна. Маргаантай олон асуудлууд байна. Тэнд байгаа иргэдийн амьдралын чанар байгаль экологийн асуудал гээд олон зүйлүүд байгаа. Баялгийн сангийн тухай хуулийн гол үндсэн философи бол баялгаа ашиглуулж байгаа бол тухайн орон нутаг түрүүлж хөгжих ёстой гэдэг философи байгаа. Энэ бол хөгжлийн сангийн гол философи. Дээрээс нь байгалийн баялаг илүү иргэдэд амьдралын чанар болж, өсөлт хүртээмжтэй байх тухай ойлголт байгаа. Тэгээд аль аль нь хуульчлагдчихсан. Засгийн газар хуулиа л биелүүлж байгаа. Парламентын баталж өгсөн хуулийг л Засгийн газар биелүүлж байгаа. Тийм учраас энэ дээр бид нар хамтарч ажиллах зайлшгүй шаардлагууд гарна.

Говийн бүс нутгийнхан илүү бас хурдтай төвлөрсөн суурин газар болж хөгжиж байгаа. Гэхдээ амьдралын чанар болон ялангуяа ус, экологийн асуудал дээр Засгийн газар онцгой анхаарал хандуулж ажиллаж байгаа. Энэ хамтын ажиллагаагаа бас эрчимжүүлнэ гэдгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд нэмж хариулъя. Улсын Их Хурлаас баталж өгсөн 58 дугаар тогтоолоор баталж өгсөн үндсэн чиглэлийн 12 зүйл заалтыг бүгдийг нь 3 түвшний бичиг баримтад хуваан тусгасан. Хэлэлцээр, протокол, компани хоорондын гэрээний драфт дээр тусгаж өгсөн. Хэлэлцээрийг өнөөдөр соёрхон батлагдсанаар эцэслэгдэнэ. Протоколыг бол Харбинд хамтран

гарын үсэг зурж албажуулсан байгаа. Энэ дотор говийг усжуулах асуудал бол протоколын 5 дугаар зүйл заалтын бусад гэсэн хэсэгт байгаль орчин, усжуулах, орон нутаг, суурьшлын бүс, ажиллах хүчний асуудлаар хамтран ажиллана гэж.

Мөн шар шороон шуургатай холбоотой асуудлыг би өчигдөр Байнгын хорооны хуралдаан дээр заагдаагүй гэж хэлсэн. Энэ асуудал тэр компани хоорондын гэрээний өөрөөр хэлбэл 3 дугаар түвшний гэрээ дотор шар шороон шуургатай холбоотой асуудлыг хамтран шийдвэрлэхээр тусгагдсан байна лээ гэдгийг залруулж хэлье.

Д.Амарбаясгалан: Гомбын Ганбаатар гишүүн тодруулж асууя.

Г.Ганбаатар: Ерөнхий сайд аа, түрүүнд би таны хариулахыг сонсож байсан л даа. Гашуунсухайт-Ганцмодны холбоо, түүний дараа дараалан Шивээхүрэн, түүний дараа Бичигт боомт, тэгээд түүний дараа Ханги-Мандал гээд боомт тус бүрээр 10 сая тонны хүчин чадал нэмэгдэх юм гээд. Ер нь хугацааны хувьд би асуугаад байгаа байхгүй юу. Цаглаврын хувьд. Энэ хэдий хэмжээний цаг хугацаа орох юм. Энэ 3 боомтыг дарааллаар нь холбоход хэзээ хамгийн цаад талын хугацаа ч гэдэг юм уу ашиглалтад орох вэ л гэдэг асуудал асуугаад байгаа юм.

Сая Туваан сайдын хариулт дээр тэр протоколд орсон гээд . Өчигдөр Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр тэр протоколд байгаа гээд. Протоколыг чинь харъя гээд би харж чадаагүй байхгүй юу. Тийм учраас яг тэр бид нарын өгсөн чиглэлийн 12 дугаар заалт бол протоколд орсон юм байна. Протоколын тэр 5 дугаар хэсэгт орсон юм байна гэж ойлголоо. Тэгээд та нарын хувьд чинь ингээд төмөр замын байгууламж, нүүрс худалдах, худалдан авах гэрээ, уурхайн хүчин чадлаа өргөжүүлэх энэ 3 гэрээ чинь үндсэндээ ингээд Улсын Их Хурал, Засгийн газраас ... /минут дуусав/

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Ерөнхий сайдын хариулсан хариулт дээр нэмж хугацаа асууж байна. Ер нь бол бид нар энэ гэрээг дагуулж протоколд гарын үсэг зурсан байгаа. Энэ протокол дээр юу гэж заасан байна гэхээр Ганцмод-Гашуунсухайтын хил холболтын барилгын ажил эхэлмэгц дараагийн боомтын ажлыг ярьж эхлүүлнэ гэдэг ийм тодорхой зааж өгсөн байгаа. Тэгэхээр мэдээж ямар ч барилгын хугацаа өөрийн гэсэн цаг хугацаатай. Тэгэхээр өмнөх хугацааг өөрөөр хэлбэл Ганцмод-Гашуунсухайтын 1,9 жил буюу 22 сарыг бид хүлээлгүйгээр дараагийн боомтуудын асуудлаа ингээд шат дараатай яриад явна.

Тийм учраас цаг хугацааны хувьд бол мэдээж бид аль болох богино хугацаанд холбох ийм бодолтой байгаа учраас энэ ирэх 4 жилдээ буюу .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууна. 2 гишүүний дараа санал хураалт явагдана.

Д.Ганбат: Хэд хэдэн асуулт байна. Гэхдээ буруу асуулт байдаггүй гэсэн. Тэгээд асуултад заавал хариулахыг л бодоорой доо. Би асуухаар тэгээд заримдаа хариулт байдаггүй л юм л даа.

1 дүгээрт хил холболт, хил дамналт гээд 2 ойлголт яриад байх юм. Гэрээ дээрээ бол хил дамнасан гэж байна. Тэгээд хил холболт, хил дамнасан гэдэг чинь ялгаатай ойлголт юм уу. Адилхан ойлголт юм уу. Ялгаа байна уу. Тэрийг би нэг ойлгоод авчихмаар байх юм.

Нөгөө талаараа юу байна. Энэ нарийн царигтай төмөр зам бол ороод ирэх юм байна гэж ойлголоо. Өргөн цариг нь ч бас даваад явчих юм байна гэж ойлголоо. Нарийн царигтай төмөр зам чинь хэчнээн километр орж ирээд, хэний өмч байх юм бэ. Тэгээд энэ гэрээ чинь хосолсон 3 гэрээ гээд байгаа юм. Нэг нь нөгөөгөөр болохгүй гээд. Тэр дээр бол “Эрдэнэс Тавантолгой” компани маань компани ч юм уу төрийн өмчтэй газар ч юм уу тэрийг нь мэдэхгүй байгаа. Монголын ард түмэн болох 30 хувийг нь хувьцаа эзэмшигчид гээд явж байгаа шүү дээ. Тэгсэн мөртөө аж ахуйн нэгж нь ч юм уу юу ч юм. Энэ бол тодорхойгүй байгаа. Тэгээд энэ яг ямар байх ёстой юм бэ. Яах юм бэ. Энийг бас бас тодруулчихмаар байгаа юм. Тэр лиценз нь хэнд хамаарагддаг юм бэ. Монгол Улсын төр засаг нь байдаг юм уу. “Эрдэнэс Тавантолгой” компанийн лицензүүд юм уу гэсэн ийм асуулт байгаа юм.

Тэгээд тэр гуравласан гэрээг бол олж хараагүй л дээ. Мэдэх ч үгүй байна. Энэ “Эрдэнэс Тавантолгой” компанийн 40 хувь гэж би ойлгоод байгаа юм. Зөв үү, үгүй юу. 2 толгой байгаа. 2 орд. Тэр 2 ордоо бол төрийн өмчтэй “Чайна Энержи” компанид шилжүүлэх юм байна. Тэр компани маань өөрөө олборлоод, өөрөө төмөр замаар тээвэрлээд, өөрөө борлуулаад ашиглаад явах юм гэж ойлгож байгаа зөв үү. Хэрвээ тийм байгаа бол 1 компани эхнээс нь дуустал юмаа хийж байх нь бол зөв үү, буруу юу. Ийм юм байдаг юм уу. Тэгээд ер нь судалгаа энэ тэр юм хийсэн үү. Байгаа юу. Аль болохоор л сайжруулж л байвал сайн байна л даа. Энэ Монгол Улсын эрх ашиг, Монголын ард түмэн, Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцаа эзэмшигчид энэ бүх юманд үнэхээр сайн гэрээ болж чадаж байгаа юу. Яах вэ ер нь цаг хугацаа л харуулдаг л даа. Дараа нь цаг хугацаа өнгөрсний дараа тийм ашиг сонирхлын зөрчилтэй ийм хүмүүс оролцсон байна, ингэж ингэж хийсэн байна гээд удахгүй гараад ирдэг л дээ. Иймэрхүү юмнуудыг бас сонсмоор байх юм.

Нөгөө талаар бол энэ хувийн хэвшлүүд, би өөрөө хувийн хэвшлийг дэмждэг, хувийн хэвшил дээр эдийн засаг явдаг, иргэдийн санал санаачилга дээр явах ёстой гэж ойлгодог л доо. Энэ юмаа бол бид нар буруутгаад, болохгүй гээд тийм ойлголтыг нийгэмд суулгаж болохгүй юм. Энэ чинь алтаар өндөглөдөг тахиануудаа л байхгүй болгож байна л гэсэн үг шүү дээ. Буруутай бол төр засаг л буруутай. Компаниуд ямар ч буруу байхгүй ийм л юм байгаа шүү дээ уг нь бол. Тэр Эрдэнэтийн 49 хувийг авчраагүй бол өнөөдөр энэ улс орон ямар ч байх байсан юм. Ковидын нөхцөл байдлыг даваа ч уу, үгүй ч үү гэх мэтчилний.

Тэрбум долларын борлуулалт хийчихсэн. Олон улсын зах зээл дээр гарчихсан ийм компаниуд бий болж байна л даа. Энэ бол сайн юм байгаа. Ингэж л хөрөнгө оруулалтыг татах ёстой. Ингэж ажиллах ёстой л доо. Энийг ч Засгийн газар дэмжиж, энэ Улсын Их Хурал ч гэсэн дэмжиж байх ёстой. Ийм л зүйлүүд байгаа. Тэгээд энэ талаар бас та бүхний санал бодлыг сонсьё. Энэ юмаа аль болохоор сайжруулах хэрэгтэй байна. Бусад Тавантолгой дээр яг ингэж хийсэн шигээ нарийн царигтай төмөр зам .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Ерөнхий сайд хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: 2014 оны ярьж байсан гэрээнээс юугаараа ялгаатай вэ гэж. Таны хэлдэг үнэн. Өргөн, нарийн цариг хил холбох зорилгоор харилцан хил давж болно гэж ийм агуулга дээр үндсэндээ тохиролцож, зөвшилцөж чадсанаар өргөн, нарийн царигтай холбоотой энэ маргаан эцэслэгдэж, бусад боомтууд дээр ч гэсэн энэ агуулгаар явна гэдэг ийм байдлаар тохирсон. “Эрдэнэс Тавантолгой”-н лиценз “Эрдэнэс Тавантолгой” дээрээ л байна гэж тохирсон. Төмөр зам тавьчихвал олборлох нүүрсний тогтвортой байдлыг харин Монголын тал хангаарай гээд. Урьд нь бол “Эрдэнэс Тавантолгой”-той холбоотой лицензийг зайлшгүй хувийн хэвшилд шилжүүлэх нь зүйтэй гэдэг ийм хэлцэл явагдаж байсан. Үүнээс болж бас их маргаан үүссэн. Тэрийг бол та мэдэж байгаа. Тэгэхээр энэ маргаан маань ингээд эцэслэгдэж байгаа.

3 дахь, 4 дэх талууд оролцчихсон байсан. Та мэдэж байгаа. Тийм учраас 3 дахь болон 4 дэх тал байхгүйгээр 2 улсын Засгийн газар хоорондоо хэлэлцээр хийе. Их Хурлаараа батлуулъя гэсэн. Энэ нь илүү ил тод, ойлгомжтой болох болов уу гээд ингээд л өнөөдрийн энэ маргаан эцэслэгдэж байгаа маань ерөөсөө л энэ 3 зарчим дээр л эцэслэгдэж байгаа.

Хувийн хэвшилтэй холбоотой яриад байгаа зүйл огт байхгүй. Хууль зөрчсөн эсэх дээр л тодруулж байгаа зүйл байгаа. Хууль зөрчсөн эсэх дээр. Би тантай санал нэг байна. Хувийн хэвшилд буруу байхгүй. Харин гагцхүү төрийн байгууллага өөрийнхөө хэм хэмжээг хэтрүүлсэн үү, үгүй юу л гэдэг асуудал. Монгол Улсын Их Хурлаар оруулах ёстой байсан хэм хэмжээ дээр оруулсан уу, үгүй юу гэдэг асуудал. Засгийн газар тогтоол гаргах ёстой байсан зүйл дээр Ерөнхий сайдын захирамж, эсвэл тэмдэглэлээр эрх хэмжээгээ хэтрүүлсэн үү, үгүй юу л гэдэг асуудлыг л нягталж байгаа юм. Энийг нягтлах ч ёстой. Ийм л зүйл байгаа шүү. Тийм учраас бас том ч сэдэв юм энэ асуудал. Олон ч янзын өнцгөөс янз бүрийн л тайлбарууд явах шиг боллоо. Нөлөөтэй толины тусгалаар янз бүрийн өнцгөөс энэ байр сууриуд гуйвсан байхыг үгүйсгэх аргагүй. Гэхдээ юутай ч бид нар энэ том мэтгэлцээний ард хамтдаа Монгол Улсын парламент, Монгол Улсын улс төрчид хөрш оронтойгоо бас 3 дахь хөрштэйгөө нэгдсэн ойлголтод хүрч чадсан ийм сайн жишээ болж байгаа.

Цаашдаа Шивээхүрэн болон бусад боомтууд, 3 улсын эдийн засгийн төмөр замын коридор болсон төслүүдээ баруун, зүүн коридороо хурдтай явуулахын төлөө Засгийн газар ч бүх чадлаараа л хичээе. Их Хурал дээрээ нээлттэй яг ингээд танилцуулаад явъя. Хамтдаа мэтгэлцье Тэгээд нэгдсэн шийдэлд ороод ингээд явбал бид нар олон асуудлыг бас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд нэмж хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энэ хил холболт, хил дамнасан гээд 2 ойлголт яваад байна гэж. Хил холболт бол өөрөө шууд техникийн асуудал Ганбат гишүүн ээ. Хил дамнасан гэдэг бол хуулийн асуудал. Энэ нарийн царигтай төмөр зам бол хэний өмч байх юм бэ гэж асууж байна. Монгол тал руу орж ирж хийгдэж байгаа бүтээн байгуулалт Монгол Улсын өмч байна. Нарийн царигийн төмөр замын Монголд орж ирж байгаа уртын хэмжээ бол 14км 553 метр байна. Тийм учраас энэ бол Монголын өмч хөрөнгө болно гэдгийг бас албан ёсоор хэлье. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Дашдондогийн Ганбат гишүүн тодруулж асууя.

Д.Ганбат: Ер нь бол тэр царигийн асуудал бол тийм болчхож байгаа юм байна гэж ойлголоо. Ер нь өрсөлдөх чадвар гэж нэг юм байгаа юм. Ер нь нүүрсний бизнес чинь ер нь тээвэр л юм билээ шүү дээ. Аль болохоор ачих, буулгах зардал нь ихсээд л байвал тэр өрсөлдөх чадвар нь буурах ийм л юм билээ. Тэгээд гадна, дотнын хүмүүс уулзаад ярьж байхад бол хэлж байна лээ. Үгүй ээ, танай орж ирж байгаа нүүрс бол ерөөсөө хил гараад л Ганцмодны боомт гараад л 200, 300км дотор л өрсөлдөж байгаа шүү дээ. Цаашдаа ч бараг тийм байх байх. Хэрвээ тэр боломж бололцоо нь гаргаад, дараачийн тэр өсөж хөгжих Энэтхэгийн эдийн засаг байна. Вьетнамын эдийн засаг байна. Хамгийн ойрхон боомт чинь тэр Далиан, Тяньжин 2 байгаа шүү дээ. Тэнд нь хүргэх, мэдээж хэрэг том орнууд чинь өөрийгөө тойрсон жижиг орнууддаа бол далайд гарцгүй хувьд бол тэр боломж бололцоог нь олох олон улсын гэрээ хэлэлцээр байдаг.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Ганбатын Хосбаяр гишүүн асуулт асууж, үг хэлье.

Г.Хосбаяр: Энэ бүтээн байгуулалт, төслийг бол дэмжиж байгаа. Энэ бүтээн байгуулалт, төсөл бол Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хэрэгжих, ихэнх хэсэг нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр байгаа ийм төсөл. Тийм учраас энэ төслийн ер нь зураг төсөл эцсийн байдлаар бэлэн болсон уу. Монгол Улсын норм дүрэм, стандарт, тэр дундаа дэд бүтцийн салбарын стандарт, норм, дүрмийг хангаж байгаа юу. Тэгэхгүй бол бид нар чинь бусад салбарт бас энэ гаднын зураг төслөөр ажил хийх гэхээр Монгол Улсын норм стандарт юманд шаардлага хангахгүй байна гэдэг асуудал яригддаг. Тийм учраас энэ зураг төсөл маань яг эцсийн байдлаар бэлэн болсон уу. Яг 4 сард ажил эхлэхэд, бүтээн байгуулалт эхлэхэд энэ зураг төсөл энэ зүйл дээр саатах зүйл байхгүй биз дээ гэж.

2 дугаарт нь Эрдэнэс Тавантолгой маань бас 900 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт гаргах ийм гэрээ дээр тусгагдсан байгаа. Тэгэхээр энэ санхүүжилтийн эх үүсвэр юм нь суучихсан байгаа юу. Ер нь нүүрсний үнэ унаад бас нүүрсний экспорт буурч байгаа үед энэ санхүүжилт дээрээ саатахгүй биз дээ гэдэг ийм асуудал байна.

Ер нь тэгээд цаашдаа бид нар энэ томоохон төслийн хэрэгжилт дээр яг анхан дунд шат бас онцгой анхаарч ажиллахгүй бол их гоё том төсөл, хууль баталдаг. Их Хурал дэмждэг. Яг бүтээн байгуулалт хэрэгжилтийн шатдаа замхардаг, алдаа дутагдал гардаг ийм зүйлүүд их байгаа. Тийм учраас энэ дээр бас онцгой анхаарч ажиллах шаардлага байгаа.

Мөн өчигдөр Байнгын хорооны хурал дээр хэлсэн бүтээн байгуулалтынхаа үе шатын ажлыг бас сайн эрэмбэлж, түрүүлж хийж болох, түрүүлж хийвэл Монгол Улсад ашигтай ажлуудаа сайн ялгаж салгаж хиймээр байна. Тэгэхгүй бол өмнө нь хэрэгжүүлсэн газрын тосны бүтээн байгуулалтын ажил дээр гэхэд нефть нэрэх үйлдвэрээ хийгээгүй байж байж, түүхий газрын тос татах шугамаа хийгээд байгаа хүмүүс шүү дээ. Тэгэхээр энэ ажлынхаа эрэмбэ дараалал, бүтээн байгуулалтынхаа эрэмбэ дарааллыг сайн тогтоох хэрэгтэй.

2 дугаарт нь нүүрсний бизнес бол тээврийн бизнес юм байна лээ. Тэгэхээр бид нар төмөр замаар нүүрс тээвэрлэх тухай ярьж байна. Энэ боомт, хил холболт хийгдсэнээр 25-30 сая тонн нүүрс л нэмж гаргах ийм хүчин чадал нэмэгдэж байгаа. Өмнө нь өнгөрсөн жил гэхэд бид нар 38 сая тонн нүүрсийг автомашинаар, авто

тээврээр зөөгөөд гаргачихсан байдаг. Тэгэхээр нөгөө талдаа авто тээврээр нүүрс тээвэрлэж байгаа энэ бизнесээ, олон хүмүүсээ бас харж үзэх энэ хүмүүсийн асуудлыг бас нухацтай авч үзэх ийм асуудал байгаа. Тэгэхгүй бол өчнөөн олон Монголчууд, өчнөөн олон хөрөнгө оруулалт хийгээд, олон машин тэрэг аваад, энэ нүүрс тээвэр, нүүрсний экспортод чиглэсэн бизнес хийж байдаг маш олон мянган Монголчууд бас тэр тээвэрт явж байна. Гэтэл энэ төмөр зам ашиглалтад орсноороо энэ хил холболт хийгдсэнээрээ энэ хүмүүсийн бас эрх ашиг яаж хөндөгдөх юм. Энэ талаар бас тодорхой байр суурь хэлээч ээ.

Тэгээд төгсгөлд нь хил холболтын төсөл хэрэгжсэнээр Монгол Хятадын харилцаанд ямар ахиц дэвшил гарах вэ. Ер нь мэдээж шууд ач тус нь бол экспорт нэмэгдэх ийм байгаа. Зүгээр шууд бусаар алс хэтдээ ямар ач тус, ашиг тус гарах вэ. Энэ талаар бас хэлж өгөөч.

Д.Амарбаясгалан: Цэвэгдоржийн Туваан сайд.

Ц.Туваан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ төмөр замтай холбоотой асуудлуудыг нь Дэлгэрсайхан сайд хариулчих байх. Энэ дээр “Эрдэнэс Тавантолгой” компани энэ хөрөнгө оруулалт дээр 976 тэрбум төгрөг буюу 270 орчим сая доллар гаргах ийм төсөөлөлтэй байсан. Тэгээд хэлэлцээрийн уулзалтын ажлын хэсгүүдийн хүрээнд ярилцаад, эндээс 50 орчим сая доллар буюу 170, 180 тэрбум төгрөгийн хэмнэлт гаргаж, хугацаа дээр 22-24 сар болгож, нааш нь урагшлуулж ашиглалтад оруулахаар ийм хэлэлцээрийг хийж байгаа гэдгийг хэлье. Энэ хэлэлцээр байгуулагдсанаар шууд нүүрс борлуулах, экспорт нэмэгдэх, уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар гадагш нь яаралтай, найдвартай, бага өртгөөр хүргэж өгөх гээд шууд нөлөө гарахаас гадна шууд бус бол маш олон дам ашигтай нөлөөнүүд гарч ирнэ.

Дараагийн төмөр замын боомтууд бас харилцан ярианы дүн дээр шууд залгуулаад холбох асуудлууд нь яригдаад эхэлнэ гэж ийм зүйлийг хэлье. Тэгээд бас нэмж зүйл хэлэхэд Монголчууд салхи доорх хүнтэйгээ муудаж болдоггүй гэж үг байдаг. Тэр бол жишээлбэл Туваан салхин доор байгаа айлтайгаа муу байвал саяынх шиг салхи шуурга болоход бас адуу мал нь уруудаад явчих юм бол бас тогтоогоод авах ч юм уу, сураг чимээ хэлэх талаар ярьж байгаа. Тэгэхээр бид нар бол энэ гэрээ хэлэлцээрийг амжилттай хийж чадсанаараа өмнө нь яригдаад гацаад байсан, бид нарт итгэхгүй байсан асуудлуудыг шийдэх ийм нааштай байдал бол шууд харагдаж байгаа. Шууд уулзалт болгон дээр энэ асуудлууд бол нааштайгаар харагдаж байгаа. Монгол Улсын Ерөнхий сайд нийтдээ 4 удаа, яам тамгынхан бас Гадаад хэргийн яамныхан ч гэсэн бусад асуудлыг ярихад харилцаа бол нэлээн сайжирсан, зөөлөрсөн, 2 талынхаа эрх ашгийг хангахуйц байдлаар ийм харьцдаг болсон байна лээ. Энэ асуудал бол энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн өөрөөр хэлбэл Петро Чайна Дайчин Тамсаг, Петро Чайна Синапек зэрэг компаниудтай уулзах дээр хүртэл харагдаж байгаа. Тэгэхээр энэ гэрээний дам нөлөө бол 2 улсын хоорондын харилцаанд бол үнэлж баршгүй ийм эерэг үр нөлөөг үзүүлж байгаа гэж хэлье.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд хариулт өгье.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүний асуултад хариулъя. Энэ хил дамнасан гүүрэн байгууламжийн зураг төсөл бол 2023 оны 9 сард хийгдээд дууссан. Энэ зургийг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төмөр замын зураг төслийн корпорац

хийсэн. Монгол Улсын барилгын тухай хуулиар хуулийн дагуу магадлагдчихсан байгаа. Одоо ажил эхлэхэд бол бэлэн байгаа гэдгийг хэлье. Ингээд гэрээ соёрхон батлагдсаны дараа мөн тендерийн ажил явагдаад, тэгээд бүтээн байгуулалтын ажил эхлэхэд зураг төсөл бол бэлэн байгаа гэдгийг хэлье.

2 дугаарт таны хэлсэн энэ машины тээврийн нүүрсний тээвэр бол өмнө нь бас Монгол Улсын нүүрсний тээврийг нуруундаа үүрч явсан ийм чухал ач холбогдолтой байсан. Тийм учраас цаашдаа ч гэсэн машины тээврийг бид бол хэвийн үргэлжлүүлнэ. Энэ бүх нөхцөлөөр хангаж байгаа. Мөн гарц, орцыг нь нэмэгдүүлэх асуудал дээр ч гэсэн .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Хосбаяр гишүүн тодруулж асууя.

Г.Хосбаяр: Сая Дэлгэрсайхан сайд бас өргөн зам маань Хятадын нутаг руу орно гэж юм хэлчих шиг болох юм. Зураг төслөөр чинь бол тийм юм байхгүй байсан биз дээ. Монголын талд л Монголын нутаг дэвсгэр дээр л бүтээн байгуулалт хийгдэх ийм зураг төсөл байсан. Энэ дээр та бас нэг тодруулга хэлчхээрэй.

Д.Амарбаясгалан: Борхүүгийн Дэлгэрсайхан сайд тодруулж хариулъя.

Б.Дэлгэрсайхан: Хосбаяр гишүүн ээ, энэ нөгөө төмөр замын зураг бол өөрөө хоёулаа өргөн царигийн гүүрэн байгууламж, нарийн царигийн гүүрэн байгууламж хоёулаа зураг нь хийгдчихсэн. Миний түрүүний хэлдгээр Монголын барилгын тухай хуулиар магадлагдчихсан байгаа. Өргөн цариг бол цаашаа Чайна Энержигийн агуулах руу шууд ороод, тэнд буухаар зураг нь хийгдсэн байгаа. Нарийн цариг нь бол Монгол тал руу би түрүүн хэлсэн 14км 533 метрээр орж ирж байгаа. Энэ дээр бас терминал хийгдэнэ. Тийм учраас бол өргөн, нарийн төмөр замын зураг хоёулаа хийгдээд, хоёулаа Монгол Улсын Барилгын тухай хуулиар магадлагдчихсан гэдгийг бас дахин хэлье.

Д.Амарбаясгалан: Монгол улсын ерөнхий сайд нэмж хариулт өгье.

Л.Оюун-Эрдэнэ: Хариулт ер нь сайн явчихлаа даа. Би тэгээд санал хураалт бас болохын өмнө энэ санал хураалтыг дэмжиж өгөхийг бас эрхэм гишүүдээсээ хичээнгүйлэн хүсээд, өмнөх цаг хугацаанд талархаж байгаагаа бас илэрхийлье.

Тэгээд би түрүүн бас хэлсэн. Өнөөдөр бид нар хэнийг ч зөвтгөх, хэнийг ч буруутгах, аль нэг өнцгөөс харах гэхээс илүүтэйгээр бид нар асуудлаа шийдэх нь л Монгол Улсын эрх ашиг. Тэгээд энэхүү хэлэлцээр өнгөрсөн хугацаанд урт хугацаа үргэлжилсэн. Олон ажлын хэсгийн ахлагч нар ажилласан. Бүх ажлын хэсгийн ахлагч нарт бас талархал илэрхийлэхийг хүсэж байна.

Дээрээс нь аюулгүйн зөвлөлөөр олон удаа яригдсан. Бас Монгол Улсын Ерөнхийлөгчид, үе үеийн Аюулгүйн Зөвлөлийн гишүүдэд, мөн Их хурал дээр томоохон хэлэлцүүлэг боллоо. Их Хурлын даргад, мөн Байнгын хороодын дарга нарт би онцгойлон бас Цогтоо гишүүнд Хууль зүйн байнгын хорооны даргад бас талархаж байгаагаа илэрхийлж байна. Яагаад гэвэл парламентаар ийм олон улсын хэлцэл байх нь хамгийн зөв гарцаа гэдгийг Хууль зүйн байнгын хороо маш оновчтой тодорхойлж, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хүлээж авснаар энэ бол маш их олон хуулиудыг өөрчлөх замыг илүү товчилж, бас илүү тийм дэлгэрэнгүй хэлэлцүүлэг болгож чадсан. Тэгээд ажлын хэсгийг салбар эрдэмтэн судлаачид,

парламентад суудалтай намууд, Ардын намынхаа гишүүдэд, Ардчилсан намын удирдлагууд болон Ардчилсан намын ажлын хэсэг дээр оролцсон бүх гишүүдэд Туваан сайдад, ХҮН нам, Иргэний Зориг ногоон нам, Үндэсний эвсэл, Их Хурлын даргын дэргэдэх зөвлөл бид нар маш их олон талаас шүүн ярилцсан. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Тэмүүлэн даргад, Гадаад хэргийн сайд Батцэцэг сайд, манай Дэлгэрсайхан сайд гээд олон хүмүүс энэ дээр олон талаас нь ажилласан.

Тэгээд өнөөдөр бид нар юутай ч хэлэлцүүлгээр анхны хэлэлцүүлэг болж байх үед бид нар яригдаж байсан зүйлээс өнөөдрийн хэлэлцүүлэг бол харьцангуй их мэдээлэлтэй, бас илүү консенсуст орчихсон, мэдээж бүтэн зүйлүүдийг 100 хувь шийдвэрлэж чадаагүй байж болох ч гэсэн бид нар чадах бүх талаараа л Их Хурал, Засгийн газар хамтдаа хичээсэн, зөвшилцсон ийм хэлэлцээр болж чадаж байна гэж бодож байна. Энэ бол тэгээд хамтарсан Засгийн газрын хамтдаа хурдтай хөгжлийн төлөө зориг гарган ажиллая гэсэн 14 мега төслийн хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн эдийн засгийн хувьд хамгийн чухал ийм төсөл. Тэгээд мэдээж нүүрсний үнэ дээшээ, доошоо савлаж байгаа, дэлхийд худалдааны дайнтай байгаа энэ үед эдийн засгийг тогтворжуулах дараа дараагийн алхам яриа хэлэлцээрт ч гэсэн энэ удаагийн шийдэл өнөөдрийн Монгол Улсын парламентаар соёрхон батлахаар санал хураалт бол түүхэн..../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ингээд Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо Байнгын хорооны саналаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг соёрхон баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 87 гишүүн дэмжиж, 79,1 хувиар санал дэмжигдсэн байна.

Улсын Их Хурлын гишүүн Хэрлэн, Энхцэцэг, Дамдинням, Жавхлан, Учрал, Бадрахын Найдалаа, Мөнхтуяа, Батчимэг, С.Ганбаатар, Г.Ганбаатар, Энхбатын Болормаа, Жигжидийн Батжаргал гэсэн гишүүд, Халтмаагийн Баттулга гэсэн гишүүд дэмжсэнээр протокол тэмдэглүүлье гэж байна. Тийм ээ. Дэмжсэнээр протокол тэмдэглүүлье. Ингээд нийт дүнгээрээ 98 гишүүн дэмжсэн байна. Чуулганы хуралдаанд 110 гишүүн бүртгэлтэй байгаа.

Тэгэхээр энэ дүн дэмжсэн гишүүдийн тоог нэмээд, дэмжсэн хувь өөрөөр гарах байх гэж бодож байна. Ингээд Улсын Их Хурлын нийт гишүүдийн олонх дэмжсэн тул “Гашуусухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай хэлэлцээр” соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн баталсанд тооцлоо.

Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсэгт талархал дэвшүүлье.

Үдээс өмнөх чуулганы нэгдсэн хуралдаан үүгээр завсарлаж байна. 14 цаг 30 минутад үдээс хойших хуралдаан эхэлнэ.

13.24 цаг.

ЗАВСАРЛАГА

Д.Амарбаясгалан: Үдээс хойших чуулганы хуралдаанаа эхлүүлье. Гишүүд танхимдаа орж ирье.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцэнэ.

Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Одонхүүгийн Мөнхсайхан танилцуулна. Индэрт урьж байна.

О.Мөнхсайхан: Монгол Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхэнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 3 дугаар дүгнэлтийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай.

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим. 16 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Г.Баясгалан даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, илтгэгч Б.Болдбаатар нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч иргэн С.Номынбаясгалан, түүний өмгөөлөгч З.Тамир болон Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг нар оролцлоо.

Энэхүү хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 14 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 9 дэх заалтын холбогдох зохицуулалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцэв.

Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 3 дугаар дүгнэлт нь нийт 24 нүүр, түүний үндэслэл хэсэг нь дангаараа 17 нүүр болсон учраас та бүхэнд дүгнэлтийн үндэслэл хэсгийг товчилж, тогтоох хэсгийг бүхэлд нь уншиж сонсгоё.

Үндэслэл. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгох, сонгох эрхтэй.” гэж заасныг цогцоор нь авч үзвэл иргэн бүр сонгуульд оролцох буюу сонгох, сонгогдох тэгш боломжоор хангагдахаар байх бөгөөд үүнийг Үндсэн хуулиар хамгаалсан болохыг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт удаа дараа тэмдэглэж байжээ.

Сонгуульд оролцох тэгш боломж нь сонгуулийн өрсөлдөөний нөхцөл оролцогч бүр шударгаар үйлчлэх, улмаар сонгох, сонгогдох эрхийг эдлүүлэх урьдач нөхцөл болно. Үндсэн эрхэд тавих аливаа хязгаарлалт нь тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зэрэг зарчимд нийцэх шаардлагатай. Сонгуулийн жил эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн төдийгүй бусад иргэн хийсэн ажлын тайлангаа тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх болон хуулиар хориглоогүй бусад арга хэмжээ явуулах нь нээлттэй байна.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгээр Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө хийсэн ажлынхаа тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийхийг илт зөвшөөрч, харин Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд ийнхүү зөвшөөрөөгүй байна. Эдгээр зохицуулалт нь дараах үндэслэлээр тодорхой, тохирсон, ялгаварлан гадуурхаагүй байх зарчмыг хангахгүй байх тул иргэний сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсан байна.

Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хууль дээдлэх” зарчмын дагуу үндсэн эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах бөгөөд уг хязгаарлалт нь хоёрдмол утгагүй, тодорхой, үр дагаврыг урьдчилан таамаглаж мэдсэнээр зан үйлээр нийцүүлэх боломжтой байхаар хуульчилбал зохино.

Гэтэл хуулийн тус хэсгээр нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн ажлын тайлан тараах, уг тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой уулзалт хийх давуу байдлыг олгосон байх бөгөөд ийм боломжийг бусад иргэнд зөвшөөрсөн эсэх нь хуулийн зохицуулалтаас ойлгомжгүй байна. Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайланд ямар шаардлага тавих, ямар мэдээлэл тусгаж болох, эс үгүй бол болохгүй, сонгуулийн сурталчилгааны агуулга оруулж болох эсэх, түүнд хэн, яаж хяналт тавих нь тодорхой хуульчлагдаагүй байна. Тус зохиц зохицуулалтад Улсын Их Хурлын гишүүн нэр дэвшихээр бол ажлын тайлан тараах нөхцөлийг тусгасан бөгөөд ажлын тайлан болон сурталчилгааны материал хоорондын ялгааг тодорхойлоогүй учраас ийм тайлан тараах нэрээр сонгуулийн сурталчилгаа хийх эрсдэлийг үүсгэжээ. Гишүүний хийсэн ажлын тайланг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй гэж хуульчилсан тул сурталчилгааны материалд тавигдах шаардлагыг хангахгүй байхыг зөвшөөрсөн байна.

Тус хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийн энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй гэдэгт юуг хамруулан үзэх нь тодорхойгүй байна. Энэ заалт хуулиар хориглоогүй бол иргэн зөвшөөрөх зарчмыг хуульчлах зорилготой бол яагаад гагцхүү Улсын Их Хурлын гишүүнд зориулан тусгайлан заасан үндэслэл тодорхойгүй байна. Иймээс эрх зүйн тодорхой байдал хангагдсан гэж үзэх үндэслэлгүй юм.

Тохирсон байх зарчмын дагуу үндсэн эрхийн хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх гэсэн шалгуурыг хангах шаардлагатай. Улсын Их Хурлын гишүүн тайлан тараах, уулзалт хийх давуу байдал олгосон нь сонгогчидтой нягт холбоо эгэх хариуцлагатай байх хууль ёсны зорилгод хүрэхэд уялдаатай байх боловч адил байдлаар тайлан тараах, уулзалт хийхийг

Улсын Их Хурлын гишүүн бус иргэнд илт зөвшөөрөөгүй учраас сонгуульд оролцох тэгш боломжийг хамгийн бага хязгаарласан арга зам гэж үзэхгүй тул зайлшгүй байх шалгуурт нийцэхгүй байна.

Парламентын гишүүн ард түмнийг төлөөлж гүйцэтгэсэн ажлын тайлангаа танилцуулахыг зөвшөөрөх нь үндэслэлтэй байж болох ч ирээдүйд ард түмнийг төлөөлөх хүсэлтэй иргэн ч өөрийн үзэл бодол, үйл ажиллагааг нийтэд танилцуулах адил боломжоор хангагдах хэрэгтэй.

Түүнчлэн маргаан бүхий зохицуулалт нь сонгуульд оролцох тэгш боломжийг алдагдуулсны зэрэгцээ Улсын Их Хурлын гишүүн бус иргэн адил байдлаар тайлан тараах, сонгогчидтой уулзах нь сонгогдох эрхээ эдлэх боломжгүй болох буюу нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах, эсвэл нэр дэвшигчийг бүртгэсэн шийдвэрийг хүчингүй болгох ноцтой үр дагаварт хүргэх эрсдэл дагуулж, улмаар гишүүн болон бусад иргэний хооронд шударгаар өрсөлдөх нөхцөлийг алдагдуулж байх тул тэнцвэргүй байна.

Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн бүр эрх тэгш байх зарчим нь үндсэн эрхийг эдлүүлэх болон бусад хүрээнд хүмүүст дур мэдэн буюу зохих үндэслэлгүйгээр ялгаатай хандахыг хориглох зэрэг өргөн агуулгатай. Нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа тараах, тайлангаа танилцуулах зорилгоор уулзалт хийх замаар өөрийгөө сонгогчдод таниулах давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр бий болгосон байх тул ялгаварлан гадуурхсан шинжтэй байна.

Улсын Их Хурлын гишүүн нь ард түмний элч болохын хувьд бусад иргэнээс эрх зүйн байдлын хувьд ялгаатай субъект мөн боловч сонгуулийн жил эхэлснээс нэр дэвшихээр бол нэр дэвших сонирхол бүхий бусад иргэнтэй адил эрх зүйн байдалтай гэж үзэх тул сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн хязгаарлалт, эрх, үүрэг нь нэгэн адил үйлчилнэ. Тухайлбал сонгуулийн жил эхэлснээс хойш нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэх хүртэлх хугацаанд буюу сонгуулийн сурталчилгааны хугацаанаас өмнө Улсын Их Хурлын гишүүний сонгогчдод ажлын тайлан тараах, уулзалт хийх боломжийг бусад иргэнтэй адилхан хязгаарлах, эсвэл ийм тайлан тараах уулзалт хийх боломжийг Улсын Их Хурлын гишүүн болон бусад иргэнд адилхан эдлүүлэх зэрэг тэнцвэржүүлэх зохицуулалтыг тодорхой хуульчлах нь тохирсон байх, ялгаварлан гадуурхаагүй байх зарчимд нийцнэ.

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүний эрхийн хорооны 25 дугаар ерөнхий тайлбарт зааснаар иргэн, нэр дэвшигч, сонгогдсон төлөөлөгч нар хоорондоо нийтийн болон улс төрийн аливаа асуудлаар мэдээлэл, үзэл бодлоо чөлөөтэй солилцох боломжтой байх нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактын 25 дугаар зүйлд заасан сонгох, сонгогдох эрхийг баталгаатай эдлэх урьдач нөхцөл болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг нь фактаар хамгаалагдсан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг, үүний дотор улс төрийн материал хэвлэн нийтлэх, сонгуулийн сурталчилгаа явуулах, улс төрийн үзэл санаагаа сурталчлах эрх чөлөөг хязгаарласан байх ч Улсын Их Хурлын гишүүнд бусад иргэнээс илүү давуу байдлыг зохих үндэслэлгүйгээр бий болгосон нь фактын 25 дугаар зүйлд заасан эрх

боломжийг ялгаварлан гадуурхалгүйгээр эдлүүлэх үзэл баримтлалд нийцэхгүй байгааг тэмдэглэж байна.

Европын Аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын ардчилсан институт хүний эрхийн газраас 2016, 2020, 2024 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг ажиглаад гаргасан тайланд маргаан бүхий зохицуулалтын талаар удаа дараа дүгнэсэн байна. Тухайлбал Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн ажиглалтын талаарх эцсийн тайланд ерөнхийдөө өрсөлдөгчид чөлөөтэй хөндлөнгийн оролцоогүйгээр кампанит ажил явуулсан хэдий ч кампанит ажил явуулах тэгш бололцоогоор дутагдаж байв гэж дүгнээд, үүний нэг шалтгааныг нэр дэвшихээр горилогчид албан ёсны сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө сурталчилгаа явуулахыг хуулиар хориглодог. Гэсэн хэдий ч одоогийн Улсын Их Хурлын гишүүнд дахин нэр дэвшихийг зорьж буй нэр дэвшигчээр бүртгүүлэх үйл явц эхэлсэн эсэхээс үл хамааран сонгогдсон төлөөлөгчийн хувиар өөрийгөө сурталчилж болно. Уулзсан маш олон хүн хуулиар зөвшөөрсөн тул одоогийн Улсын Их Хурлын гишүүд, төрийн өндөр албан тушаалтнууд сонгууль болохоос өмнө хэдэн сарын турш идэвхтэй кампанит ажил явуулж байсан талаар мэдэгдсэн юм хэмээн тайлбарласан байна.

Сонгуулийн үеийн хууль зүйн зохицуулалтын талаар харьцуулсан судалгаанаас үзвэл дийлэнх ардчилсан улсад сонгуулийн жилд ажлын тайлан тараах, сонгогчидтой уулзах давуу байдлыг парламентын гишүүнд олгохоос татгалзаж, харин үзэл бодлоо эрэлхийлэх эрх чөлөөнд тавих хязгаарлалт нь парламентын гишүүн болон бусад иргэнд тэгш үйлчлэх, парламентын гишүүний давуу байдлыг хязгаарлаж, сонгуульд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх чиг хандлагатай байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэцийн шийдвэр буцаж үйлчлэх хүрээг тодорхойлсон учир энэхүү дүгнэлт нь гарсан цагаасаа хойш үйлчлэх бөгөөд буцаж үйлчлэхгүй үр дагавартай болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг удирдлага болгон Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь:

Нэг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой

хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээнд сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгох, сонгох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Гурав.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсгийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Дөрөв.Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

Даргалагч Г.Баясгалан, гишүүд Ж.Эрдэнэбулган, Д.Гангабаатар, О.Мөнхсайхан, Б.Болдбаатар.

Анхаарлаа хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Одсүрэнгийн Номинчимэг танилцуулна. Индэрт урьж байна.

О.Номинчимэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэгээс Байнгын хорооны гишүүд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэболд Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийн үндэслэл болон Улсын Их Хурлын гишүүн өөрийн сонгогдсон тойргоос өөр тойрогт ажлын тайлангаа танилцуулж болох эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Улсын Их Хурлын гишүүн ард түмнээ төлөөлөх бүрэн эрхийн хугацаа 4 жил бөгөөд сонгуулийн жил гишүүд иргэд сонгогчдод хийсэн ажлынхаа тайланг танилцуулах уулзалт хийх нь Үндсэн хуулийн зөрчил гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 3 дугаар дүгнэлт нь учир дутагдалтай байгаа талаар, улс төрийн намын жагсаалт болон тойргоос сонгогдсон гишүүд тайлангаа тавихтай холбоотой зааг ялгаа, хүрээ хязгаарын талаар мэдээлэл

гаргагч болон Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч талуудын хооронд мэтгэлцээн өрнөсөн эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй талаар, Үндсэн хуулийн цэц зөвхөн Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчийн сурталчилгаа гэдэг өнцгөөс бус иргэд өөрийнхөө сонгосон гишүүний ажлын тайлантай танилцсаны дараа сонголтоо үргэлжлүүлэх эсвэл өөр хүнийг сонгох эсэхээ шийдвэрлэх сонгогчийн эрхийн талаар бодолцож анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр Үндсэн хуулийн цэц дүгнэлтээ гаргахдаа улс төр, эрх зүйн үр дагаврыг дутуу үнэлсэн талаар, Улсын Их Хурлын гишүүний 4 жилийн бүрэн эрхийн хугацааг 6 сараар хязгаарлаж байгаа нь Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүнийг хавсран гүйцэтгэх тохиолдолд Засгийн газрын гишүүдэд ажлын тайлангаа тавих ялгамжтай байдал бий болгож байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг агуулгаар нь дэмжиж байгаа талаар байр сууриа илэрхийлж, сонгуулийн жил Улсын Их Хурлын гишүүд их хэмжээгээр тайлан танилцуулга тараадаг, иргэд сонгогчдыг гадагшаа явуулдаг зэрэг асуудлуудыг цэгцлэх, Улсын Их Хурлын гишүүн өдөр бүр иргэд олон нийтдээ тайлангаа тавьж байх, 4 жилийн бүрэн эрхийн хугацаанд ажлын гүйцэтгэлээрээ өөрийгөө таниулах зэрэг асуудалд анхаарч ажиллах талаар, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн гол агуулга нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасан Улсын Их Хурлын гишүүний ажлын тайлан болон нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа 2-ын зааг ялгааг нарийвчлан зохицуулах, тайланд юу тусгах, эс үгүй бол тусгахгүй байхыг тодорхой болгох, хууль зүйн үг хэллэг найруулгаар засах зэргийг агуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар Үндсэн хуулийн цэцийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй, сонгогч өөрийн сонгосон Улсын Их Хурлын гишүүний ажлын тайлантай танилцах нь эрхийг хязгаарлаж болохгүй талаар тус тус үг хэллээ.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн хуулийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагууд сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн, мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагаас сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн

хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Цэцийн дүгнэлтийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гончигдоржийн Уянгахишиг танилцуулна. Индэрт урьж байна.

Г.Уянгахишиг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9, 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд ирүүлснийг Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан журмын дагуу 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн талаарх товч танилцуулгыг танилцуулсан.

Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн тохиолдолд сонгуульд оролцох тэгш боломжийг хангах үүднээс аль нэг субъектэд үндэслэлгүйгээр давуу байдал олгохгүй байх хүрээнд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн холбогдох зохицуулалтыг тодорхой болгох нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахишиг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлийн тодорхой хэсгийг хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлээд, сонгуульд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бий болгож, сонгох, сонгогдох эрхийг хэн бүхэнд тэгш эдлүүлэх, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь зүйтэй талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүний хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “тэгш байдал, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” Мөн зүйлийн 2 дахь хэсэгт “хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад “төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.” гэснийг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн байна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгье. Ингээд 12 гишүүн, 13 гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгээд Улсын Их Хурлын гишүүн тайлангаа хэвлүүлж, ард иргэдэд танилцуулах, тэгээд түүгээр дамжуулан иргэдтэй уулзах энэ ажлыг ерөнхийдөө энэ цэцийн дүгнэлтээр хязгаарлаж байгаа юм байна. Тэгэхээр энд хамгийн гол асуудал нь яах вэ, тайлан энэ тэр дээр гол нь биш хамгийн гол нь иргэдтэй уулзах тэр уулзалтын маань ерөнхийдөө бас нэг тийм хязгаарлах агуулга энэ Цэцийн дүгнэлт дотор бас орсон гэж би үзэж байгаа. Тэгэхээр яах вэ, залхуу хүмүүс бол ашгүй ингээд хаагаад иргэдтэй уулзахгүй нь гэж бодож байж магадгүй. Мань мэтийн уулзаад явж байдаг хүмүүст энэ бол маш том хохирол болох юм байна. Тэгэхээр энэ зүйл дээр ингээд харж байхад бол яг үнэхээр хэрэггүй бандгар бандгар, том том сэтгүүлүүд гаргадаг. Тэр сэтгүүл дээрээ баахан өөрсдийгөө сурталчилсан зүйлийг хийдэг л дээ. Тэгэхээр энэ дээр чинь бас яг ингээд сүүлийн 6 сарын бас улс төрийн үйл ажиллагааг бас тодорхой хэмжээгээр хязгаарлаад байна. Жишээ нь өнгөрсөн 2024 оны 1 сард би 1 тогтоолын төсөл батлуулсан. 2024 оны хаврын чуулганаар би 1 хууль, 1 тогтоолын төслийг батлуулсан. Тэгэхээр энэ 1 хууль 2 тогтоолын төслөө ард иргэддээ тайлагнах тэр боломжийг минь хаагаад хаячхаж байна шүү дээ. Тэгэхээр энэ бол болохгүй.

Тэгэхээр ер нь бол яах вэ энэ тайлангуудыг гаргадаг нь заримдаа хэтрээд байгаа учраас энэ хүмүүс өргөдөл гаргасан байх л даа. Жишээ нь миний энэ бол өнгөрсөн 2024 оны сонгуулиар гаргасан хөтөлбөр, тайлан хоёулаа хамтдаа 14 хуудастай. Тэгээд 4 аймаг дээр бол ийм сэтгүүл гаргаж, хэвлүүлэх бол маш их тийм хүнд байсан. Надад бас хэцүү байсан л даа. Тийм учраас би нөгөө Их Хурлын гишүүд шиг өвөл нь тайлан гаргачхаад, хавар нь дахиж мөрийн хөтөлбөр, сэтгүүл гаргаж ганцхан хамтатгаад нэгхэн л юм гаргасан.

Гэтэл энэ зохицуулалтаар чинь Их Хурлын гишүүдийг хаачхаад, Засгийн газрын гишүүдийг хэвээр нь үлдээчхэж байгаа байхгүй юу. Засгийн газрын гишүүд

өөрсдийнхөө Засгийн газрын үйл ажиллагааг танилцуулах замаараа сэтгүүл хэвлээд, тэрийгээ тараагаад явчхаж болох юм байна. Бас аймгийн Засаг дарга нар өөрсдийнхөө ажлыг тайлан гаргах замаараа энэ сэтгүүлээ хэвлээд гаргаад явчих юм байна. Ийм л зүйлийг хийгээд байна. Жишээ нь өнгөрсөн сонгуулиар 1 аймгийн дарга 78 сая 752 мянган төгрөгийг сэтгүүл хэвлэхэд гаргаж, тэр Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хөрөнгөөр ажил, үйлчилгээг худалдан авах тухай хууль баахан хуулийг 76 сая төгрөгийг л ард түмний хөрөнгөөс, аймгийн төсвөөс аваад, тэгээд л өөрсдийгөө сурталчлахын тулд ингээд хэрэглээд явчихсан байна шүү дээ. Ийм давуу талыг бусад хүмүүст бий болгож өгчхөөд, тэгээд зөвхөн Их Хурлын гишүүд яг энэ танхимдаа суугаад, яг энэ хууль тогтоох тэр үйл ажиллагаандаа ажлаа явуулж байгаа тэр гишүүдийг нь хязгаарлаад, Засгийн газрын гишүүд, аймгийн дарга нар болон бусад албан тушаалтнуудад хэвээр үлдээж ерөөсөө болохгүй. Тийм учраас энэ дээр манай Их Хурал бас тодорхой хэмжээнд мэдээж бусад нэр дэвшигч нараас илүү давуу тал бий болгож байгаа. Тэгэхдээ энэ дээр бас нэг тодорхой бас хувилбар гаргаж, тэр өргөдөл өгч байгаа хүмүүсийн тэр асуудлыг бас тодорхой хэмжээгээр шийдэнгээ бас яг зөвхөн Их Хурлын гишүүдийг ингээд хязгаарлаж орхиж болохгүй гэсэн ийм саналтай байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сандагийн Бямбацогт сайд асуулт асууж, үг хэлье.

С.Бямбацогт: Би бас энэ цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж байгаа юм. Сая Пүрэвдорж гишүүн Засгийн газрын гишүүд, аймгийн Засаг дарга нарт бас давуу байдал бий болох гээд байна. Гишүүд жоохон дутуу болчих гээд байна гэж байх шиг байна. Тэр агуулгаараа биш. Яагаад Их Хурлын гишүүдийг иргэдтэй, сонгогч нартай уулзах, тайлангаа тавих бололцоо боломжийг хаах гээд байгаа юм бол. Гол нь иргэдтэй уулзаж, иргэдээрээ дүнгээ тавиулж, тайлангаа тавьж, дахиж сонгогдох уу, сонгогдохгүй юу гэдгээ бас мэдрүүлж, мэдэрч, имрүүлж, тэмтрүүлж үзэж байж сонгогчид маань саналаа өгдөг л баймаар байгаа юм л даа. Шийдвэр гаргадаг. Ингэхэд нь л саад болох гээд Их Хурлын гишүүд сонгогдоод, алга болчихдог. Тайлан тавих гэсэн тайлан тавихыг хориглочихсон учраас тайлангаа тавьж чадсангүй гээд тайлан ч тавьдаггүй, ажил ч хийдэггүй, худлаа иргэдээ хуураад явчихдаг ийм байдлыг л өөгшүүлсэн ийм л хууль болох гээд байна.

Нэг талаасаа ингээд ялгаварлан гадуурхаж болохгүй иргэдийг албан тушаал, эрх мэдэл, юугаар нь Үндсэн хууль зөрчсөн байна гээд, нөгөө талаас нь сонгогчдын сонгуулийн эрх тэгш, шударга байдлыг хангахгүй байна гэсэн малгайн доор л орж ирж байгаа юм л даа. Гэтэл энэ чинь нөгөө талаасаа үзэх юм бол иргэдийн сонгох, сонгогдох эрхийг зөрчих нь. Сонгох, сонгогдох.

Тайлангаа тавьдаг, иргэдтэйгээ эргэх холбоотой ажилладаг, ажил хийдэг бас уулзах нүүртэй ийм гишүүдийг уулзахыг нь хязгаарлах гэж байна. Мэдээж тийм алга болчихдог нөхдүүдэд тайлангаа тавьдаггүй, ажил хийдэггүй, иргэдтэй уулздаггүй нөхдүүд тайлан тавихыг хориглосон учраас би очихгүй, очих боломжгүй байна, уулзах боломжгүй байна гээд ийм хүмүүст нь боломжийг бий болгох гэж байна. Ингэж болохгүй л дээ. Ингэж болохгүй.

Нөгөө талаасаа бас түрүүн ярьж байгаа иргэдийн мэдэх эрх. Үнэхээр хэн нь хэн бэ гэдгийг Их Хурлын гишүүн сонгогдсон нөхөр 2024 онд сонгогдоод юу хийв, ямархуу ажиллав, 2028 онд эргээд ирэхдээ ямар тайлантай ирэх нь вэ гэдгийг мэдэх эрхийг нь бас хязгаарлах гэж байгаа юм. Улсын Их Хуралд сонгогдоно гээд очихдоо уурыг нураана, усыг эргүүлнэ. Би ёстой танай сумыг ёстой орвонгоор нь эргүүлж

хөгжүүлнэ гэж амладаг, ярьдаг. Мөн бас сонгогчдод нисдэг тэрэгнээс мөнгө тараадаг, ямааны ноолуур 50 мянгатай байхад нь 100 мянган төгрөгөөр ямааны ноолуурыг чинь худалдаж авна гэж саналыг нь худалдаж авдаг, ингээд сонгогддог. Сонгогдсон мөртөө алга болж байсан, алга болчихдог, сураггүй алга болсон олон гишүүд байдаг. Тэр аймагтай, тэр тойрогтой, дахиж очоогүй, алга болчихсон ийм хүмүүст л боломж олгох гээд байна л даа. Тэгээд л тойрог тойрог солиод л, худлаа яриад л, худлаа амлаад л, мөнгө тараагаад л, тэгээд л сонгогддог. Сонгогчид өөр тойрогт очдог, очоод тайлангаа тавьдаггүй ийм хүмүүсийг дэмжсэн ийм заалт болох гээд байна. Тийм учраас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг бид бас хүлээж авахгүй байх ёстой байх. Ийм ажил хийдэггүй, худлаа амладаг, мөнгө тараадаг, эд материал тараадаг ийм хүмүүсийг дахиж сонгогдох, өөр тойрогт очиж ажиллах бололцоо боломжийг нь бий болгох ийм асуудал болох нь байна шүү гэдгийг бас 1 дүгээрт нь хэлье.

Тэр тайлан сэтгүүл гээд эд материал, тайлан сэтгүүл тараахгүй байж болно. Амаараа уулзаад, биеэрээ уулзаад, амаараа яриад, өөрийнхөө хийсэн ажилтай, хэлэх үгтэй хүн бол тэгээд уулзахаас айхгүй, ичихгүй очоод уулзана. Эд материал, тайлан сэтгүүл тараахгүй, уулзах бололцоотой байдаг. Энэ боломжийг нь л хангаж өгөх ёстой байх. Энэ боломжийг нь. Тэр тайлан сэтгүүлийг нь юу гэдэг юм хийлгэхгүй байж болно. Энэ том тойрогт угаасаа тэр олон 100 хуудастай, олон 100 мянган тийм тайлан сэтгүүл хийгээд тараах нь бас илүү ч зардалтай байх. Түүний оронд харин иргэдтэйгээ очоод уулздаг, хийсэн ажилтай, хэлэх үгтэй. Тэрийгээ бас .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Сүхбаатарын Эрдэнэболд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

С.Эрдэнэболд: Энэ Улсын Их Хурлын олон сонгогдсон гишүүд энэ цэцийн дүгнэлтээ сайн уншиж байж уянгалмаар байна. Тэр имрүүлэх, бариулах наад цаадах юмаа яримаар байгаад байгаа юм. Энэ цэцийн дүгнэлт дээр ингэж байна шүү дээ. 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд буюу тараах материалын тухай л энд ярьж байна шүү дээ. Тараах материалын тухай ярьж байгаа болохоос биш уулзахыг хориглоогүй байгаа. Нэг.

Сая жишээлбэл 2024 оны сонгуулиар болсон би бодитой факт ярья. Жишээлбэл ингээд 2023 оны 12 сар өнгөртөл аймаг болгон тусдаа 1, 1 тойрог байсан. Сонгуулийн хууль гэнэт өөрчлөгдсөн. Ингээд 6 сар, 7 сарын дараа болох гэж байгаа сонгууль нь 3 юм уу 4 аймаг нийлээд 1 болохоор болчихсон. Тэгэнгүүт хуучин Их Хурлын гишүүн хийж байсан хүмүүс нь өөрийн сонгогдоогүй тойргууд буюу сонгогдоогүй аймгууд дээр тайлан сонин хэвлэж тараасан байхгүй юу. Энэ чинь эргээд шударга ёсны зарчим буюу тэгш өрсөлдөөнийг алдагдуулсан.

Тэгээд саяын Пүрэвдорж гишүүний хэлж байгаа, Бямбацогт гишүүний хэлж байгаа үгнүүд дээр аргумент алга байна гэж харж байгаа юм. Яагаад аргумент алга байна гэхээрээ нөгөө олон сонгогдсон хүний дархлагдсан нүдээр та нар асуудлыг хараад байна шүү дээ. Энэ дотор чинь бол уулзалт хийхийг хориглоогүй байна. Зөвхөн тэр тараах материалыг яах вэ гэдэг зүйлийг л хэлж байна шүү дээ. Энэ бол өрсөлдөөний тэгш бус нөхцөл байдлыг үүсгээд байгаа юм. 1 дүгээр асуудал нь.

Одоо шинэ залуучууд улс төрд цус сэлбэх гэж байгаа, улс төрд шинэ төрлийг авчрах гэж байгаа залуучуудад энэ бол хаалттай зохицуулалт байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр ингээд Их Хурал дотор ороод ирчхэнгүүтээ дархан эрхээ баталгаажуулчхангуутаа дараа дараагийн олон хүмүүсийн үүд хаалгыг нь хаах гэж байгаа маягийн юмыг ингэж нам дамнаж та нар ярьдгаа болих хэрэгтэй шүү дээ. Тийм учраас энд нэг зүйл хэрэгтэй байгаа. Өөрөөр хэлбэл, зохицуулалтыг нарийн болгох, тараах материал гэж юуг хэлэх юм бэ, тараах материал дээр юу юуг оруулах юм бэ гэдэг зохицуулалтуудыг хуульдаа нарийвчилж оруулах тухай болохоос биш Цэцийн энэ асуудлыг бүхэлд нь ингэж гуйвуулж болохгүй гэсэн тийм байр суурьтай байна.

Д.Амарбаясгалан: Пүрэвжавын Сайнзориг гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. Би энэ Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын дүгнэлтийг бас хүлээн зөвшөөрөх боломжгүй гэдэг л асуудлыг ярих гэж байгаа юм. Тэгэхдээ бас шууд нэг сэтгэл хөдлөлөөр боломжгүй гэж хэлэхээсээ илүүтэй бас хэд хэдэн үндсэн шалтгаан байгаа юм. Энэ дээр түрүүн бас хэд хэдэн гишүүд хэлээд байгаа юм. Яг энэ улс төрийн сонгуульд нэр дэвших ч гэдэг юм уу, улс төрийн албан тушаалыг хашиж байгаа хүмүүс гэхээсээ илүүтэйгээр иргэдийнхээ тэр мэдэх эрх, ямар хүнийг сонгосон юм, ямар ажлууд амжуулсан юм гэдэг зүйлүүдийг мэдэж байж дараагийн энэ сонголтыг үргэлжлүүлэх үү, эсвэл өөр хүнийг сонгох уу гэдэг ийм шийдвэр гаргах боломжийг нь бас олгох үүднээс гишүүд бол бас тодорхой хэмжээний тайлан, хуулийг сурталчлах энэ үйл ажиллагаануудыг хийх нь зөв байгаад байгаа юм.

Дээрээс нь яах вэ зүгээр улс төрийн хувьд заавал сонгуулийн жилд тайлан мэдээ хүргэж байгаа хүн болгон улс төрийн ээлжит сонгуульд нэр дэвшинэ гэсэн үг биш. Магадгүй улс төрийн үйл ажиллагааныхаа ерөнхий тайланг тавих, ямар ажлууд хийсэн гэдгээ тайлагнаад энэ улс төрөөс гарах гэж байгаа хүмүүс ч бас байж болно. Тэгэхээр энэ хүмүүсийн боломжуудыг бас нэг талдаа хаачхаж байна уу.

Тэгээд Байнгын хороо дээр Цогтбаатар дарга нэлээн чухал санаа хэлсэн юм. Энэ улс төрийн албан тушаал хашиж байгаа хүмүүс чинь бол иргэд олон нийтдээ нээлттэй мэдээллээ хүргэх үүрэгтэй юм. Үүрэгтэй. Энэ үүргийг нь ингээд шууд автоматаар байхгүй болгочхож болохгүй. Нөгөө талдаа бас зарим асуудлаараа Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хязгаарлачхаад байна уу даа гэж үзэж байгаа юм. 4 жилээр ард түмэндээ нээлттэй ил тодоор үйл ажиллагаагаа тайлагнаад явах энэ үүрэгтэй 4 жилийн албан тушаалын хугацааг нь 3,6 жил болгоод үндсэндээ ингээд Үндсэн хууль болон бусад хуулиар олгогдсон тэр бүрэн эрхийн хугацааг нь хязгаарлах нөхцөл байдал үүсчих вий гэдэг ийм бас зүйл байна.

Тийм учраас энэ зүйлүүдийг анхаарах, магадгүй зүгээр хууль тогтоомжийг боловсронгуй болгох зүйл байж магадгүй. Яг жоохон цаг хугацааны хязгаарлалтыг сонгуулийн сурталчилгаа эхлэхээс өмнө бас тодорхой болгоод өгөх, хэлбэрийг нь тодорхой болгоод өгөх, хэмжээг нь тодорхой болгоод өгөх зүйлүүд бол байж болно. Түүнээс биш яг огтоосоо ингээд ард түмнээс сонгогдсон гэдэг юм уу, энэ сонгуулийн үр дүнд гаргаж ирсэн хүмүүсийг сонгуулийн жил эхэлснээс хойш ард түмэнтэйгээ тайлагнаж уулзаж, юу хийсэн тухайгаа тайлагнах асуудлыг нь бол хязгаарлах нь буруу.

Сонгуулийн амлалт өгөх, эд материал тараах гэдэг зүйл чинь угаасаа хориотой байгаа байхгүй юу. Тэгэхээр үүний ийм ялгамжтай байдлыг бас ойлгож байж явах нь зөв байгаа юм гэдэг зүйлийг би зүгээр хэлмээр байгаа юм. Тэгээд үндсэндээ цэцийн энэ шийдвэрийг бас зохистой хэмжээнд иргэдийн тэр мэдэх эрхийг хаачих гэдэг болгоомжлолоос нь би илүү түлхүү хэлж байгаа гэдэг зүйлийг бас энэ ташрамд хэлэхийг хүсэж байна.

Тэгээд Үндсэн хуулийн шийдвэрийг хүлээж авах шаардлагагүй гэж л хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Сүхбаатарын Эрдэнэбат гишүүн асуулт асууж, үг хэлье. Алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууж, үг хэлье.

А.Ариунзаяа: Цэцийн дунд суудлын шийдвэртэй холбоотойгоор дүгнэлт нь 2 агуулгыг оруулж байгаа юм байна. Нэг дэх нь болохоор 1 дүгээр заалт дээр сая Эрдэнэболд гишүүний хэлсэнчлэн Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох гэдэг энэ агуулгыг буруу юм байна гэдгийг дүгнэсэн байна.

2 дахь нь болохлоор энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалтыг бас хориглох нь зүйтэй гэдэг ийм шийдвэрийг гаргасан байгаа юм байна.

Тэгэхээр энэ 2 агуулгаар тайлан болон уулзалтыг аль алиныг нь буруу гэж дунд суудлаар дүгнэсэн. Гэтэл энэ маань өөрөө эргээд Улсын Их Хурлын хууль Үндсэн хуулиасаа бүр эхлэх байх. Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 2-т Улсын Их Хурлын тухай хуулийн 7.4-д гишүүний бүрэн эрх нь хэзээ дуусах вэ гэхээр дараагийн гишүүн тангаргаа өргөж байж сая гишүүний бүрэн эрх нь дуусна. Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.26-д бүр сонгогчдод гэдэг үгээрээ сонгогчдод үйл ажиллагаагаа мэдээлэх эрхтэй ба үүрэгтэй гэдэг ийм агуулга явж байгаа учраас эргээд энэ ажлыг нь үгүйсгэчихлээр тухайн гишүүн нэр дэвшсэн ч бай, дэвшээгүй ч бай иргэд сонгогчдод мэдээ тайлангаа өгдөг байх, уулзалтаа хийх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхгүй байх тал дээр Үндсэн хууль болоод Улсын Их Хурлын тухай хуулийг ийм зөрчсөн гэдэг юм уу ийм зөрчилтэй дүгнэлтийг гаргасан байна гэж үзэж байгаа учраас ер нь бол би энэ саналыг нь дэмжихгүй байна гэдгээ илэрхийлье.

2 дахь нь болохоор ер нь энэ сонгуулийн сурталчилгааны материалтай холбоотойгоор цаашид яг хамгийн том зардал бол ердөөсөө л энэ сонгуулийн сурталчилгааны материал шүү дээ. Тэгэхээр энийг бусад улс оронтойгоо нэгэн адилаар Сонгуулийн ерөнхий хорооноос нэгдсэн байдлаар түгээдэг байх юм бол энэ зардал болоод хэн нэгэндээ давуу байдал үүсгээд байгаа асуудал байхгүй болох юм.

2 дахь нь болохоор ер нь яагаад тайлангийн уулзалт хийж болохгүй гээд байгаа юм бэ гэхээр тайлангийн уулзалт хийж байна гэдэг агуулгаараа өмнөх түүхийг харах юм бол Улсын Их Хурлын гишүүд нэр дэвших магадлалтай хүмүүсээ дагуулж яваад олон нийтэд таниулаад ийм хуулийн цоорхой гаргаад байгаа нь өөрөө буруу юм. Ийм учраас тайлангийн уулзалтаа хийх гэж байгаа бол Улсын Их Хурлын гишүүн дангаараа л Улсын Их Хурлын энэ сонгогчидтойгоо хийх уулзалтуудаа хийх ёстой. Бусад хүмүүсийг дагуулж явж байгаа нь бол давуу байдал

үүсгэж байгаа хэрэг мөн. Хуулийн цоорхой ашиглаж байгаа хэрэг мөн. Ийм учраас бас ёс зүйтэй байж энэ хуулиа зүгээр яг өөртөө явуулах нь зүйтэй гэж.

Тэгээд эцсийн байдлаар бид нар энэ дунд суудлын шийдвэрийг хүлээн авахгүй, эсэргүүцэж байна гээд буцаачихаар яг нэг хуулийн бас ийм юу гэдэг юм бэ дээ цаад болохгүй байгаа асуудал нь юу юм бэ гэхээр Цэцийн дээр хөх тэнгэр гэдэг шиг их суудлын шийдвэрээрээ Цэц эцсийн байдлаар ямар нэгэн маргаангүйгээр шууд энэ асуудлыг шийдвэрлэх боломжтой учраас Улсын Их Хурлын гишүүд хуулиа өөрчлөх боломж нь байхгүй болчих юм байна.

Ийм учраас хуулийнхаа энэ боломжийг ашиглаад хэдийгээр бид нар дэмжихгүй байгаа ч гэсэн энэ шийдвэрийг нь аваад, хуульдаа зохих өөрчлөлтүүдийг нь хийх ёстой болж байгаа юм. Ийм учраас энэ Байнгын хороо дээр унасан байгаа асуудлуудыг эргэж сэргээж буюу дэмжээгүйг дэмжихгүй байж, эргээд Улсын Их Хурлын гишүүд бүрэн эрхээ хадгалж, хуульдаа өөрчлөлт оруулж энэ яриад байгаа асуудлыг бас цэгцлэх нь зүйтэй юм гэсэн ийм саналтай байна.

Д.Амарбаясгалан: Хүрэлбаатарын Баасанжаргал гишүүн асуулт асууж, үг хэлье.

Х.Баасанжаргал: Би бол энэ Үндсэн хуулийн цэцийн энэ шийдвэрийг бид нар хүлээж авах ёстой гэж үзэж байгаа. Тэгээд Цэцийн шийдвэрийн гол үндэслэл бол Их Хурлын гишүүн гэдгээрээ хэт давуу эрх эдлээд байна гээд.

Түрүүн Пүрэвдорж гишүүн өөрийнхөө тайланг хөтөлбөртэй хамт хэвлүүлж тараасан гээд л. Гэтэл тэр үе чинь мөрийн хөтөлбөр биш, энэ чинь зөвхөн тайлан тараахыг л уг нь зөвшөөрөөд байгаа шүү дээ. Гэтэл ингээд л манай гишүүд хөтөлбөр энэ тэрээ нэмээд л, өөрсдийгөө танилцуулаад, сурталчилгаагаа хийгээд тайлан тарааж байгаа нэрийдлээр сурталчилгаагаа хийгээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ чинь одоогийн энэ 126-д олгож байгаа давуу эрх хэдий боловч дахиад үүний цаана өрсөлдөх зуу зуун нэр дэвшигч нарт маш том сул талыг үүсгээд байгаа. Тэгээд энэ чинь өөрөө хүний эрхийн зөрчил мөн.

Тийм учраас манай гишүүд энэ дээр бас гишүүн гэдэг утгаараа биш, дараа нь 2028 оноо бодох гэдэг утгаараа биш, Үндсэн хуульд заасан хүний эрхийн асуудлаа бодож бас шийдвэр гаргаасай гэж хүсэж байна.

Тэгэхээр Байнгын хороодын гаргасан шийдвэрийг хүлээж авахгүй байх ёстой гэж бодож байна.

Д.Амарбаясгалан: Энхтайваны Бат-Амгалан гишүүн асуулт асууж, үг хэлье.

Э.Бат-Амгалан: Асуулт алга. Санал байгаа. Нэгэнт Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар ийм дүгнэлт гараад, Улсын Их Хурал дээр бид нар хэлэлцээд байж байна. Ер нь яах вэ, Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийг бид нар хүлээж авсан тохиолдолд энэ Улсын Их Хурлын гишүүд бүр эсрэгээрээ улам их давуу эрхтэй болно гэдгийг манай гишүүд бас ойлгох хэрэгтэй гэж бодоод байгаа юм. Яагаад вэ гэхээр Үндсэн хуулийн 23.2-т Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацааг зааж өгсөн байгаа. Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр Их Хурлын гишүүний хугацаа эхэлнэ. Мөн дараагийн парламентын гишүүд сонгогдсоноор хугацаа дуусаж байгаа. Тэгээд энэ хоорондох хугацааг Улсын

Их Хурлын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.26-д Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд иргэд сонгогчдод тайлан, уулзалт бүх зүйл нь нээлттэй харагдаж байгаа юм. Тэгэхээр энийг нэг логиктой ойлгохоор энэ Цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн 41.9, 44.6-г бид нар хүлээж авснаараа нөгөө талдаа энэ Үндсэн хуульд заасан Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь хэрэгжээд ирэхээр бид нар энэ заалт байхгүй болсон ч гэсэн Их Хурлын тухай хуулиараа, Үндсэн хуулиараа Улсын Их Хурлын гишүүд нь бүр их давуу талтай болж байгааг бас ойлгох ёстой.

Гэхдээ одоо ингээд хэрвээ бид нар энийг хүлээж авахгүй ингээд явуулчих юм бол Үндсэн хуулийн Их суудлаараа бас хэлэлцэнэ. Ингээд асуудал гарах юм бол ар араасаа маргаанууд дагуулаад ирнэ. Улсын Их Хурлын гишүүд нь ийм давуу талтай болчихсон юм байна шүү дээ гээд. Тийм учраас Байнгын хорооноос гаргасан энэ саналыг бас дэмжиж, бид нар энэ асуудалд хандах нь зүйтэй гэж ингэж бодож байгаа юм.

Д.Амарбаясгалан: Тэгэхээр чинь Бат-Амгалан гишүүний хэлж байгаа бол Цэцийн дүгнэлтийг хүлээж авъя гэдэг агуулгаар хэлээд байна тээ. Хүлээж авъя. Байнгын хорооноос чинь бол хүлээж авахгүй гэсэн дүгнэлт орж ирж байгаа шүү дээ. Тэгэхээр тэрийг бид дэмжихгүй байх ёстой л гэсэн агуулгаар хэлж байна гэсэн үг тийм үү. Шинэбаярын Бямбасүрэн гишүүн асуулт асууж, үг хэлье.

Ш.Бямбасүрэн: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Би бол энэ цэцийн дунд суудлын дүгнэлтийг бол хүлээж авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Ер нь бол шударга ёсны зарчмын л асуудал ярьж байгаа. Сонгууль тэгш гараанаас гарах л асуудлыг бид нар ярьж байгаа гэсэн үг. Манай зарим гишүүдийн хэлж байгаагаар бол тайлангаа тавихгүй бол бараг сонгогчид нь танихгүй юм шиг юм яриад байх юм. Энэ 4 жилийн хугацаанд, 3,5 жилийн хугацаанд хэн нь хэн бэ гэдгийг Монголын ард түмэн, сонгогчид чинь бол хангалттай сайн харчихна. Тэр дээр ингээд ахиж баахан тараах материал тараагаад, өнгөтэй аягүй гоё үнэтэй тийм гоё сэтгүүлүүд хэвлээд ингээд тараагаад явах нь бол шударга ёсонд нийцэхгүй.

Тэгээд мэдэх эрхийн асуудал бас зарим хүмүүс ярьж байна. Энэ мэдэх эрхтэй ямар ч холбоогүй. Хэрвээ үнэхээр мэдэх эрхийн тухай ярих гээд байгаа бол бид нар хориглосон заалтаа бас бүр аваад хаячих ёстой. Тэгж байж бид нар бүгдээрээ өөрийгөө таниулах ажлаа нийтэд нээлттэйгээр, чөлөөтэй олгочих ёстой юм байгаа юм. Угаасаа хуулиар юм тараах, амлалт өгөх бол угаасаа хориотой байгаа шүү дээ. Тэгэхээр тэр мэдэх эрхийн хүрээнд ярьж байгаа бол тэр хориглосон заалтаа бүүр аваад хаячих хэрэгтэй.

Тэгэхээр гишүүд минь шударга ёсны талд байж бас Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж авах нь зүйтэй гэсэн үгийг хэлье.

Д.Амарбаясгалан: Үг хэллээ. Одсүрэнгийн Номинчимэг гишүүн асуулт асууж, үг хэлье.

О.Номинчимэг: Энэ маргаанд миний бие Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон. Мэтгэлцээнд оролцсон байгаа. Тэгээд бичгээр үндэслэлүүдийг хүлээж аваад, уншаад, ерөнхийдөө цэцийн дүгнэлт маань жоохон учир дутагдалтай гарчээ гэж харж байгаа. Ялангуяа энэ дүгнэлт хэрвээ биелэх юм

ямар үр дагавар гарах вэ гэдэг дээр нэлээн учир дутагдалтай дүгнэлт гарсан байна гээд.

Тэр юу вэ гэхээр яг одоо манай гишүүдийн хөндөж байгаа, ер нь бол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хугацаа байгаа. Үндсэн хууль дээр болон Улсын Их Хурал дээр бүрэн эрхийн буюу 4 жилийн хугацаандаа иргэд, олон нийтдээ мэдээллээ хүргэх үүрэгтэй.

Сая бас Цэцийн гишүүн маань энд танилцуулгаа хийж байна. Ер нь бол эрх зүйн хувьд Улсын Их Хурлын гишүүн, энгийн иргэн 2 өөр субъектүүд, өөр статустай субъектүүд боловч сонгуулийн жил эхлэхээр энэ бол адилхан байх ёстой гээд. Тэгээд энэ дээр бол нөгөө Цэцийн гишүүд маань Улсын Их Хурлын гишүүн дараагийн сонгуульд нэр дэвших гэж байгаа Улсын Их Хурлын гишүүн 2-ыг ерөнхийдөө бүгдийг нь ингээд хольсон байгаа. Тэгэхээр яах вэ, дараагийн сонгуульд нэр дэвших зорилгогүй Улсын Их Хурлын гишүүний хувьд иргэд олон нийтдээ хийсэн тайлангаа тавиад, уулзалтаа хийх энэ эрхийг ч гэсэн ерөнхийдөө хязгаарлаж байгаа.

2 дугаарт энэ асуудлыг харах юм бол түрүүн бас ярьж байсан. Бусад улс төрийн албан тушаалтнуудын асуудлыг тэгвэл яах вэ гэдэг асуудал энэ цэцийн хурлын үеэр мэтгэлцээн дээр гарсан. Энэ асуудал дээр ерөөсөө хариулт бол цэцийн дүгнэлт дээр байхгүй байсан. Тэгэхээр яах вэ, энэ Улсын Их Хурлын тухай хуулийн 2 зүйл, заалтыг тус бүр нь Үндсэн хуулийн 4 зүйл, заалтыг зөрчсөн байна гээд шийдсэн байгаа.

Нөгөө талдаа яг манай Эрдэнэболд гишүүний хэлж байгаа шиг энэ Улсын Их Хурлын гишүүн тайлангаа тавих боломжийг нээсэн энэ заалт нь өөрөө тодорхой биш, шалгуур байхгүй байгаа нь бусад зарим улс төрчдийн хувьд үүнийг буруугаар ашиглаж, сонгогчдыг өөртөө татах ийм эрсдэлүүдийг үнэхээр дагуулж байгаа нь үнэн. Тэгээд өөрийнхөө сонгогдсон биш тойрогт тойрог томорсноор очоод тайлангаа тараадаг. Пүрэвдорж гишүүн бол өөрөө бүр хэлж байна тээ. Тайлантайгаа хамт мөрийн хөтөлбөрөө тараадаг гээд. Мөрийн хөтөлбөр бол жинхэнэ сонгуульд нэр дэвшигчийн сонгуулийн компанит ажил, сурталчилгааны хугацаа эхэлсний дараа тараах ёстой юмыг тайландаа нэгтгэж тарааж байна. Ингэснээр сурталчилгаагаа ерөнхийдөө хийгээд эхэлчихсэн байна гэдэг ийм асуудлууд бол үнэхээр тавигдаж байгаа. Тэгээд үүний гол асуудал нь юу байна гэхээр энэ хөндөөд байгаа зүйл, заалтууд маань өөрөө тодорхой бус байна.

Улсын Их Хурлын гишүүн үнэхээр тайлангаа тавьж болох ч тайлангийн агуулга нь ямар байх юм, яагаад яачих юм бол Улсын Их Хурлын сонгуулийн сурталчилгааны агуулга руу явах юм. Юу хийж болох юм. Ганцаараа очиж болох юм уу эсвэл өөр горилогчийг ингээд дагуулж очоод танилцуулаад байж болох юм уу гэдэг юм ерөөсөө байхгүй байгаа учраас энэ цэцийн маргаанд мэдээлэл гаргах юм уу ерөөсөө байхгүй байгаа учраас энэ цэцийн маргаанд мэдээлэл гаргагчдын зүгээс ч гэсэн энийг л тодорхой болгоод өгөөч ээ, тайлангаа тавих нь зүй ёсны хэрэг юм. Гэхдээ тайландаа үнэхээр Улсын Их Хурлын гишүүний хувиар хийсэн ажлаараа л хязгаарлаач ээ, битгий сонгуулийн сурталчилгааны агуулгыг оруулаач ээ гээд үүнийхээ дагуу сонгуулийн сурталчилгаагаа хийгээч ээ гэдэг асуудлыг тавьж байгаа юм.

Тэгэхээр яах вэ, миний хувьд энэ үндэслэлүүдээс нь тодорхой буюу зөвхөн энэ хууль, зүйл заалт маань тодорхой бус байна. Ийм учраас Үндсэн хуулийн бас хуулиа боловсронгуй болгох шаардлагатай байна гэж харж байгаа. Тэгэхээр өнөөдөр бас чуулганд сууж байгаа Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ хэлэхэд Байнгын хороон дээр 8 санал хураалт явсан. 8 санал хураалт нь 2 зүйл заалтын тус бүр Үндсэн хуулийн 4 зүйл заалтыг зөрчсөн гэсэн ийм санал хураалт байсан.

Тэгэхээр ялангуяа 1 болон 5 дугаар санал хураалтыг бид нар Байнгын хорооныхоо санал, дүгнэлтийг дэмжихгүй буюу Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн авч, энийгээ бас хууль тогтоомжоо боловсронгуй болгоё. Харин 2, 3, 4 .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Номинчимэг гишүүнд 1 минут нэмж өгье.

О.Номинчимэг: 2, 3, 4, 6, 7, 8 дугаар асуудал буюу энийг бол албан тушаалаар нь ялгаварласан байна ч гэдэг юм уу, Үндсэн хуулийн энэ зөрчлийг бол бид нар хүлээж авах боломжгүй юм. Хэрвээ энэ үндэслэлээр бид нар бас энэ Цэцийн шийдвэрийг хүлээгээд авчих юм бол бид нарын хувьд нөгөө сонгуулийн компанит ажил, сонгуулийн сурталчилгааны хугацаа гэдэг юмны утга учир алдагдчих юм байна. Бүх иргэд ерөнхийдөө ажлын тайлан тараагаад, ингээд сонгуулийн сурталчилгааны маягийн уулзалтууд хийгээд ирэх юм бол бид нарын хувьд сонгуулийн сурталчилгааг 18 хоногт хийнэ гэсэн энэ хугацаа ямар ч утгагүй. Харин ч сонгууль маань их удаан үргэлжилдэг. Компанит ажлаа их удаан хийдэг, санхүүжилт их гардаг. Ийм байдал руу шилжих эрсдэлтэй байгаа юм. Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүддээ Байнгын хорооны саналын 1, 5 дугаар саналыг дэмжихгүй, Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжихгүй байж унагаж өгөөд, бусад саналыг дэмжиж өгнө үү гэдгийг уриалж байна.

Д.Амарбаясгалан: Ганбатын Очирбат гишүүн асуулт асууж, үг хэлье. Их хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ Үндсэн хуулийн дунд суудлын дүгнэлтийг бол хүлээж авах ёстой гэж бодож байгаа. Түрүүн Номинчимэг гишүүн бас хэлж байна. Ялангуяа тэр 5, 1-ийг хүлээж авахгүй бол болохгүй. Энэ яг хүний эрхтэй холбоотой асар том асуудлыг хөнддөг. Сонгууль болдог, сонгууль болохоор тухайн нөхцөл байдалд эрх барьж байгаа нам нь ямар нэгэн байдлаар шахалт хаалт хийж байгаад зөвхөн өөрийгөө таниулах ийм үйл ажиллагаа явуулдаг. Ялангуяа 2020 оны сонгууль дээр бол энэ бол бүр илт явсан шүү дээ. Ковидын үе гэж байгаад Их Хурлын гишүүд нь бүрэн эрхийнхээ хүрээнд очоод иргэдтэйгээ уулзаад болоод байдаг. Нөгөө сөрөг хүчнээс явж байгаа юм уу. Тэр шинээр нэр дэвших гэж байгаа бие даагч нар, бусад намаас нэр дэвшиж байгаа хүмүүст ямар ч боломжгүй болгоод хаачихдаг. Дээрээс нь төрийн бүтцээ ашигладаг. Их Хурлын гишүүн гэдэг ийм бүрэн эрхээрээ далайлгаж төрийн албан хаагч нартай нийлж иргэдийг олноор нь цуглуулж уулздаг. Ийм юм бол үнэхээр хавтгайрдаг.

Тэгэхээр Үндсэн хуулийн дунд суудлын дүгнэлт бол үнэхээр бас бодитой. Их хурал хүлээж авах ёстой гэж харж байгаа юм. Ер нь цаашдаа ч гэсэн Үндсэн хууль дээр заасан энэ хүний эрхийнхээ зүйл заалтуудыг манай Их Хурлын гишүүд бас нэлээн сайн тогтож уншиж байхгүй бол тэр сонгох, сонгогдох эрхэнд бол 4 жил болдог сонгууль болгоноор халддаг шүү. Ялангуяа залуучуудад, тэр эмэгтэйчүүдэд, тэр тухайн салбараараа мэргэшчихсэн байгаа мэргэжилтнүүдэд ингээд сонгогдох эрхийг нь боогоод хаачихдаг. Яах ч арга байхгүй. Яваад очдог алхаад хөөрхий өөрийгөө танилцуулах гээд явдаг. Их Хурлын гишүүд нь би гишүүн гэдэг бүрэн

эрхээрээ далайлгаад төрийн бүтцийг ашиглаад уулзалтуудыг хийж, өөрийгөө таниулж, илүү давуу байдлыг илүү эрхийг эдэлдэг. Тэгэхээр Их Хурлын гишүүддээ Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг бас хүлээж авах ёстой. Энэ дээр бас байр сууриа ялангуяа кнопоо дарах ёстой гэдэг байр суурийг илэрхийлж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Баатархүү сайд асуулт асууж, үг хэлье.

Ц.Баатархүү: Их Хурлын гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Өнөөдрийн Үндсэн хуулийн цэцийн оруулж ирж байгаа асуудал бол их тодорхой бус байдлыг үүсгэхээр байна. Шууд буцаахаар тодорхой бус байдал дахиад үргэлжлэхээр байна. Тийм учраас хүлээж аваад, үнэхээр энэ сонгогч иргэдийн эрхийг хамгаалж байна уу гэдэг дээр Их Хурал ажлын хэсэг байгуулаад, хуулийн зохицуулалтаа илүү тодорхой болгоод ингээд хэлэлцээд явах тэр үүд хаалгыг бол нээсэн нь зөв юм байна гэж бодож байна. Би Номинчимэг гишүүний саналтай бол санал давхцаж байна.

Энэ Үндсэн хуулийнхаа логик үзэл санааг өөрөө зөрчсөн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гэж бодож байгаа. Улсын Их Хурлын гишүүн бол дараагийн Улсын Их Хурлын гишүүн тангараг өргөснөөр эрх нь дуусдаг. Тэр эрх рүү тэр Үндсэн хуулийнхаа заалтыг, зарчмыг зөрчсөн ийм дүгнэлт байгаа учраас сонгогчийн эрх, шинээр нэр дэвшиж байгаа энэ хүмүүсийн шударга ёсны зарчмыг бодож энэ зохицуулалтыг нарийн болгох үүднээс бол хүлээгээд авчихъя гэдэг ийм санал руу бол очиж байна. Хүлээж аваад тодорхой болгох дээр 2 зүйлийг бид нар хатуу Улсын Их Хурлын гишүүд нэмж тусгах хэрэгтэй 2 зүйл байгаа юм. Зарчмын асуудал.

1 дүгээрт Улсын Их Хурлын гишүүд тайлан цаасаар байна уу, цахимаар байна уу тараах байх. Иргэддээ хүргэх ийм үүрэгтэй.

2 дугаарт хамгийн гол нь тухайн орон нутгийн төрийн албаны бүтцийг хэрхэн уялдуулах юм бэ. Улсын Их Хурлын гишүүд төрийн энэ бүтцийг сонгуульд ашиглаж болохгүй тухай энэ заалтыг их тодорхой болгож өгөх хэрэгтэй байгаа юм.

2 дугаарт нь ерөөсөө энэ Монгол төрийг тунгалаг болгоё гэвэл, сонгогчдоо сонгох эрхэд нь халдахгүй байя гэвэл, шударга ёсны зарчим тогтооё гэвэл сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнууд бүхий л цаг хугацаандаа өөрийн нэртэй гарын бэлэг өгөхийг бол бүрэн хориглох хэрэгтэй. Өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд бид нар бүгдээрээ өөрийн нэртэй гарын бэлэг өгч байгаа явдал нь сонгогчийн эрхэд бүдүүлгээр халдаж байгаа, шинээр сонгогдох гэж байгаа хүний эрхийг зөрчсөн үйлдэл учраас энэ бүх сонгуультай холбоотой зохицуулалтыг илүү нарийн болгохын тулд 2 зүйлийг илүү тодорхой болгох хэрэгтэй. Улсын Их Хурлын гишүүд тайлан дээрээ төрийн албаны бүтцийг огт ашиглахгүй байх. Сонгогдсон болон томилогдсон албан тушаалтнууд гарын бэлгийг зөвхөн сонгуулийн жил биш бүхий л хугацаанд иргэдэд өгөхгүй байх гэдгийг хатуу хуульчилж өгөх ёстой гэсэн ийм л зарчмын саналыг оруулж байна. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа. Санал хураалт. Байнгын хороодын саналаар санал хураана.

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж

заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт. 3 гишүүн дэмжиж, 2.7 хувиар санал дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 13 гишүүн дэмжиж, 11,8 хувиар санал дэмжигдсэнгүй.

Цэцийн дүгнэлтийг хүлээж авч байна гэсэн үг.

3.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшвэл хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 9 гишүүн буюу 8,2 хувиар санал дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9 дэх хэсэгт “Монгол Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвших бол хийсэн ажлын тайлангаа энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө тарааж болох бөгөөд үүнийг сонгуулийн сурталчилгааны материалд тооцохгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 дэх заалтад төрийн байгууллагад сонгох сонгогдох эрхтэй гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 6 гишүүн буюу 5,5 хувиар санал дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. 5 гишүүн буюу 4,5 хувиар санал дэмжигдлээ.

6.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 8 гишүүн буюу 7,3 хувиар санал дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 7 гишүүн буюу 6,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.6 дахь хэсэгт “Энэ хуульд заасан нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа танилцуулах зорилгоор сонгогчидтой хийсэн уулзалт болон энэ хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “ ... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...” гэснийг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн Байнгын хороодын саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 7 гишүүн буюу 6,4 хувиар санал дэмжигдсэнгүй.

Байнгын хороодын саналаар санал хурааж дууслаа. Ингээд Байнгын хороодын саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжээгүй тул “Үндсэн хуулийн цэцийн 2025 оны 03 дугаар дүгнэлтийн тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталсанд тооцлоо. Нэг ёсондоо Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээж авлаа.

15.36 цаг.

Дараагийн асуудалд оръё. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 оны гүйцэтгэлийн тайлан болон Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг хэлэлцэнэ.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх асуудлаар танилцуулга хийх сайд байна уу. Таны чиг үүрэг биш шүү дээ. Чиг үүргийн сайд байхгүй учраас маргаашийн чуулган хүртэл хойшлууллаа.

15.37 цаг.

Дараагийн асуудалд оръё.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулна.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Очирбатын Амгаланбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Маргааш энэ асуудал хэлэлцэхэд Учрал сайд аа, Засгийн газрын үндсэн чиглэл хэлэлцэж байгаа учраас бүх сайд нар байх ёстой. Бүх сайд нар ерөөсөө 2, 3 асуудал дээр л байх үүрэгтэй байдаг. Тийм ээ. Төсөв, үндсэн чиглэл, төсвийн хүрээ зэрэг асуудлууд дээр. Тэгэхээр маргааш өглөө 10 цагаас энэ чуулганаар хэлэлцэж эхэлнэ.

Амгаланбаатар гишүүн.

О.Амгаланбаатар: Улсын Их Хурлын дарга, гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн миний бие Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2025 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Амьтны тухай хууль 2012 онд батлагдсанаар бүс нутгийн амьтны зүйлийн бүрдэл, тэдгээрийн тархац, нөөцийн судалгааг хийж, зэрлэг амьтны мэдээллийн санг тогтмол шинэчилсний үндсэн дээр зэрлэг амьтныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн байдаг.

Монгол Улсад 1986 оны байдлаар 30 гаруй мянган чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан гэж Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтдийн гаргасан судалгаанд дурджээ. 1986 оноос хойш улсын хэмжээнд чонон талаар нарийвчилсан судалсан судалгаа мэдээлэл огт байхгүй байна.

Амьтны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу иргэн зохих төлбөр төлж сумын Засаг даргаас олгосон эрхийн бичгийн дагуу агнуурын ховор амьтнаас бусад амьтныг өөрийн ахуйн зориулалтаар агнаж, барьж болох бөгөөд тус эрхийн бичигт иргэний овог, нэр, агнах, барих, агнуурын амьтны зүйл, тоо, агнах, барих хугацаа, газар, төлбөр хураамжийн хэмжээг нарийвчлан заадаг. Тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.2-т заасны дагуу чоно агнах, барих зөвшөөрлийг 5 хүртэл хоногийн хугацаатай олгодог олгодог байна. Мөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3, 17 дугаар зүйлийн 17.1.2-т тус тус заасны дагуу Засгийн газрын 2023 оны “Амьтны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолыг үндэслэн тухайн амьтны экологи, эдийн засгийн үнэлгээний 20 хувиар буюу 226 мянган төгрөгөөр зөвшөөрлийн хураамжийг 2 хувь буюу 22.600 төгрөгөөр тус тус тооцож, 1 чоно агнах зөвшөөрөл 248.600 төгрөгийн үнэлгээтэй байна.

Тулгамдаж буй асуудлыг тодорхойлбол.

1 дүгээрт агнах зөвшөөрлийн бичиг нь 5 хүртэлх хоногийн хугацаатай байдаг. Хэрвээ тухайн хугацаандаа ан хийж чадахгүй бол дахин сум орж зөвшөөрөл авах шаардлага үүсдэг тул төлбөр төлж зөвшөөрөл авах сонирхол байдаггүй байна.

2 дугаарт хуульд заасны дагуу ан агнах зөвшөөрөл авахад шаардлагатай бичиг баримт бүрдүүлэх нь малчин иргэдийн хувьд хүндрэлтэй байдаг бөгөөд тухайлбал, ангийн буу өмчлөх, эзэмших зөвшөөрөл авахад хүндрэлтэй байдаг.

3 дугаарт малчид өмнө нь чоно ихэссэн тохиолдолд нийлж чоно агнадаг байсан бол чоно агнасан хүнийг 1 хониор шагнадаг байсан бол одоо малчин иргэд зөвшөөрөлгүй чоно агнавал өндөр торгууль төлөх учраас амь нас мал сүргээ чононоос хэрхэн хамгаалахаа мэдэхгүй байна. Торгууль, нөхөн төлбөрийн хэмжээ Засгийн газрын 2023 оны “ Амьтны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн батлах тухай” 260 дугаар тогтоолын хавсралтад заасны дагуу чонон экологи, эдийн засгийн үнэлгээг 1 сая 130 мянган төгрөгөөр тогтоосон байна. Зөвшөөрөлгүй чоно агнасан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу торгууль төлөхөөс гадна Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.4 дэх хэсэгт заасны дагуу 2 сая 260 мянган төгрөгийн нөхөн төлбөр төлдөг.

Иймд Амьтны тухай хуулийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.7 дахь хэсгийг нэмэхээр тусгаж байгаа болно. Үүнд:

25.7.амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн 25.1 дэх заалт хамаарахгүй буюу иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, хуулийн этгээд тусгай болон үйлдвэрийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл авч гэрээ байгуулна гэсэн заалт хамаарахгүй байхаар тусгалаа.

Уг хуулийн төслийн хүрээнд иргэд, олон нийтийн дунд хэлэлцүүлэг явуулж, 5 мянга гаруй иргэд гарын үсэг зуруулж, ирүүлсэн болно.

Иймд уг хуулийн төслийг дэмжиж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Төслүүдийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хорооны дарга Буланы Бейсен уншиж танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Бейсен: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Амгаланбаатараас 2025 оны 3 сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Амьтны тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Хууль санаачлагч Амьтны тухай хуулиар чоно агнахад заавал хураамж төлж зөвшөөрөл авах ёстой гэж хуульчилсан нь өргөн нутаг дэвсгэрт нүүдлийн соёлтой амьдарч байгаа малчин иргэдийн бодит амьдралд нийцэхгүй байгаа, гэнэтийн үед буюу амь нас, мал сүргээ хамгаалах шаардлага үүссэн тохиолдолд зөвшөөрөл

авалгүй чоно агнавал малчин иргэд торгууль, төлбөр төлөх Монгол Улсын Үндсэн хуульд заасан амьд явах, өмчтэй байх эрх зөрчигдөж байгаа гэж үзжээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Наранбаатар чоно болон бусад зэрлэг амьтанд бариулж хүний амь нас хохирсон, гэмтсэн талаарх судалгаа статистик байгаа эсэх, мал сүрэг нь хохирсон тохиолдолд нөхөн төлбөр авах боломж, хохирлыг хэрхэн барагдуулах талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ хуулийн төслийн талаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баримталж байгаа бодлогын талаар, уг хуулийн төслийг дагаж Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орох эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал өргөн мэдүүлсэн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, хэлэлцүүлгийн шатад хууль хоорондын нийцэл, уялдааг хангах, агнуур зүй, зохион байгуулалтын тоон мэдээллийг улс бүс нутгийн хэмжээнд гаргаж, тусгай зөвшөөрлөөр агнах амьтдын тоо толгойг зохистой түвшинд байлгах асуудалд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын баримталж байгаа бодлого чиглэлийн талаар тодрууллаа.

Улсын Их Хурлын гишүүн Аубакир туурга, хар галуу, тарвага, янгир зэрэг бусад амьтдыг нутагшуулах, тоо толгойг зохистой түвшинд байлгах асуудалд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны баримталж байгаа бодлогын талаар, малчид, иргэдэд зэрлэг амьтдаас амь нас, мал сүргээ хамгаалах талаар холбогдох мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулагддаг эсэх, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхбат чоно болон ирвэсийн тоо толгой нэмэгдсэн эсэх, байгалийн тэнцвэрт байдал хангагдах зохистой түвшний талаар, чоно, ирвэст бариулж хүний амь нас хохирсон тохиолдолд авах арга хэмжээний талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн С.Замира хуулийн төслийг дэмжиж байгаагаа илэрхийлж, хэлэлцүүлгийн явцад төслийн зохицуулалтыг холбогдох бусад хуультай нийцүүлэх, хүний амь насанд хохирол учруулахаас сэргийлэх чоно болон бусад зэрлэг амьтны устгах гэсэн өөрчлөлтийг нэмэх санал хэлсэн болно.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 86,7 хувь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Д.Амарбаясгалан: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүн Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Одонтуяа сайд байж байна. Яамны төлөөлөл байна.

Улсын Их Хурлын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан намын бүлэг болон бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт асууж, хариулт авна. Нийт 8 гишүүн асуулт асуухаар нэр ирсэн байна. Бат-Өлзийн Бат-Эрдэнэ гишүүн алга

байна. Саруулсайханы Цэнгүүн гишүүн алга байна. Аюушийн Ариунзаяа гишүүн асуулт асууя.

А.Ариунзаяа: Хуулийн төслийг зарчмын хувьд бол дэмжиж байгаа. Амгаланбаатар гишүүнд баруун бүсээс сонгогдсон, зовлон жаргалыг нь мэдэж байгаа, яахын аргагүй тулгамдсан асуудал мөнөөс мөн учраас энэ асуудлыг Улсын Их Хуралд оруулж ирж байгаа.

1986 онд 30 мянга гаруй чоно 18 аймгийн нутаг дэвсгэрт тархсан байна гэдэг статистикийг Шинжлэх Ухааны Академийн Биологийн хүрээлэнгийн эрдэмтэд гаргасан байдаг. Түүнээс хойш ер нь Монгол Улсад хэчнээн чоно байгаа юм бэ гэдгийгээ ер нь мэдэхгүй байдалд хүрсэн. Ер нь энэ чоно агнахыг хориглосон шийдвэр яагаад гарсан юм бэ гэхээр устах хэмжээндээ хүрч, манай монголчууд агнаад байсантай л холбоотой. Ер нь энэ шийдвэрийг зогсоосон. Энэ шийдвэрийг гаргаж ан агнуурыг зогсоосон. Гэтэл нөгөө талдаа яг баруун бүсийн малчдын хотонд нь орж ирээд, бүр шалдан гараараа чоно алсан тухай мэдээ мэдээллийг бид нар сошиалаас хүртэл харж байсан. Тэгэхээр ийм хэмжээнд орсон. Ер нь Монголын төр ингээд 2 талдаа л туйлширсан байдлаар ийм шийдвэрийг гаргаад байдаг нь бол нэг талдаа туйлын харамсалтай. Энэ нээлттэй болгож байгаа байдлаар эргээд нөгөө ан агнуур маань ямар нэгэн хязгаарлалтгүй явчих вий дээ гэдэг болгоомжлол бол байгаа юм. Яагаад гэхээр энэ бол манай Монголчуудын сэтгэлгээтэй бас их холбоотой.

Нөгөө хийморь гэдэг амьтантай бас холбоотой болоод явчихдаг. Одоог хүртэл чоно харвал хийморьтой, чоно агнавал бүр ч их аз хийморьтой гэдэг ийм ойлголт явсаар байгаад хэн их азтай хийморьтой байна тэр нь чоно агнаад, тэрэнтэйгээ зургаа авхуулаад хот дундуур машин дээрээ тавьж давхилцаад, сүүлдээ бүр вертолётгоор дээрээс нь агнаад ийм замбараагүй байдал ер нь үүсэж байгаа юм л даа. Тэгээд тэр хийморь гэдэг амьтан бол зөвхөн эрчүүдэд л бас байдаг юм гэнэ лээ. Тэгээд эрчүүдийн аз хийморийг чоно агнаж байж л сэргээдэг ийм Монголчуудын тийм бичигдээгүй ч юм уу, бичигдсэн ч юм уу тийм ойлголт яваад байдаг.

Тэгэхээр яг нээлттэй болгож байгаа маань эргээд нөгөө энэ эрчүүдийн маань аз хийморио сэргээх гэсэн энэ шуналд автчих вий дээ. Хэрхэн яаж энийг зохицуулах вэ. Тэгээд энэ чоно, тарвага агнаж болно, болохгүй гэдгийг Улсын Их Хурал дээрээ хүртэл яриад байгаа нь жоохон ичгэвтэр асуудал мөн л дөө. Тэгээд энэ асуудал дээр үр дагаврыг нь хэдүүлээ бас яаж харах вэ. Энэ залуучуудын юу гэдэг юм, очоод Дулмаа гуай, Дорж гуай настай учраас өөрөө агнаж чадаагүй, намайг гуйсан юм гээд агнаад байх вий гэсэн ийм болгоомжлол бол байна. Тэрнээс биш ер нь зарчмын хувьд дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: Очирбатын Амгаланбаатар гишүүн хариулт өгье.

О.Амгаланбаатар: Ер нь 1 дүгээрт энэ 1986 оноос хойш судалгаа хийгдээгүй нь харамсалтай. Тэгээд Монголд яагаад энэ чоно ховордсон юм бэ. Яагаад Монголчууд тэгж их хэмжээгээр чоноо алсан юм бэ гэдэг нь 2000 оноос авхуулаад 2012 он хүртэл 12 жилийн хугацаанд хил дээр буюу Хятадууд маш их хэмжээний чоныг өндөр үнэтэй авсан юм байна лээ. Хил дээр 1 чоно 2 сая төгрөг хүрээд, энэ бол арилжааны зориулалттай тийм хядлага болчихсон юм байна лээ. Баруун аймгуудад бас л тухайн үед тэмээ маш ихээр хорогдож байсан. Яагаад тэмээ маш

ихээр хорогдсон гэхээр тэмээний тавхайг Хятадууд бас маш их өндөр үнээр аваад эхэлсэн чинь тэмээний тавхайг Хятад руу зарах гээд бас л тухайн үед ийм асуудал үүсэж байсан юм. Тэгэхээр энэ бол яг тэр нөгөө хөлдөөсөн чоно хил дээр их үнэд хүрсэнтэй холбоотойгоор ингээд энэ чонын хядлага бол явагдсан юм байна лээ. Түүнээс биш одоо бас энэ хүмүүсийн ухамсар өөр болчихсон хийморио сэргээж тэр чоно алах асуудал бол бас яг тухайн үедээ ч гэсэн тийм хавтгай байгаагүй юм байна лээ. Зүгээр үнэтэй учраас л ингэж алаад байсан юм байна лээ гэдгийг хэлье.

Тэгэхээр энэ бол тийм үр дагавар нь бол хавтгайрахгүй гэдэгт бас итгэлтэй байна. Дээр нь болохоор одоо ингээд хүмүүсийн хувьд амь нас, эрүүл мэндээ, мал сүргээ хамгаалахын тулд ингэж чоно алахгүй бол энийг чинь тэгээд малд явж байгаа хүн буу аваад явж байхад сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа нар нь чи ан хийх гээд буу аваад явж байна шүү дээ гэж хэлээд л бууг нь хураагаад аваад явчихдаг. Нөгөө бууныхаа араас хөөцөлдөөд бас л энэ хөдөөгийн ард иргэдийн хувьд маш их хүндрэл учирч байгаа юм.

Гэтэл нөгөө талд нь ард иргэдийн хувьд бага насны хүүхдээ хүртэл эмэгтэй хүмүүсийг хүртэл ингээд хонь малдаа явуулж чадахгүй маш их хүндрэл учирч байгаа юм. Тэгэхээр хүндрэл талаас нь авч үзэх юм бол өнөөдрийн хууль хэрэгжсэнээрээ саяын тэр нөгөө сөрөг үр дагавраасаа илүү том давуу тал үүсэх юм гэж ингэж харж байна. Тэгээд хэлсэн саналуудыг бас хүлээж авлаа.

Д.Амарбаясгалан: Цэндийн Сандаг-Очир гишүүн алга байна. Хассуурийн Ганхуяг гишүүн алга байна. Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Наранцэцэгийн Алтаншагай гишүүн асуулт асууя.

Н.Алтаншагай: Өдрийн мэнд хүргэе. Хууль шинэчлэлд орох гэж байх шиг байна. Тэгээд саарал чонын тоо толгойтой холбоотой асуудал яригдлаа. Тэгээд 40 жилийн өмнө судалгаа хийгдсэн ийм л дүр зурагтай байгаа юм. Тэгээд Байгаль орчны яам энэ дээр яг ямар бодит арга хэмжээ авах юм бэ. Говийн болон энэ зүүн аймгуудын нутгаар энэ талын саарал чоно ер нь үзэгдэхээ байсан шүү дээ. Энэ дээр ямар бодлого баримтлах юм. Цаашдаа энэ чонын тоо толгойгоо яаж хамгаалах юм. Экологийн бас сүйрэл авчрах магадлалтай шүү дээ. Чоно чинь өөрөө энэ байгаль дээр байгаа зэрлэг амьтны бас мууг нь барьж, ан ав хийж байгалийн нэг ёсны цэвэрлэгч ийм үүрэг гүйцэтгэж байгаа амьтан. Нүүдэлчин малчид маань бол энэ байгаль эх дэлхийтэйгээ, ан амьтантайгаа дасан зохицоод бас яваад өдий хүрсэн. Энэ чонын тоо толгой сүүлийн үед өссөн гээд байгаа нь энэ ковидтой холбоотой байж магадгүй. Яг хөл хорионы үе бас 2 жил бараг л байсан. Энэ үед бол нөгөө чоно устгал, гөлөг суйлах энэ ажиллагаанууд нь зогссон байх магадлалтай. Үүнээс болоод өссөн байж магадгүй. Тэгэхээр энэ эргээд хяналтаа яаж тавих юм. Хэт задгайд нь тавиад, энэ амьтны аймгийг хоморголон устгах энэ байдал руугаа орчих вий дээ. Энэ дээр яг бодит яг ямар арга хэмжээ авах вэ, нөхцөл байдал нь ямар байгаа юм. Энэ чонын тоо толгойг яг бас нэг эргэж харах, судалгаа шинжилгээ, эрдэм шинжилгээний чиглэлээр ажил хийх нь бас зөв байх. Саарал чонын нөгөө говь хээрийн чонын тоо толгой дээр бас яг тийм бодит мэдээлэл өгөөч. Баярлалаа.

Д.Амарбаясгалан: Салдангийн Одонтуяа сайд хариулт өгье.

С.Одонтуяа: Алтаншагай гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр 2004 онд Биологийн хүрээлэнгийн судалгаагаар бол 10 мянга орчим байна гэсэн ийм судалгаа байдаг. Тэгэхээр тантай ямар зүйл дээр бас санал нийлж байна вэ гэхээр

энэ саарал чоно бол өөрөө Дэлхийн байгаль хамгаалах холбооны улаан дансны үнэлгээгээр бол ер нь ховордож болзошгүй гэж үнэлэгдсэн байгаа. Гэхдээ ер нь бол чоно өөрөө энэ байгальд эко балансыг барьдаг ийм амьтан. Зарим оронд бол яах вэ, чоноо бас нэлээд хядаад, сүүлдээ чоно ховордоод, өөр улсаас авчирч ингэж үржүүлж байгаа ийм орнууд ч хүртэл байдаг.

Амгаланбаатар гишүүний хувьд бол зөвхөн 1 заалт дээр л ойлгомжтой болгож өгч байгаа юм. Өөрөөр хэлбэл амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор чоно агнасан бол энэ хуулийн заалт хамаарахгүй гэж. Тэгэхээр энэ бол өөрөө Эрүүгийн хуульд ч байдаг.

Гэхдээ ер нь Монгол улсын Засгийн газраас сая гарсан шийдвэр юу вэ гэхээр ард иргэдэд энэ бүх хууль тогтоомжийг маш ойлгомжтой болгох хэрэгтэй гэсэн. Энийг үндэслэж бол энэ заалтыг дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл маш олон хууль байдаг. Энийг бол ард иргэд мэддэггүй. 1 багийн иргэн бас мэдэхгүйгээс болж энэ дээр асуудлууд бол үүсэж байгаа гэдэг ийм гомдол бол намайг болон манай гишүүдийг хөдөө орон нутгаар явахаар маш их гарч байгаа юм. Зүгээр яаж энийгээ зохицуулах вэ гэхээр энэ дээр бол орон нутгийн засаг захиргаа бүх тоо толгойгоо үргэлж Байгаль орчны яаманд ингээд жил болгон тоо толгой, сүргийн бүтэц ямар байна, тоо толгой ямар байна, ихдэж байна уу, багадаж байна уу энэ мэдээллээ өгдөг. Энийг үндэслэж бол бид бүх арга хэмжээнүүдийг авдаг байгаа.

Тийм учраас энэ дээр бол тэр олноор нь ингэж хядаад, өмнө нь байсан шиг машинаар хөөгөөд л хэдэн 10-аар нь алж байсан энэ асуудал гарах юм бол өөрөө энэ хуулийн хариуцлагатай байгаа. Ийм асуудал гэвэл энэ заалтаар хөндөөгүй гэж үзэж байгаа учраас энэ заалтыг нь бол дэмжиж байгаа. Өөрөөр хэлбэл зөвхөн амь нас, мал сүргээ хамгаалах зорилгоор гэдэг.

Тэгээд би хууль санаачлагчид бас юу гэж хэлж байгаа вэ гэхээр энэ олон хуулиуд байгаа. Эрүүгийн хууль, Зөвшөөрлийн хууль, Ан агнуурын хууль, Амьтны тухай хууль гээд энэ бүх хуулиудыг бүгдийг нь хооронд нь уялдуулж, уялдаа холбоог нь бас яг сайн хангахгүй бол яг агнана гэдэг нь өөрөө бол ийм урьдчилж бэлдсэн ийм зүйлийг хэлдэг. Тэгэхээр энэ үг үсэг дээрээ хэлэлцэх хэсгийн дараа ажлын хэсэг дээр маш сайн ажиллаарай гэдгийг л хэлж байгаа. Тийм учраас энэ заалт бол өөрөө зөвхөн энэ тодорхой яг айл өрхөд заасан ийм заалт байгаа юм. Өмнө нь бол .../минут дуусав/

Д.Амарбаясгалан: Батын Батбаатар гишүүн алга байна. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай намын бүлгийг төлөөлж бүлэгт харьяалагдаагүй гишүүдээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлж үг хэлнэ. 2 гишүүний нэр ирсэн байна. Сандагийн Бямбацогт гишүүн үг хэлнэ.

С.Бямбацогт: Амгаланбаатар гишүүний санаачилсан хуулийг дэмжиж байгаа. Монголчууд нүүдэлчин соёлтой ард түмэн. Нүүдлийн өв соёлыг маань тээж байгаа ганц хүмүүс бол малчид. Мөн бас Монгол Улсын хязгаар нутгийг эзэнтэй байлгаж, хязгаар нутагтаа эзэн болж байгаа хүмүүс бол малчид. Малчдын амьжиргааны гол эх үүсвэр бол мал сүрэг. Тийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуульд мал сүрэг

төрийн хамгаалалтад байна гээд заачихсан. Гэвч бас малчдын гол амьжиргааны эх үүсвэр болсон мал сүргийг чоно гэдэг амьтан бол үндсэндээ маш олноор нь идэж, хядаж, амьжиргааны гол эх үүсвэрийг нь салгаж байгаа.

Зүүн болон говийн бүсэд бас чоно агнахгүй. Бусад аймагт нь агнаж болно гэсэн шийдвэр гаргасан Одонтуяа сайдад баярлаж байгаа. Яагаад гэвэл зүүн болон говийн бүсэд хурдан буутай, хурдан унаатай хүмүүст чоно агнаад дуусчихсан, ховордчихсон. Хангайн бүсэд, Алтайн бүсэд, Баруун бүсэд, Хангайн бүсэд үнэхээр чоно бол дийлдэхээ больсон. Бод мал үндсэндээ төл авахаа больсон. Үхрээс, адуунаас тийм үү ерөөсөө хээр явж байдаг. Хээр ерөөсөө төлийг нь бол ерөөсөө тэр тугал, бяруу, унага, даага бүгдийг нь чоно идчихдэг. Тэр байтугай хотонд нь орж ирээд хонь, ямааг нь барьдаг. Үүнийг алъя гэхээр сумын Засаг даргаас зөвшөөрөл ав гэдэг. Чоно алах сургалтад суу гэдэг. Дээрээс нь 240 мянган төгрөг төл гэдэг. Ингэхгүй агнах юм бол эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн Эрүүгийн хуультай. Ийм байдлаар үндсэндээ бол чоно алсан малчин маань, мал сүргээ хамгаалсан малчин маань амьжиргааны эх үүсвэрт нь дайсан болсон чоныг устгасныхаа төлөө эрүүгийн хариуцлага хүлээх болдог. Үүнээс болоод алж чадахаа больчихсон. Үүнээс болоод чоно өсчихсөн. Тийм болохоор үүнийг л цэгцэлье гэсэн хуулийг Амгаланбаатар гишүүн оруулж ирж гэж ойлгож байгаа. Энэ бол зайлшгүй бас бид бүхэн дэмжээд батлах ёстой хууль. Ингэж бас зохицуулалт хийхгүй бол, төр бодлогын дэмжлэг үзүүлэхгүй бол болохгүй байгаад байгаа юм.

Хэт туйлширсан шийдвэр гаргадаг. Эсвэл болно, эсвэл болохгүй. Зарим бүсдээ болно. Зарим бүсдээ болохгүй. Сая Алтаншагай гишүүн хэлж байна. Зүүн бүс, Говийн бүс чоногүй болчихсон шүү дээ гэж. Тэнд хориглоё. Баруун бүс, Хангайн бүсэд нь чөлөөтэй агная. Тоо толгой нь хэт цөөрөөд ирэх юм бол хязгаарлая. Ийм л уян хатан мэдрэмжтэй шийдвэрийг энэ төр гаргадаг баймаар байгаа юм. Гаргадаг баймаар байгаа юм.

Өнөөдрөөс бууны асуудал байж байгаа. Нөгөө чоно агная нь хуучин оросын буутай. Винтов, Лос юу гэдэг юм Карбен гээд. Тэр буунууд нь хуучирчихсан, онохоо больчихсон, цэцгүй болчихсон. Шинээр буу худалдаж авъя гэхээр бас л тусгай зөвшөөрөлтэй компаниудыг хязгаарлаад буу маш өндөр үнэтэй борлодог. Америкт барууны орнууд 500 долларын буу Монголд 5 мянган доллараар зардаг. Сум нь 10, 20 мянган төгрөгийн үнэтэй. Тийм үнэтэй бууг малчид худалдаж авах бололцоо байдаггүй. Тийм үнэтэй сумаар чоноо алж чаддаггүй. Тийм болохоор бас юу гэдэг юм бууг хямдруулах, сумыг хямдруулах чөлөөтэй бас сургалтад суугаад агнадаг болох энэ талд нь анхаарах ёстой. Яг үүнтэй адилхан байгалийн нөөц ашигласны төлбөр гэж байж байгаа. Тэр эдийн засаг, экологийн үнэлгээ гэдгээр хулганаас, үлийн цагаан оготноос агнах юм бол төлбөр авна гэсэн хуультай. Одоо Ховдод Хар ус нуурын ондатр, заарт харх гээд амьтан агная гэхээр маш олон болчихсон. 50 хэдэн аралтай байсан. 20 хэдхэн аралтай болтлоо арлуудыг идээд дуусгачихсан.

Тэрийг агная гэхээр заавал мөнгө төл гэдэг. 5 мянган төгрөг. 5 мянган төгрөг төлөөд агнах хүн байдаггүй. Тэр нь ингээд нөгөө Хар ус нуурын шагшуургатай арлуудыг бүгдийг нь идээд цөөлөөд байдаг. Энийг Байгаль орчны яам бас иймэрхүү юманд мэдрэмжтэй л хандмаар байгаа юм л даа. Гэрийн хулгана нь алахад төлбөр төлж агнах хуультай байгаа өнөөдөр. Өлийн цагаан оготно устгахад мөнгө төлөх хуультай байгаа шүү. Тэр Хар ус нуурын ондатрыг алахад бас 5 мянган төгрөг төлөх ийм хуультай байгаад байгаа юм. Ийм л юмнуудыг маш хурдан мэдрэмжтэй шийдээд энэ чоно агнах хуультай адилхан шийдмээр байгаа юм. Ийм юман дээр

бас манай Одонтуяа гишүүн, Байгаль орчны сайд маань бас илүү бас санаачилгатай ажиллаасай. Сая бас зүүн бүсээс бусад говийн бүсээс бусад газар чоно агнахыг зөвшөөрнө гэдэг чиглэл өгсөнтэй адилхан энэ асуудалд бас мэдрэмжтэй хандаасай гэж танаас бас хүсье. Хуулийг дэмжиж байгаа.

Д.Амарбаясгалан: 16 цагаас орон даяар “Гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохио”-оор ажиллах дадлага сургуулилтын хүрээнд Төрийн ордонд анхааруулах дуут дохио сая 3 удаа дуугарсан байна.

Тэгэхээр “Жанжин Сүхбаатар”-ын талбайд цуглах тул өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаан хаасныг мэдэгдье. Маргааш чуулганы хуралдаан үргэлжилж явна.

16.02 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ